

БҮС НУТГИЙН УЛААН ДАНСНЫ ЦУВРАЛ

# МОНГОЛ ОРНЫ ХОЁР НУТАГТАН, МӨЛХӨГЧДИЙН УЛААН ДАНС БА ХАМГААЛАЛ

(Хоёрдугаар хэвлэл)



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ





Захиалагч:



БАЙГАЛЬ ОРЧИН,  
УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Санхүүжүүлэн зохион байгуулж, гүйцэтгэсэн:



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН  
(WWF)-ИЙН МОНГОЛ ДАХЬ  
ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН  
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛЫН  
ИХ СУРГУУЛЬ

# МОНГОЛ ОРНЫ ХОЁР НУТАГТАН, МӨЛХӨГЧДИЙН УЛААН ДАНС БА ХАМГААЛАЛ

## Хоёрдугаар хэвлэл

**Боть 15, 16**



## БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



**Захиалсан:** БАЙГАЛЬ ОРЧИН, УУР  
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

**Санхүүжүүлсэн:** ДЭЛХИЙН БАЙГАЛЬ  
ХАМГААЛАХ САН (WWF)-ИЙН МОНГОЛ  
ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

**Гүйцэтгэсэн:** МОНГОЛ УЛСЫН  
ИХ СУРГУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ

**Зохиогчид:** Х.Тэрбиш, М.Мөнхбаатар,  
П.Золжаргал, П.Эрдэнэтүшиг, Ж.Гүррагчаа,  
М.Бүрнээ

### РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

**Ерөнхий редактор:** Х.Тэрбиш,  
С.Гомбобаатар, Д.Батболд, Ц.Уранчимэг

**Бүлгийн редактор:** Х.Мөнхбаяр,  
Г.Онолрагчаа, Г.Довчиндорж,  
С.Гомбобаатар

**Зүйлийн тархцын зургийг боловсруулсан:**  
Х.Тэрбиш, С.Гомбобаатар, Ж.Номундарь

**Хавтас, хавчуулга зураг** © Х.Тэрбиш,  
ДБХС/Б.Гантулга

ДАА: 590  
ННА: 28.6  
М-692  
ISBN: 978-9919-9323-5-0

### Зүйлүүдийн үнэлгээ хийсэн:

Х.Тэрбиш	1.2, 1.3, 1.4, 2.3, 2.5, 3.1, 3.2, 3.3, 3.6, 3.15, 3.16, 4.2, 4.9
М.Мөнхбаатар	2.4, 2.6, 2.7, 3.8, 3.13, 3.14, 4.1, 4.3, 4.6
П.Золжаргал	2.2, 3.9, 3.10, 3.11, 3.12, 4.7, 4.8
П.Эрдэнэтүшиг	2.1, 3.4, 3.5, 3.7, 4.4, 4.5
Ж.Гүррагчаа	2.4, 3.1, 3.2, 3.3, 3.15, 3.16, 4.2, 4.6, 4.9
М.Бүрнээ	2.3, 2.5, 3.1, 3.2, 3.15, 3.16, 4.2, 4.4
С.Гомбобаатар	2.4, 3.2
Г.Довчиндорж	2.3, 3.1, 3.3
Г.Онолрагчаа	2.5, 4.4, 4.5
С.Пүрэвсүрэн	1.1

### Зохиогчийн эрх:

© Монгол Улсын Их Сургууль  
© Монгол Улсын Боловсролын Их Сургууль  
© Байгаль Орчин, Уур Амьсгалын  
Өөрчлөлтийн Яам  
© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-  
ийн Монгол дахь хөтөлбөрийн газар  
©2025. Зохиогчийн эрх хуулиар  
хамгаалагдсан бөгөөд уг номыг худалдан  
борлуулахыг хориглоно. Сургалт, судалгаа,  
хамгаалал, сурталчилгааны чиглэлээр  
ашгийн бус зорилгоор эх сурвалжийг  
дурдаж, талархал илэрхийлэн ашиглаж  
болох ба зураг, газрын зураг, бичвэр, номын  
агуулга, бүтцийг олон нийтийн сүлжээнд  
байршуулах, онлайн болон оффлайн  
аппликейшн, бусад платформд ашиглах,  
зөвлөх үйлчилгээ болон бусад зорилгоор  
ашиглахдаа зохиогч, зохиогчийн эрх бүхий  
байгууллагуудаас ашиглах эсэх тухай  
зөвшөөрөл заавал авна. Дээрх болон  
бусад зорилгоор ашиглуулах, зохиогчийн  
эрхийн асуудлыг оролцогч талууд хамтран  
шийдвэрлэнэ.



### Гэрэл зураг:

Б.Гантулга © (Зулзагалагч гүрвэл)

Д.Лхагвасүрэн © (Толбот гүрвэл)

М.Мөнхбаатар © (Шивэр гүлмэр, Модны  
мэлхий, Дорнодын мэлхий, Зүүнгарын  
гүрвэл)

Х.Мөнхбаяр © (Нарийн могой)

Х.Тэрбиш © (Монгол бах (эр, эм),  
Зүүнгарын бах (эр, эм), Шивэр мэлхий,  
Шөвгөр мэлхий, Нохой гүрвэл, Төмөр  
гүрвэл, Говийн махир хуруут гүрвэл,  
Замба гүрвэл, Цоохор хонин гүрвэл,  
Тойрмын хонин гүрвэл, Кулагины хонин  
гүрвэл, Могой гүрвэл, Говийн гүрвэл,  
Монгол гүрвэл, Загалт гүрвэл, Гавшгай  
гүрвэл (эр, эм), Тэмээн сүүл могой, Усны  
могой, Рашааны могой, Сум могой,  
Бамбай хоншоорт могой, Эгэл загалмайт  
могой)

Kim Huyn-tae © (Дорнодын бамбай  
хоншоорт могой)

A.Siching © (Хар мөрний цариг могой)

### Түлхүүр үг:

Монгол, хоёр нутагтан, мөлхөгч, улаан  
данс, хамгааллын төлөвлөгөө, үнэлгээ,  
ховордлын зэрэглэл, хамгаалал.

### Эшлэх загвар:

Тэрбиш, Х., Мөнхбаяр, Х., Мөнхбаатар,  
М., Золжаргал, П., Эрдэнэтүшиг, П.,  
Гүррагчаа, Ж., Бүрнээ, М., Довчиндорж,  
Г., Онолрагчаа, Г., Пүрэвсүрэн, С.,  
Гомбобаатар, С. (эмхэтгэсэн). 2025.

*Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн  
улаан данс ба хамгаалал.* Хоёрдугаар  
хэвлэл. Боть 15, 16. Монгол Улсын Их  
Сургууль, Монгол Улсын Боловсролын  
Их Сургууль, Дэлхийн Байгаль Хамгаалах  
Сангийн Монгол дахь хөтөлбөрийн

газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын  
Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот,  
Монгол Улс.

### Хандах хаяг:

Монгол Улсын Их Сургуулийн ШУС-ийн  
Байгалийн Ухааны Салбарын Биологийн  
тэнхим.

Проф. С.Гомбобаатар.

Утас: +976 – 90112244

Цахим хаяг: [gomboo@num.edu.mn](mailto:gomboo@num.edu.mn)

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн  
Монгол дахь хөтөлбөрийн газар

Хаяг: Интер оффис, Амарын

гудамж-4, 8-р хороо, СБД,

Улаанбаатар хот 14200

Утас: +(976)-11-311659

Цахим шуудан: [info@wwf.mn](mailto:info@wwf.mn)

Вэбсайт: <https://mongolia.panda.org>

Энэ ном нь цөөн тоогоор хэвлэгдсэн  
бөгөөд цахим хувилбарыг Дэлхийн байгаль  
хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь  
хөтөлбөрийн газрын дээрх вэбсайтаас үнэ  
төлбөргүй татаж авна уу.

# ГАРЧИГ

УДИРТГАЛ .....	05
ӨМНӨХ ҮГ .....	07
ТАЛАРХАЛ.....	08

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ ХОЁР НУТАГТАН, МӨЛХӨГЧДИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ХОВОРДЛЫН ШАЛТГААН..... 10

1.1. Танилцуулга ба тайлбар .....	11
1.2. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн өнөөгийн төлөв байдал.	24
1.3. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн тархалт.....	26
1.4. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн ховордлын шалтгаан ....	28

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ ХОЁР НУТАГТНЫ АНГИЙН АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ..... 29

2.1. Шивэр гүлмэр .....	30
2.2. Монгол бах .....	32
2.3. Зүүнгарын бах .....	34
2.4. Модны мэлхий.....	37
2.5. Шивэр мэлхий .....	40
2.6. Дорнодын мэлхий .....	42
2.7. Шөвгөр мэлхий.....	45

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ МӨЛХӨГЧДИЙН АНГИЙН ГҮРВЭЛИЙН САЛБАР БАГИЙН АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ..... 47

3.1. Нохой гүрвэл .....	48
3.2. Төмөр гүрвэл .....	50
3.3. Говийн махир хуруут гүрвэл.....	52
3.4. Замба гүрвэл .....	54
3.5. Цоохор хонин гүрвэл.....	56

3.6. Тойрмын хонин гүрвэл .....	58
3.7. Кулагинь хонин гүрвэл.....	60
3.8. Өргөслөг хонин гүрвэл .....	62
3.9. Могой гүрвэл .....	64
3.10. Говийн гүрвэл .....	66
3.11. Монгол гүрвэл.....	68
3.12. Толбот гүрвэл .....	70
3.13. Загалт гүрвэл .....	72
3.14. Зүүнгарын гүрвэл .....	74
3.15. Гавшгай гүрвэл.....	76
3.16. Зулзагалагч гүрвэл .....	78

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ МӨЛХӨГЧДИЙН АНГИЙН МОГОЙН САЛБАР БАГИЙН АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ..... 80

4.1. Тэмээн сүүл могой .....	81
4.2. Усны могой .....	83
4.3. Нарийн могой .....	85
4.4. Рашааны могой.....	87
4.5. Хар мөрний цариг могой .....	89
4.6. Сум могой.....	91
4.7. Бамбай хоншоорт могой .....	93
4.8. Дорнодын бамбай хоншоорт могой....	95
4.9. Эгэл загалмайт могой.....	97

## ЭШ ТАТСАН БҮТЭЭЛ .....

## ХАВСРАЛТ..... 110

**Хавсралт 1.** Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны ховордлын зэрэглэлийн үнэлгээний товч тайлбар (IUCN, 2012) ... 110

**Хавсралт 2.** Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлүүдийн үнэлгээний нэгтгэл..... 112

**Хавсралт 3.** Монгол оронд тэмдэглэгдэх боломжтой хоёр нутагтан, мөлхөгчид..... 114

## УДИРТГАЛ

---

Монгол орны Сибирийн тайгаас Төв Азийн хээр, говь цөл хүртэлх өндөр уулсын өвөрмөц систем, ус, намгархаг газар зэрэг экосистемийн нэн олон янз байдал нь 144 зүйл хөхтөн, 519 зүйл шувуу, 25 зүйл мөлхөгч, 7 зүйл хоёр нутагтан, 80 зүйл загас амьдрахад тааламжтай орчныг бүрдүүлдэг.

Дэлхий нийтээр биологийн зүйл бүрийн байгаль хамгаалал, нийгэм, эдийн засаг, соёлын үнэ цэнийг тогтоох, тухайн экологийн систем дэх оролцоог тодруулах, шинжлэх ухааны өгөгдлийг цуглуулах, нэгтгэх, ховордлын зэрэглэлийг тогтоох, хамгааллын төлөвлөгөө боловсруулах зэрэг олон асуудлыг шийдвэрлэх зорилгоор Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны зэрэглэл, шалгуураар зүйлийг үнэлэх ажлыг Монгол Улсад Дэлхийн банк, Нидерландын Вант Улсын санхүүгийн дэмжлэг, Байгаль Орчны Яамны бодлогын дэмжлэг, Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн техникийн туслалцаатай Степ форвард хөтөлбөр, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль (МУИС), Шинжлэх ухааны академи (ШУА), Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС), Хөдөө Аж Ахуйн Их Сургууль (ХААИС) болон бусад төрийн ба төрийн бус байгууллагын эрдэмтэн, судлаачид хамтран 2006 онд боловсруулж, улмаар тэр жилдээ Монгол орны загас, хоёр нутагтан, мөлхөгч, хөхтөн амьтад, 2011 онд шувууны Улаан данс болон хамгааллын төлөвлөгөөг гаргасан нь Азидаа нугаламт амьтдыг үнэлсэн анхны улс орон болж байлаа. Үүнээс хойш Монгол орны гуурст ба гуурсгүй ургамлын Улаан данс, хамгааллын төлөвлөгөөг боловсруулж, олны хүртээл болгосон билээ.

Монгол орны биологийн зүйлийн үнэлгээний үр дүнг эрдэмтэн судлаачид, төрийн захиргааны төв байгууллагатай хамтран Монгол Улсын хууль болон бодлого, эрх зүйн баримт бичигт тусгахаар ажиллаж, улмаар ургамал, амьтны чиглэлийн шинээр батлагдах хууль, тогтоомжийн төсөлд тусгалаа олж буй нь энэ чиглэлээр ажилладаг эрдэмтэн судлаачид болон төрийн захиргааны төв байгууллагын хамтын ажиллагааны чухал үр дүн гэж үзэж байна.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод “Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулах зорилго тавин, амьтан, ургамлын Улаан дансыг шинэчлэн шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлэхээр” үйл ажиллагаагаа төлөвлөсөн нь бидний хамтын ажиллагааны нэгэн чухал үр дүн мөн.

Хүн төрөлхтний олон талт үйл ажиллагаанаас улбаалсан уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, бохирдол, хууль бус агнуур, амьдрах орчны алдагдал зэрэг хүчин зүйлсээс хамааран биологийн олон зүйлүүд устах, мөхөх эрсдэлд орж байна. Монгол орны амьтны зүйлүүдийг улаан дансны зэрэглэл, шалгуураар дахин үнэлэх хугацаа 6 жил байдаг ч санхүүгийн хүндрэл бэрхшээлээс хамааран 19 жилийн дараа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олон талуудыг оролцож, дэмжиж хамтран ажиллахыг уриалж, бүхий л нөөц бололцоогоороо дэмжлэг үзүүлж ажилласан бол Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар санхүүгийн дэмжлэг үзүүлэхийн сацуу энэ багц ажлын олон үе шатны зохион байгуулалт, бүтээлийн эцсийн үр дүнг хүлээлгэн өгөх ажлыг хариуцаж, МУИС, ШУА, МУБИС, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын эрдэмтэн,

судлаачидтай хамтран Монгол орны 76 зүйл загас, 7 зүйл хоёр нутагтан, 25 зүйл мөлхөгчид, 140 зүйл хөхтөн амьтдын зүйлүүдийн үнэлгээг шинэчлэн хийж, анги тус бүрээр нэгтгэсэн бүтээлийг гаргаж байна.

Байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлтэй, экологийн хувьд нэн эмзэг Монгол орны амьтны Улаан дансны үнэлгээг шинэчлэн боловсруулах ажил нь зүйлүүдийн ховордлын шалтгааныг тодорхойлж, цаашид амьтны талаар төрөөс баримтлах бодлого, хууль эрх зүйн зохицуулалтыг улам бүр боловсронгуй болгох, сайжруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх арга замыг тодорхойлж, ялангуяа ховордлын зэрэглэлтэй амьтдын талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэгийг олон нийтэд хүргэх, хүн ба байгаль зэрэгцэн оршиход бүх талын оролцоо чухал болохыг ойлгуулахад эдгээр бүтээл нь үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэ бүтээлийг дэмжиж, хамтран ажилласан эрдэмтэн, судлаачид, байгууллага, хамт олонд тусгайлан ТАЛАРХАЛ илгээв.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД  
Б.БАТБААТАР

## ӨМНӨХ ҮГ

---

Хоёр нутагтан, мөлхөгчид бол амьтны аймгийн ангилал зүйн хувьд Хөвчтөний хүрээ (Chordata), Сээр нуруутны салбар хүрээ (Vertebrata), Дөрвөн мөчтөний дээд анги (Tetraopoda), Хоёр нутагтан (Amphibia), Мөлхөгчид (Reptilia) хэмээх бие даасан хоёр анги юм. Сээр нуруутны салбар хүрээнд 65,000 зүйлийн амьтан багтдаг. Манай дэлхийд эдүгээ үед 7,300 гаруй зүйл хоёр нутагтан, 10,000 гаруй зүйл мөлхөгчид амьдарч байна. Эрин цагийн эрхээр маш олон зүйлийн хоёр нутагтан, мөлхөгчид мөхжээ. Хоёр нутагтан, мөлхөгчид нь амьтны аймгийн түүхэн хувьсах хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн, өөрөөсөө өндөр хөгжилтэй хуурай газрын сээр нуруутан амьтдыг үүсгэсэн амьтны аймгийн ангилал зүйн дээд нэгж юм. Амьтны аймгийн ангилал зүйн дагуу сээр нуруутан амьтдыг таван үндсэн анги болгож үздэг, тэдгээрийн хоёр нь хоёр нутагтан (Amphibia), мөлхөгчид (Reptilia) билээ.

Манай орон эртний мөхсөн мөлхөгчдийн үлдэгдлээр асар баян. Аварга том үлэг гүрвэлийн чулуужсан яс, ялангуяа говь нутгаас элбэг олддог. Ийм олдвороор Монгол орон дэлхийд гайхагддаг.

Эдүгээ Монгол оронд 7 зүйлийн хоёр нутагтан, 25 зүйлийн мөлхөгчид тархсан байдгаас гадна, сүүлийн үеийн судалгаагаар шинэ зүйл, салбар зүйл нэмэгдэж байгаа билээ.

Хоёр нутагтан, мөлхөгчид бол өөрийн амьдрах орчиндоо дасан зохицсон, аюулаас шилжин зайлах чадваргүй, их эмзэг амьтад учир тэдгээрийг хамгаалах асуудлыг өргөн олон түмэнд сурталчлахад энэ Улаан дансны үнэлгээ чухал ач холбогдолтой гэдэгт итгэлтэй байна.

Хоёр нутагтан, мөлхөгчид бол бусад сээр нуруутан амьтадтай харьцуулахад илүү эмзэг бүлэг амьтад юм. Энэ нь 1 дүгээрт, тэд ангиараа реликт амьтад мөн. Учир нь тэдний холын өвөг болох амьтад аль диван галавын үед цэцэглэн хөгжиж байсан. Одоогийн хоёр нутагтан, мөлхөгчид бол тэдгээрийн өчүүхэн хэсэг нь юм. Монгол орны говь, цөл нутгийн мезозойн үеийн хурдаснаас эртний аварга үлэг гүрвэлийн чулуужсан яс элбэг олддог нь үүний баталгаа мөн. Хоёрдугаарт, эх газрын эрс тэс уур амьсгалтай Монгол нутагт орших хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн олон янз байдал дэвсгэр нутгийнхаа хэмжээтэй харьцуулахад дэндүү хомс. Гуравдугаарт, хоёр нутагтан, мөлхөгчдийн аж ахуйн холбогдол бага учир тэр бүр хүмүүсийн анхаарлыг татдаггүй. Гэтэл хоёр нутагтан, мөлхөгчид нь Монгол орны биологийн олон янз байдлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг, экосистемийн бодис энергийн солилцоонд чухал байр эзэлдэг амьтны аймгийн биеэ даасан хоёр ангийн төлөөлөгчид билээ.

Орчин үед хоёр нутагтан, мөлхөгчдийг хамгаалах асуудал улам чухал болж байна. Учир нь тэдгээр нь ландшафтын бус, биотопын зүйлүүд болохоор гаднын нөлөөнд маш эмзэг, ялангуяа уул уурхайн үйлдвэрлэлийн явцад амьдрах орчныг нь эвдэж бусниулах, нуур, голын усыг бохирдуулах зэрэг хүний буруутай үйл ажиллагаанаас болж тоо толгойн хорогдон цөөрсөөр байна. Цаашид хоёр нутагтан, мөлхөгчдийн хамгааллын менежментийг сайжруулахад “Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн Улаан данс ба хамгаалал” бүтээл ач холбогдлоо өгөх нь дамжиггүй.

Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн Улаан данс ба хамгаалал бүтээлийг гаргах ажлыг зохион байгуулсан болон үнэлж, хянахад идэвхтэй оролцсон гадаад, дотоодын эрдэмтэн, мэргэжилтэн нарт гүн талархал илэрхийлж байна.

МОНГОЛ УЛСЫН АРДЫН БАГШ,  
ПРОФЕССОР Х.МӨНХБАЯР

## ТАЛАРХАЛ

---

Энэхүү “Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн Улаан данс ба хамгаалал” ном нь Монголын хоёр нутагтан, мөлхөгч судлаачдын биет оролцоо, дэмжлэггүйгээр гарах боломжгүй бөгөөд олон судлаачдын хамтын бүтээл юм.

Тус бүтээлд өөрсдийн олон жилийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, оюун ухаан, мэдлэг туршлага, үнэт цагаа сэтгэл харамгүй зарцуулж өмнөх болоод өнөө үеийн эрдэмтэн, судлаачдын судалгааны ажил, бүтээлүүдийг шүүн судалж, зүйлийн бичиглэлийг боловсруулан, үнэлгээг хийж, нэгтгэн танилцуулсан профессор Х.Мөнхбаяр, профессор Х.Тэрбиш, профессор М.Мөнхбаатар, доктор П.Золжаргал, доктор П.Эрдэнэтүшиг, доктор Г.Онолпрагчаа, магистр Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, Г.Довчиндорж нарт болон уг бүтээлийг мэргэжлийн хувьд хянан засварласан профессор Х.Мөнхбаяр, доктор Г.Онолпрагчаа, магистр Г.Довчиндорж, улаан дансны зэрэглэл, шалгуур, үнэлгээ, бичвэрийг хянасан профессор С.Гомбобаатар, доктор Д.Өсөжжаргал нарт онцгойлон талархал илэрхийлье.

Мөн Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлүүдийн тархцын зургийг боловсруулах нарийн чимхлүүр ажлыг нягт нямбай гүйцэтгэсэн Ж.Номундарь, профессор С.Гомбобаатар, доктор Д.Өсөжжаргал нарт баярлалаа.

Өөрсдийн олон жилийн хүч, хөдөлмөр, үнэт цагаа зарцуулан, сэтгэл оюунаа чилээн байж буулгасан, олдоц ховортой зүйлүүдийн гэрэл зургаа харамгүй хандивласан Х.Тэрбиш, М.Мөнхбаатар, Х.Мөнхбаяр, Д.Лхагвасүрэн, Kim Huyn-tae, A.Sichting нарт их баярлалаа.

Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн Улаан данс ба хамгаалал бүтээлийг дэмжин ажилласан дараах байгууллагууд болон хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Үүнд:

**Монгол Улсын Их Сургууль (МУИС).** Төрийн болон төрийн бус байгууллагын эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагааг хангаж, удирдан зохион байгуулсан, тус төслийн удирдагч МУИС-ийн Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор, профессор С.Гомбобаатар, энэ төслийн хүрээнд шат дараатай нэгдсэн болоод бүлгийн уулзалт, хэлэлцүүлгүүдийг амжилттай зохион байгуулж, арга аргачлал, заавар мэдээллээр хангаж, зүйлийн бичвэрүүдийг нэгтгэж, хянасан МУИС-ийн Биологийн тэнхимийн багш, доктор (Ph.D) Д.Өсөжжаргал, доктор (Ph.D) Д.Нарангарвуу, хоёр нутагтан, мөлхөгчдийн бүлгийг ахлан ажилласан профессор Х.Тэрбиш, уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах бүхий л боломжоор хангаж, хамтран ажилласан тус сургууль болон нэр бүхий тэнхимийн нийт хамт олонд,

**Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС).** Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийг Улаан дансны зэрэглэл, шалгуураар үнэлэх, хэлэлцэх, нэгтгэн боловсруулах бүхий л үе шатны үйл ажиллагааг дэмжиж, арвин их мэдлэг туршлагаа хуваалцаж, идэвхтэй оролцсон МУБИС-ийн Математик, байгалийн ухааны сургуулийн Биологийн тэнхимийн профессор Х.Мөнхбаяр, доктор П.Эрдэнэтүшиг, доктор Г.Онолпрагчаа, мөн тус МУБИС-ийн харьяа Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн захирал, профессор М.Мөнхбаатар, доктор П.Золжаргал, магистр Ж.Гүррагчаа болон тус сургуулийн нийт хамт олонд,

**Шинжлэх Ухааны Академи (ШУА).** Тус бүтээлд онцгой ач холбогдол өгч, эрдэмтэн, судлаач нараа өргөнөөр оролцуулж, хэлэлцүүлэг өрнүүлж, мэдлэг туршлагаа хуваалцан, идэвхтэй хамтран ажилласанд,

**Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN).** Уг номыг туурвихад шаардлагатай холбогдох мэдээ, материал, шалгуур болон мэдээллийн санг ашиглах боломж олгож, техникийн туслалцаа үзүүлсэнд,

**Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар.** Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийг Улаан дансны зэрэглэл, шалгуураар дахин үнэлж, хамгаалах арга хэмжээг шинэчлэн боловсруулах санаачилгыг гаргаж, 2012 оноос хойш хөрөнгө мөнгө босгох нөр их ажил дээр хичээнгүйлэн зүтгэж, тус ажлын санхүүжилтийг бий болгож, зохион байгуулсан тус хөтөлбөрийн газрын захирал Д.Батболд, Байгаль хамгааллын захирал Б.Чимэддорж, доктор Б.Гантулга, мөн тус бүтээлийг “Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн Улаан данс ба хамгаалал” хэмээн нэрийдэж энэ номын болон зүйлийн бичиглэлийн агуулга, чиглэлийг боловсруулах, нэгтгэн хянаж сайжруулах, хэвлэлд бэлтгэх зэргийг бүхий л үе шатанд хариуцан ажилласан зөвлөх С.Пүрэвсүрэн болон тус байгууллагын нийт хамт олонд тусгайлан талархсанаа илэрхийлье.

**Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам (БОУАӨЯ).** Монгол орны хоёр нутагтан, мөлхөгч амьтдыг улаан дансны зэрэглэл, шалгуураар дахин үнэлж, хамгаалах арга хэмжээг шинэчлэн боловсруулах ажлыг бодлогоор дэмжихийн сацуу цаг заваа зориулж, мэдлэг оюунаа чилээн олон талуудад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг уриалж, албан бичиг хүргүүлэх, уулзаж ярилцах, мөн ажлын ерөнхий чиглэлийг боловсруулан хүргүүлж захиалах, шаардлагатай баримт, материалаар хангах, санал солилцох зэргээр бүхий л үе шатанд удирдлагаар хангаж идэвхийлэн оролцож, нягт хамтран ажилласан БОУАӨЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг болон мэргэжилтэн Б.Хандармаа, тус яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын ахлах мэргэжилтэн Ж.Мөнхдөш, яамныхаа нийт хамт олонд гүн талархал илэрхийлье.



## **НЭГДҮГЭЭРБҮЛЭГ**

**МОНГОЛ ОРНЫ ХОЕР НУТАГТАН,  
МӨЛХӨГЧДИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ  
БАЙДАЛ. ХОВОРДЛЫН ШАЛТГААН**

## 1.1. ТАНИЛЦУУЛГА БА ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6.1-д “Байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилт”-ын 6.2-т “Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилт”-ын хүрээнд “Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэн шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ” хэмээн тусгаснаас гадна, Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр”-т биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах талаарх шийдвэр гаргагч, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, мөн биологийн олон янз байдлын нөөцийн талаарх шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан зохистой ашиглах болон хамгааллын бодлогыг бий болгон хэрэгжүүлэх, тогтвортой ашиглах нөхцөлийг хангах, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, ашиглах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлийг баримтлахаар тодорхой тусгасан.

Монгол Улс нь 2025 оны байдлаар байгаль орчныг хамгаалах чиглэлийн арван найман олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон байгаа бөгөөд тэдгээрээс дөрөв нь биологийн олон янз байдлыг хамгаалах, ялангуяа амьтны аймгийг хамгаалах, зүй зохистой ашиглахтай холбоотой гэрээ, конвенц байна. Үүнд “Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD)”-оор өнөө болон хойч үеийнхээ тусын тулд биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах явдлыг хэлэлцэн тохиролцсон бол “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-оор манай улс нь нутаг дэвсгэрийнхээ хилийн дотор амьдрах буюу нутгаар нь дамжин өнгөрч байгаа зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг ивээн хамгаалагч байх ёстойг хүлээн зөвшөөрч, “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-оор ус, намгархаг газар нь усны горим болон ургамал ба амьтны аймаг, ялангуяа усны шувуудын амьдрах орчны экологийн зохицуулагч болдог үндсэн үүрэгтэйг харгалзан үзэж усны шувууд улирлаар нүүх учир тэдгээрийг бусад нөөц баялгийн нэгэн адил үзэх ёстойг хүлээн зөвшөөрч, “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-оор зэрлэг амьтан, ургамлын аймаг нь энэ ертөнцийн байгалийн тогтолцооны орлуулшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдгээрийг хамгаалж өнөөгийн болоод хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээх, түүнчлэн зэрлэг амьтан, ургамлын зарим зүйлийг олон улсын хэмжээнд хэтрүүлэн ашиглах явдлыг зохицуулахад олон улсын хамтын ажиллагаа нэн шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч тус тус нэгдэн орж, олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээсэн байдаг.

Түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт байгаль орчныг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, багц хуулийн хэрэгжилтийг хангах, амьтан, ургамлын нөөцийг зохистой ашиглах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зэрэг зорилтуудыг тавьсан.

Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудтай хамтран Амьтны тухай хууль тогтоомжид болон “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийг хэрэгжүүлэх харилцааг зохицуулсан Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомжид удаа дараа нөлөөллийн шинжилгээ хийлгэж (2018; 2021), мөн “Монгол орны нэн ховор, ховор амьтад, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хэрэглээ, худалдаа ба хуулийн хариуцлага (2021)” зэрэг бүтээлээр дамжуулан амьтныг хамгаалах талаар холбогдох харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин нь

давхардал, хийдэл, зөрчилтэй бөгөөд эдгээрийг цаашид сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг тогтоож, холбогдох байгууллагуудад саналаа хүргүүлэв. Эдгээр ажлын үр дүн гарсаар байгаа бөгөөд тухайлбал, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2024 оны А/240 дүгээр тушаалаар Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын үндэсний Удирдан зохицуулах зөвлөлийн ажиллах журам болон Шинжлэх ухааны зөвлөлийн ажиллах журмууд батлагдан хэрэгжиж байна.

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2023 оны А/158 дугаар тушаалаар Амьтны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, улмаар Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн сайдын 2024 оны А/808 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулав. Амьтны тухай хуульд тодорхойлсон нэн ховор, ховор амьтдыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн шалгуур үзүүлэлтээр, мэргэжлийн эрдэмтэн, судлаачдын өргөн оролцоотойгоор үнэлэн тогтоож, тодорхой давтамжтайгаар (тухайлбал, 6 жил тутамд) үнэлгээг шинэчлэн хийх нь тулгамдсан асуудал болоод байна. Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яамнаас уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад шаардлагатай Монгол орны хөхтөн, мөлхөгч, хоёр нутагтан болон загасны Улаан данс (2006)-уудыг шинэчлэн боловсруулах, энэ хүрээнд амьтны зүйлүүдийн үнэлгээг дахин хийж, хамгаалах арга хэмжээг тодорхойлж, тэдгээр цуврал бүтээлүүдийг олны хүртээл болгохоор Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Аам (хуучнаар)-ны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын даргын 2024 оны 06/2375 тоот албан бичгээр тус багц ажлын ерөнхий чиглэлийг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газарт ирүүлснээр энэ ажлын хамтын ажиллагаа эхлэв.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагаар Монгол орны хөхтөн, мөлхөгч, хоёр нутагтан болон загасны зүйлүүдийг олон улсын улаан дансны шалгуураар үнэлж, хамгааллын арга хэмжээг боловсруулах багц ажлыг санхүүжүүлж, зохион байгуулсан бөгөөд олон талууд хамтран гүйцэтгэлээ. Анх 2006 онд Монгол орны хөхтөн, мөлхөгчид, хоёр нутагтан болон загасны зүйлүүдийн тархац, тоо толгой, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуураар үнэлж, хамгааллын төлөвлөгөөг боловсруулснаас хойш даруй 19 жил өнгөрсөн бөгөөд тухайн хугацаанд дээрх зүйлүүдийн тархац, тоо толгой, учирч буй аюул занал ихээхэн өөрчлөгдсөн нь тодорхой тул зүйлүүдийг дахин үнэлж, хамгаалах арга хэмжээг шинэчлэв.

Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан данс нь дэлхий дээрх амьтан, ургамлын зүйлүүдийн популяцийн нөхцөл байдлыг үнэлдэг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичиг юм (Baillie, Groombridge, 1996). Улаан данс нь ангилал зүйн хувьд өөр хоорондоо ялгаатай зүйлүүдийн устах эрсдэлийг үнэлэх чухал арга хэрэгсэл болсон төдийгүй ховордож буй зүйлд тавих анхаарлыг нэмэгдүүлэх, тэдгээрийг хамгаалахад нэн түрүүнд хийх шаардлагатай ажлыг тодорхойлох анхны арга хэмжээ болдог (Lamoreux *et al.*, 2003). Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуурыг олон улсын стандартыг хангасан гэдгийг хүлээн зөвшөөрч дэлхийн олон улс орнууд болон янз бүрийн байгууллагууд нийтээрээ ашиглаж байна (IUCN, 2001).

“Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн Улаан данс ба хамгаалал” бүтээлийн зүйлийн бичиглэлийн агуулгыг боловсруулахдаа, 2006 онд хэвлэгдсэн Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн Улаан данс болон Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл гэсэн хоёр бүтээлийн агуулгыг нэгтгэн оруулснаас гадна, зарим сэдвүүдийг нэмж, улам бүр баяжуулж нэлээд агууламжтай бүтээл болгосон. Үүнд:

**Ангилал зүй.** Тухайн зүйлийн монгол болон латин буюу шинжлэх ухааны нэр, мөн баг, овгийн монгол ба латин нэр, бас ижил нэр (хэрвээ тухайн зүйлийн латин, англи, монгол синоним нэр байгаа тохиолдолд таслалаар зааглаж оруулах г.м) зэргийг оруулав.

Ангилал зүйн тойм сэдэвт тухайн зүйлийн ангилал зүйд гарсан өөрчлөлтийг тоймлон бичсэн. Тухайлбал, салбар зүйлээс бие даасан зүйл болгон салгасан тухай баримт, бие даасан зүйлийг хэд хэдэн салбар зүйл болгон ялгасан тухай эсвэл тухайн зүйлийн монгол болон шинжлэх ухааны нэр өөрчлөгдсөн тохиолдолд тайлбарыг хадлаа.

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (хуучнаар)-аас Монгол Улсын Их Сургууль (МУИС), Шинжлэх Ухааны Академи (ШУА), төрийн ба төрийн бус байгууллагын эрдэмтэн, судлаачдын оролцоотой байгуулсан “Монгол орны Биологийн олон янз байдлын ангилал зүйн зөвлөл”-өөс нэгтгэн боловсруулж, улмаар амьтдын Монгол нэрийг өөрчлөх, шинээр оноох, тэдгээр нэрийг хянах ажлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын зөвлөл, Улсын нэр томъёоны комисстой хамтран гүйцэтгэсэн *“Монгол орны биологийн олон янз байдал: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт (Тэргүүн боть) (Редактор: С.Гомбобаатар, С.Шар, У.Айбек, Г.Гэрэлмаа, С.Баярхүү) (2019) бүтээлийг суурь болгож, Х.Тэрбиш (2019)-ийн эмхэтгэснийг баримталж, тухайн зүйлийн Монгол нэр болон шинжлэх ухааны нэрийг оруулсныг дурдах нь зүйтэй.*

Ер нь цаашид судалгаа, хамгаалал, бодлогын болон хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд энэ бүтээл дээр оноосон тухайн зүйлийн Монгол нэр (мөн шинжлэх ухааны нэр)-ийг баримталж, нэгмөр мөрдөн хэвшүүлэх нь зохистой. Учир нь эрдэмтэн, судлаачид, төрийн албан хаагчид бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрдэм шинжилгээ, судалгааны олон янзын бүтээлд нэг зүйлийг өөр өөрөөр бичих явдал түгээмэл байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

**Таних шинж.** Тухайн зүйлийг таних биеийн галбир, өнгө зүс, онцлог шинж болон төсөөтэй харагдах зүйлээс ялгарах шинж, мөн бие, сүүл, толгойн урт, өргөн, биеийн жин зэрэг хэмжилтүүд, тухайн зүйлийн шинжийг харуулсан гэрэл зургийг багтааснаараа бүтээл онцлог болов.

**Үнэлгээ ба үндэслэл.** Олон улсын үнэлгээнд Дэлхийн байгаль хамгаалах холбооны мэдээллийн сан (<https://www.iucnredlist.org>)-г ашигласан. Уг мэдээллийн санд Улаан дансны шалгуураар тухайн зүйлийн дэлхийн популяцийн үнэлгээ болон үндэслэлийг оруулсан байдаг.

Бүс нутгийн үнэлгээнд Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуур үзүүлэлтүүдээр тухайн зүйлийн Монгол орон дахь популяцийн үнэлгээг шинэчлэн хийж, оруулав. Хэрвээ тухайн зүйлийн бүс нутгийн үнэлгээг өмнө нь хийж байгаагүй бол шинээр хийж, зөвшилцсөн болно.

Энэ удаагийн бүс нутгийн Улаан дансны үнэлгээг “Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны бүс нутгийн түвшний шалгуурын удирдамж: 4.0 хувилбар” (IUCN, 2012)-ын дагуу хийв. Бүс нутгийн хэмжээнд устах эрсдэлийн үнэлгээг үнэн бодит гаргахад удирдамж нь дараах хоёр чухал үүрэгтэй. Нэгдүгээрт “Бүс нутгийн хэмжээнд устсан” болон “Үнэлэх боломжгүй” гэсэн 2 зэрэглэл нэмэгдэнэ (Хүснэгт 1). “Бүс нутгийн хэмжээнд устсан” гэсэн зэрэглэлд дэлхийд тархсан ч тухайн бүс нутагт тохиолдохгүй болсон зүйлийг багтаана. Харин “Үнэлэх боломжгүй” зэрэглэлд тухайн зүйлийн үнэлгээг хийх хангалттай мэдээ, баримт байхгүй тохиолдолд энэ зэрэглэлээр үнэлдэг.

**Хүснэгт 1.** Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны үнэлгээнд ашиглаж буй зэрэглэлийн тодорхойлолт (IUCN, 2012)

<p><b>УСТСАН EXTINCT (EX)</b></p>	<p>Хамгийн сүүлчийн бодгаль маргаангүйгээр үхсэн бол тухайн ангилал зүйн нэгжийг Устсан гэсэн зэрэглэлээр үнэлнэ. Тухайн зүйлийн бодгаль байж болох амьдрах орчныг тохиромжтой цаг хугацаанд (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж, тухайн зүйлийн өмнө нь тархаж байсан бүх газар нутгаар судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг Устсан гэсэн зэрэглэлд оруулна. Судалгааг зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.</p>
<p><b>БАЙГАЛЬД УСТСАН EXTINCT IN THE WILD (EW)</b></p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийн бодгалиуд зөвхөн таримал байдлаар, хэрэв зэрлэг амьтан бол тэжээмэл байдлаар үржүүлж байгаа эсвэл тухайн зүйлийн популяциуд түүхэн тархац нутгийн гадна байгалийн нөхцөлд нь байгаа бол Байгальд устсан гэсэн зэрэглэлд оруулдаг. Тухайн ангилал зүйн нэгжид хамаарах бодгалиудыг тохиромжтой цаг хугацаа (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан)-нд нарийн судалж, мөн тухайн зүйлийн уугуул нутагт судалгаа хийсэн ч нэг бодгаль илрүүлээгүй тохиолдолд Байгальд устсан гэсэн зэрэглэлээр үнэлдэг. Судалгааг тухайн зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.</p>
<p><b>БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД УСТСАН REGIONALLY EXTINCT (RE)</b></p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийн хамгийн сүүлчийн бодгаль үхсэн эсвэл үзэгдэхээ болсон бөгөөд дахин энэ нутагт шилжин ирэх боломжгүй тохиолдолд Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн зэрэглэлд багтаадаг. Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн зэрэглэлд тухайн зүйлийг оруулахаас өмнө цаг хугацаанд ерөнхий дүрэм тавих боломжгүй. Энэ нь зүйлийн талаарх судалгаа хэр хийгдсэнээс хамаарах болно.</p>
<p><b>УСТАЖ БАЙГАА CRITICALLY ENDANGERED (CR)</b></p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгуураар Устаж байгаа гэсэн зэрэглэлээр үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл туйлын их байгааг илтгэсэн Устаж байгаа гэсэн зэрэглэлд хамааруулна.</p>
<p><b>УСТАЖ БОЛЗОШГҮЙ ENDANGERED (EN)</b></p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгуураар Устаж болзошгүй гэсэн зэрэглэлээр үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл их байгаа гэсэн агуулгатай.</p>
<p><b>ЭМЗЭГ VULNERABLE (VU)</b></p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгуураар Эмзэг гэсэн зэрэглэлээр үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл их байгаа гэж үзэн Эмзэг гэсэн зэрэглэлд хамааруулна.</p>
<p><b>ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ NEAR THREATENED (NT)</b></p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийг А-аас Е хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд, Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг гэсэн ховордлын зэрэглэлээр үнэлэх боломжгүй ч богино хугацаанд ирээдүйд устаж, ховордох эрсдэл их байгааг харгалзан Ховордож болзошгүй гэсэн зэрэглэлд багтаадаг.</p>

<p><b>АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ LEAST CONCERN (LC)</b></p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийг А-аас Е хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд, Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг эсвэл Ховордож болзошгүй зэрэг зэрэглэлийн аль нэгээр үнэлэх боломжгүй тохиолдолд Анхааралд өртөхөөргүй зүйл гэж үзнэ. Өргөн тархац нутагтай, элбэг зүйл энэ зэрэглэлд хамааруулна.</p>
<p><b>МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ DATA DEFICIENT (DD)</b></p>	<p>Тухайн ангилал зүйн нэгжийн популяцийн төлөв байдал болон тархцыг үндэслэн устах эрсдэлийг тогтоох шууд ба шууд бус үнэлгээ хийхэд мэдээ, баримт хангалтгүй байгаа нөхцөлд Мэдээлэл дутмаг гэсэн зэрэглэлд хамааруулдаг. Тухайн зүйлийн элбэгшил, тархцын талаар мэдээ, баримт дутмаг байж болно. Мэдээлэл дутмаг гэх энэ зэрэглэл нь устах, ховордох эрсдэлийг илэрхийлсэн агуулга биш юм. Зүйлийг энэ зэрэглэлд оруулах нь тухайн зүйлийн талаар илүү мэдээ, баримт хэрэгтэйг илэрхийлдэг төдийгүй тухайн зүйлийн талаар ирээдүйд судалгаа хийж, тухайн судалгаа нь тэр зүйлийг устах эрсдэлтэйг нотлох боломжтой. Өнөөгийн байгаа мэдээ, баримтыг ашигтайгаар хэрэглэх нь нэн чухал. Тухайн зүйлийг Мэдээлэл дутмаг, мөн устах эрсдэлтэйг илэрхийлсэн зэрэглэлийн алинд нь хамааруулахаа маш анхааралтай шийдэх хэрэгтэй. Хэрвээ тухайн зүйлийн тархац нутаг харьцангуй хязгаарлагдмал, тухайн зүйлийг олон жилийн тэртээд судалсан бол тэр зүйлийг ховордох, устах эрсдэлтэй зэрэглэлд оруулах нь зайлшгүй зөв шийдвэр болно.</p>
<p><b>ҮНЭЛЭХ БОЛОМЖҮЙ NOT EVALUATED (NE)</b></p>	<p>Бүс нутгийн хэмжээнд үнэлэх шаардлага хангаагүй ангилал зүйн нэгжийг Үнэлэх боломжгүй гэсэн зэрэглэлд багтаадаг.</p>

Үнэлгээ нь хоёр шатны үйл явцаас бүрдэх ба эхлээд Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуур (IUCN, 2012)-аар тухайн популяцийг дэлхийн популяцийн төлөөлөл гэж үзэн бүс нутгийн популяцийн мэдээлэлд тулгуурлан үнэлгээ хийнэ (Хавсралт 1).

Тухайн популяцид бүс нутгийн гадна байгаа популяци нөлөө үзүүлж байвал үнэлгээг өөрчилнө. Жишээ нь, бүс нутгийн хэмжээнд ховордож байгаа тухайн зүйлийн популяци нь хөрш зэргэлдээ орноос нүүдэллэн ирдэг бодгалиудаар тэтгэгддэг бол тухайн популяцийн бүс нутгийн устах эрсдэл буурч, улмаар үнэлгээ ч мөн буурна. Хэрвээ бүс нутаг дахь тухайн зүйлийн тоо толгой болон популяцийн хэмжээ буурч байгаа бөгөөд тухайн популяци хөрш зэргэлдээ орны популяцийн бодгалиудаас сэлбэгдэх боломжгүй бол бүс нутгийн үнэлгээг ахиулж ховордлын зэрэглэлийг дээшлүүлэх зэрэг байдлаар энэ удаагийн үнэлгээг хийсэн.

Үнэлгээний үндэслэл хэсэгт дээр дурдсан Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны зэрэглэл, шалгуур үзүүлэлтүүдээр тухайн зүйлийн бүс нутгийн үнэлгээг шинээр юм уу шинэчлэн хийж, тогтоосон зэрэглэлийн үндэслэл, судалгааны тоо баримтуудыг аль болох тодорхой тайлбарлаж оруулахыг хичээсэн болно.

Үнэлгээг хийсэн эрдэмтэн, судлаач нар тухайн зүйлийн талаарх өөрсдийн судалгааны үр дүн, мөн өмнөх болон өнөө үеийн эрдэмтдийн судалгааны ажлын үр дүн, бүтээлүүдийг судлан шүүж, тухайн зүйлийн бичиглэлийг боловсруулж, үүн дээрээ үндэслэн зүйлийн бүс нутгийн үнэлгээг дээрх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хичээнгүйлэн хийж, багаараа хэлэлцэн шийдвэрлэж, улмаар дараа дараагийн шатны үнэлгээний хяналтаар оруулан хэлэлцүүлж, хамтран ажиллалаа.


Харин үнэлгээг хянасан эрдэмтэд тухайн зүйлийн үнэлгээг хийсэн эрдэмтэн, судлаач нарын үнэлгээ, үндэслэл, судалгааны баримт, материалуудыг Дэлхийн байгаль хамгаалах холбооны мэдээллийн санд тулгуурлан олон улсын үнэлгээг нягтлан шалгаж, улмаар бүс нутгийн үнэлгээний үнэн бодит эсэхийг давхар хянан нягталж, хамтран ажиллав.

Ер нь энэ удаагийн Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийг Улаан дансны зэрэглэл, шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэх ажлыг зохион байгуулахдаа аль болох олон талуудыг оролцуулж, тухайн ажлын хэсгийг ангилал зүйн бүлэг (анги, баг, төрөл г.м)-үүдээр багуудад хуваан ажиллуулж, зүйл тус бүрийн үнэлгээг хийсэн бөгөөд үүний дараа тэдгээр багуудыг хариуцсан эрдэмтэд, мөн бүлгийн ахлагч нар давхар давхар үнэлээг хянах байдлаар зохион байгуулсан тул тодорхой зүйлийн үнэлгээг хийсэн болон хянасан эрдэмтэн, судлаачид олуулаа байгааг зүйл тус бүр дээр харж болно. Тухайлбал, Монгол бахын үнэлгээ хийсэн П.Золжаргал, Х.Тэрбиш, М.Мөнхбаатар нар бол үнэлгээг хянасан Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Г.Онолрагчаа, Ж.Гүррагчаа, С.Гомбобаатар нар гэх мэт.

**Дэлхийн тархац.** Дэлхийн олон оронд баримталж байгаа хэлбэр, агуулгаар баруунаас зүүн тийш чиглэсэн байдлаар тухайн зүйл тархсан улс орон, газар нутгийн нэрийг тодорхой дурдсанаас гадна, өргөн дэлгэр тархсан зарим зүйл амьтдыг тив, бүс нутгийн нэрээр тархац нутгийн тодруулан оруулсан болно.

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Тухайн зүйлийн Монгол орон дахь тархац, байршил нутгийг баруунаас зүүн тийш гол мөрний ай сав, газар усны нэрээр тодорхой дурдаж, тайлбарлав. Мөн өмнөх бүтээл буюу 2006 оны Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн Улаан дансанд ашигласан Монгол Улсын физик газар зүйн зургийг үндэслэн (Цэгмэд, 1969) ургамал газар зүйн мужлалын зураг (Грубов, 1982; Рачковская, 1993)-аар нэмэн баяжуулж, боловсруулсан Монгол орны 16 бүс бүхий газар зүйн мужаар зарим зүйл хоёр нутагтан, мөлхөгчдийн тархцыг тайлбарласан болно (Зураг 1).

**Зураг 1.** Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн тархцыг тайлбарлахад ашигласан Монгол орны газар зүйн мужууд (Цэгмид, 1969; Грубов, 1982). 1 - Хөвсгөлийн уулс, 2 - Хэнтийн нуруу, 3 - Хангайн нуруу, 4 - Монгол Дагуурын хээр, 5 - Их Хянганы уулс, 6 - Монгол Алтайн нуруу, 7 - Төв халхын хээр, 8 - Дорнод Монгол, 9 - Их нууруудын хотгор, 10 - Олон нуурын хөндий, 11 - Умард говь, 12 - Дорнод говь, 13 - Говь Алтайн нуруу, 14 - Зүүнгарын говь цөл, 15 - Алтайн өвөр говь цөл, 16 - Алашаа говь цөл.



Үүнээс гадна, зүйл тус бүрийн тархцыг сүүлийн үеийн мэдээлэл, баримтаар баяжуулж, боломжит хэмжээнд нарийвчлан газрын зургаар харуулав. Гэвч нэлээд олон зүйлийн тархцын мэдээлэл дутмаг, хангалтгүй байсныг дурдах нь зүйтэй. Газрын зургийг боловсруулахдаа, тухайн зүйлийн тархцыг засаг захиргааны нэгж (аймаг) болон улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын зурагтай давхцуулан оруулж, боловсруулсан.

Тухайн зүйл амьтан түгээмэл тархсан байгалийн бүс, бүслүүр болон шүтэн амьдардаг амьдрах орчны хэлбэрүүдийг тодорхой тайлбарлан орууллаа. Мөн Дэлхийн байгаль хамгаалах холбооноос боловсруулсан амьдрах орчны төрөл (Habitat type)-үүдийг кодын хамт оруулсан. Тухайлбал, цэнгэг устай гол нуур, булаг шанд, намгархаг газар (5.4; 5.7) гэх мэт.

**Амьдралын онцлог.** Тухайн зүйлийн амьдралын хэлбэр, идэвхжил, идэш тэжээл, ороо хөөцөө, үржил хөгжил, ичээлэх хугацаа зэрэг онцлогуудын талаар судалгааны мэдээ, баримтад тулгуурлан тодорхой тайлбарлав. Гэвч зарим зүйл амьтдын хувьд маш бага судлагдсан эсвэл судлагдаагүй учир судалгааны мэдээ, баримт маш хомс, тодорхойгүй байсныг дурдах нь зүйтэй.

**Тоо толгой, нягтшил.** Тухайн зүйлийн бүс нутгийн популяцийн хэмжээ, тоо толгой, нягтшил, нөөцийн талаарх мэдээ, баримтыг судалгааны бүтээл, ном зохиол болон бусад баталгаатай эх сурвалжийг ашиглаж, тоо баримттай тайлбарлан (тухайн зүйл амьтны популяцийн хэмжээ, тусгаар популяциудын нөхцөл байдал, популяци/иудын өсөх, буурах, тогтвортой байдал, хандлага г.м) оруулахыг хичээв. Гэвч зарим зүйл амьтдын хувьд мэдээ, баримт тун хомс. Харин тухайн зүйлийн дэлхийн тархац, популяцийн хэмжээ, тоо толгой, төлөв байдал, хандлагын талаарх мэдээ, баримтад Дэлхийн байгаль хамгаалах холбооны мэдээллийн сан, бүтээлүүдийг ашигласан болно.

**Ховордлын шалтгаан.** Тухайн зүйл амьтны тоо толгой, тархац нутаг, нүүдэл шилжилт, амьдрах орчинд сөргөөр нөлөөлж, ховордуулж буй гол шалтгаануудын талаарх мэдээллийг судалгааны бүтээл, ном зохиол, эх сурвалжийг ашиглаж, тодорхой тайлбарлан оруулахад анхаарав. Мөн түүнчлэн Дэлхийн байгаль хамгаалах холбооноос боловсруулсан аюул заналын жагсаалт (threats list)-аас аль тохирохыг нь сонгож кодын хамт оруулсан. Тухайлбал, энэ зүйл нь хязгаарлагдмал тархац нутагтай, тусгаарлагдмал популяци тул ашигт малтмалын олборлолт (1.3.1), зам, тээвэр (1.4.4), түймэр (7.4), ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (7.4; 7.7) зэргээс шалтгаалан тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь буурах магадлалтай.

**Хамгаалсан байдал.** Тухайн зүйл амьтан “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”, “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)” болон олон улсын бусад гэрээ, конвенц, баримт бичгүүдэд хэрхэн үнэлэгдэж, хэддүгээр хавсралтад нь бүртгэгдсэнийг тодруулж, оруулав. Үүнд Монгол оронд одоогоор тэмдэглэгдээд буй 80-аад зүйл загаснаас Шивэр хилэм, Амар мөрний хилэм хэмээх хоёр зүйл дээрх нэр бүхий 2 конвенцын II хавсралтад тус тус бүртгэгдсэн байдаг.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын англи хэл дээрх товчлол болох CITES гэсэн нэрээр олны танил болсон байдаг. Энэ конвенц нь тодорхой зүйл болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдааг хянахад чиглэнэ. Конвенцод хамаарах зүйлүүдийн импорт, экспорт, ре-экспорт нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, үе шатны дагуу хийгдэх ёстой. Конвенцод нэгдэн орсон тал, нэгдэж ороогүй аль нэгэн улстай зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйл, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн худалдаа хийх тохиолдолд энэ конвенцын заалтыг мөрдөх үүрэг хүлээдэг.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц” нь дараах гурван хавсралттай бөгөөд хавсралт бүр нь ховордсон ургамал, амьтны зүйлийг агуулна. Үүнд:

<p><b>CITES I ХАВСРАЛТ</b></p>	<p>Олон улсын худалдаа нь тухайн зүйлийн оршин тогтноход нөлөө үзүүлж байгаа эсвэл нөлөө үзүүлж болох, устах аюулд орсон бүх зүйл хамаарна. Энэ конвенцын I хавсралтад орсон зүйлийн худалдааг хатуу хяналт зохицуулалттайгаар явуулдаг бөгөөд арилжааны зорилгоор худалдаалахыг үндсэндээ хориглож, судалгаа шинжилгээний зорилгоор экспортлох болон импортлоход экспорт, импортын баримт бичиг бүрдүүлэхийг шаарддаг.</p>
<p><b>CITES II ХАВСРАЛТ</b></p>	<p>Эдүгээ устах аюулд ороогүй ч тухайн зүйлийн цаашид оршин тогтноход харшлахаар ашиглалт явуулахгүй байх үүднээс олон улсын худалдааг хяналт зохицуулалттай явуулахгүй бол устах аюулд орж болзошгүй зүйлүүд багтана. Энэ конвенцын II хавсралтад багтсан зүйлүүдийг арилжааны зорилгоор худалдаалж болох бөгөөд экспортлох, импортлоход экспортлогч улсын экспортын зөвшөөрлийг шаарддаг.</p>
<p><b>CITES III ХАВСРАЛТ</b></p>	<p>Аль нэгэн тал өөрийн улсын нутаг дэвсгэрийн дотор зохицуулах шаардлагатай гэж тодорхойлсон ба тэдгээрийн худалдааг хянахад бусад талуудтай хамтран ажиллах шаардлагатай хэмээн үзэж байгаа зүйлүүд багтана. Экспортлох, импортлоход гарал үүслийн гэрчилгээ болон тухайн зүйлийг энэ хавсралтад оруулсан улсаас экспортолж байгаа тохиолдолд экспортлогч улсын экспортын зөвшөөрлийг шаарддаг.</p>

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцыг анх талуудын уулзалтыг зохион байгуулсан газрын нэрээр Боннын конвенц хэмээн товчлох бөгөөд тус конвенцын хүрээнд нэгдэн орсон талууд өөрийн улсын нутаг дэвсгэрт амьдардаг, мөн дайран өнгөрдөг шувууд, далай тэнгисийн болон хуурай газрын зүйлүүдийг амьдрах орчных нь хүрээнд хамгаалах үүрэг хүлээнэ. Уг конвенцод одоогоор 133 тал (132 улс, Европын холбоо) нэгдэн ороод байна ([www.cms.int/en](http://www.cms.int/en)). Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцын I ба II хавсралтуудыг тайлбарлавал:

<p><b>ЗЭРЛЭГ АМЬТДЫН НҮҮДЛИЙН ЗҮЙЛҮҮДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CMS) I ХАВСРАЛТ</b></p>	<p>Тархац нутагтаа эсвэл тодорхой нэг хэсэгт нь устаж үгүй болох аюул нүүрлэсэн нүүдлийн зүйлүүдийг энэ конвенцын I хавсралтад оруулдаг. Аливаа улс эдгээр амьтад болон амьдрах орчных хамгаалах, нөхөн сэргээх, нүүдэллэхэд нь саад болдог бэрхшээлийг багасгах, мөн тэдэнд аюул болж болохуйц бусад хүчин зүйлийг хянах ёстой байдаг.</p>
<p><b>ЗЭРЛЭГ АМЬТДЫН НҮҮДЛИЙН ЗҮЙЛҮҮДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CMS) II ХАВСРАЛТ</b></p>	<p>Тодорхой нэг зүйл амьтныг хамгаалах үйл ажиллагаанд олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн зүйлийг энэ конвенцын II хавсралтад оруулдаг. Иймээс уг конвенцын зүгээс II хавсралтад орсон нэг зүйл эсвэл ихэвчлэн нэг хэсэг бүлэг зүйлийн хамгаалал болон менежментийн асуудлыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг хангах зорилгоор дэлхийн хэмжээний эсвэл бүс нутгийн хэмжээний гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллахыг шаарддаг.</p>
<p>Шаардлагатай бол зарим зүйлийг I ба II хавсралтын хоёуланд нь оруулж болдог.</p>	

Хоёр нутагтан, мөлхөгчид нь Монгол орны амьтны аймгийн салшгүй бүрэлдэхүүн, тухайн экосистемийн тогтвортой байдал, бодисын эргэлт, энергийн урсгалд өөрсдийн гэсэн тодорхой үүрэг гүйцэтгэдэг, юугаар ч орлуулшгүй чухал хэсэг (Мөнхбаяр нар, 2023) бөгөөд экологи, генетик, шинжлэх ухаан, соёл боловсрол, аялал жуулчлал, амралт, гоо зүйн ач холбогдол бүхий амьтад юм.

Амьтны тухай хуулиар тэдгээрийн нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах, Генетик нөөцийн тухай хуулиар амьтны генетик нөөцийг хамгаалах, судлан хөгжүүлэх, ашиглах, мөн Зөвшөөрлийн тухай хуулиар амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох зэрэг харилцааг зохицуулсан бол Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, бусад хууль тогтоомжид ч амьтны аймагтай холбогдох заалтууд бий.

**Амьтны тухай хуулийг** голлон баримталж амьтныг хамгаалах хэлбэр, нэн ховор, ховор амьтан эсэх, агнах, барих тохиолдол болон хуульд заасан амьтан ашиглах хэлбэрүүдээс хоёр нутагтан, мөлхөгч амьтдыг голчлон ашиглаж буй хэлбэр зэргийг товчхон тайлбарлав. Ингэхдээ тус хуулиас бүрэн эхийг нь дэлгэрүүлэн уншихад хялбар байлгахыг зорьж хуулийн зүйл, хэсэг, заалтыг хураангуйлж хашилтад “( )” дотор бичсэн болно.

Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлд амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах (6.1.3.), амьтны удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах (6.1.4), үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх (6.1.7), амьтныг хамгаалах арга хэмжээний үндэслэлийг гаргахад чиглэсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх (6.1.10), иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах (6.1.11) зэрэг хэлбэрээр хамгаална гэжээ. Мөн өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах (6.1.9)-аар заасан байдаг бөгөөд энэ хүрээнд “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах аргачлал (2021)” хэмээх тусгайлсан гарын авлага боловсруулж, олны хүртээл болгосон. Үүнээс гадна, “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа” үндэсний багц (4) стандартыг боловсруулж, батлуулсан бөгөөд тэдгээрээс “MNS 6943:2021. Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага (20 хуудас)”, “MNS 6946:2021. Зэрэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хоёр нутагтан, мөлхөгчдөд тавих тусгай шаардлага (17 хуудас)” гэсэн хоёр стандарт нь хоёр нутагтан, мөлхөгчидтэй холбоотой юм.

Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нэн ховор амьтад дотор хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлээс ороогүй боловч энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад хоёр нутагтнаас Шивэр гүлмэр, Певцовын бах (ногоон бах), модны мэлхий, Дорнодын мэлхий гэсэн 4 зүйл, мөлхөгчдөөс говийн махир хуруут гүрвэл (говийн нүцгэн хуруут гүрвэл), тойрмын хонин гүрвэл, толбот гүрвэл (толбот могой гүрвэл), тэмээн сүүл могой, нарийн могой, эгэл загалмайт могой зэрэг 6 зүйл тус тус орсон байна.

Ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1), Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн (7.5.2), мөн тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор (7.5.3) зөвхөн агнаж, барьж болно.

Амьтны тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан амьтан ашиглах хэлбэрүүд дотроос хоёр нутагтан, мөлхөгч амьтдыг голдуу судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар

(ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр) ашиглаж байгаа бөгөөд ингэж ашиглахдаа амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулахгүйгээр гүйцэтгэх (16.1) учиртай. Энэ хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгодог (17.2) байна.

Зарим сониуч иргэд хоёр нутагтан, мөлхөгч амьтдын цуглуулга (20) хийдэг бөгөөд амьтны цуглуулгад эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн зорилгоор барьсан амьтан, тэдгээрийн чихмэл, арьс, үс, яс болон амьтны гаралтай бусад зүйлс хамаарна (20.1). Харин Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.15-д заасан ховор амьд амьтны цуглуулга хийх зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгодог (20.2) бол иргэн, хуулийн этгээдийн амьтны цуглуулгыг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг Генетик нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан журмыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу олгодог (20.3) байна.

Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас амьтны аймагт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг (37.1) бөгөөд энэ нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин өсгөж тогтоох (37.2) ба энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (39.2) байна.

Дашрам дурдахад, Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-нд 144 зүйл хөхтөн, 513 зүйл шувуу, 78 зүйлийн загасны экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоож, батлуулсан байх боловч хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлүүдийн экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоогоогүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй. Үүнийг тогтоосноор, амьтны нөөц ашигласны төлбөр, хураамж, амьтны аймагт учруулсан хохирол, нөхөн төлбөрийг тооцох суурь үнэ цэн болох зэрэг олон талын ач холбогдолтой.

**Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг (1.1) ашигласан, (1.2) барьсан, (1.3) агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно хэмээн тус тус заасан.**

Мөн энэ хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

3 дахь хэсэгт ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

4 дэх хэсэгт агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, тээвэрлэсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх

хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

5 дахь хэсэгт агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно хэмээн тус тус заажээ. Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

7 дахь хэсэгт харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

8 дахь хэсэгт энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

9 дэх хэсэгт амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тус тус заасныг анхаарах нь зүйтэй.

Үүнээс гадна, Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын хуулиар ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй боловч Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, эсхүл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэжээ.

**Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт** улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх,

2 дахь хэсэгт нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тус тус заасныг анхаарууштай.

Манай иргэд зарим зүйл бах, мэлхий, сонин гойд өнгө зүс бүхий гүрвэл, могой зэргийг аквариум, террариумд адгуулан тэжээх, амьтны дэлгүүрүүдээр худалдаалах, өөр хоорондоо солилцох явдал байх бөгөөд тэдгээр нь тодорхой зөвшөөрөлтэй явагдах үйл ажиллагаа гэдгийг анхаарвал зохистой.

Нөгөө талаар, Амьтны тухай хуульд заасанчлан( 4.1.24) амьтны жам ёсны эрхийг дээдэлж идэш тэжээлээ олох, амьдрах идээшил, тархац нутгаа сонгох, үржил хөөцөнд орж, үр төлөө үлдээх, бүл сүрэгтэй дасан ижилсэх, айдас цочрол, хомроглон устгагдахаас ангид байлгах зарчмыг хүндэтгэн үзэж, (34.2) амьтныг агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоноглон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулж, зөвлөгөө тусламж авч, хамтран ажиллах нь зүйтэй.

**Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.3-д** заасан амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох, 1.8 дахь генетикийн нөөц, генетикийн нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах, 1.15 дахь ховор амьд амьтны цуглуулга хийх тусгай зөвшөөрлүүдийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгодог бол харин энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.20-д заасан олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын хавсралтад заасан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох, импортлох тусгай зөвшөөрлийг конвенцын Удирдан зохицуулах зөвлөл олгодог.

Мөн энэ бүтээлд **Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг** онцгойлон авч үзэж, энэ хуульд заасан ангиллаар тухайн зүйлийн тархац нутгийн тодорхой хувь, эсвэл бүхэлдээ юм уу хэсэгчлэн улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан эсэхийг тодорхой оруулахыг хичээсэн болно. Тухайлбал, тойрмын хонин гүрвэлийн Монгол дахь тархац нутаг нь Булган гол-Онгогийн байгалийн цогцолборт газраар хамгаалагджээ гэх мэт. Ингэж тухайн зүйлийн тархац нутаг нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан эсэхийг онцгойлон авч үзсэний учир нь нэн ховор, ховор амьтан эсэхээс үл хамааран дээр дурдсанчлан Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан ... бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”* хэмээн заасан бөгөөд гэмт хэргийн шинжийг агуулах тул үүнийг олон нийтэд анхааруулж, ойлгуулахыг зорьсон хэрэг юм.

Монгол орны ихэнх зүйл хоёр нутагтан, мөлхөгчдийн тархац нутаг ямар нэгэн хэмжээгээр улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан байх тул зүйл болгон дээр энэ талаар тайлбарлах нь дахин давтагдаж нуршуу болох учир энд тайлбарлан орхив.

Түүнчлэн Монгол Улсын Улаан ном (1987; 1997; 2013; 2016)-д тухайн зүйл амьтан орсон эсэхийг шүүн үзэж, хэрвээ орсон байвал тэр тухай дурдсан болно. Тухайлбал, Дорнодын мэлхий Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгджээ (Мөнхбаяр нар, 2016).

**Хамгаалах арга хэмжээ.** Монгол орон дахь тухайн зүйлийн ховордлын шалтгааныг бууруулах, ирээдүйд тус зүйлийг өсөн үржих, тархац нутгаа тэлэх боломжийг хангахад чиглэгдсэн хамгааллын арга хэмжээг оруулахдаа Дэлхийн байгаль хамгаалах холбооноос боловсруулсан Үндэсний түвшинд авч хэрэгжүүлэх хамгааллын арга хэмжээнүүдийн жагсаалт (Conservation actions)-аас тухайн зүйлийн хамгаалалд илүү нийцэх юм уу хамгийн чухал гэсэн арга хэмжээнүүдийг түүвэрлэн авч, кодын хамт оруулсан. Тухайлбал, Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Эмзэг” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг бодлогын

түвшинд боловсруулах (1.2.1.2), ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, гений сан бүрдүүлэх (5.7.2), энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэх мэтээр санал дэвшүүлэв.

Энэ бүтээлийг улс орны хэмжээнд болон орон нутгийн түвшинд бодлогын баримт бичиг, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, аливаа төслийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж буй төрийн албан хаагчид, их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын эрдэмтэн, судлаач, багш нар, оюутан, сонсогч, залуус, хууль сахиулах болон байгаль орчны байгууллагуудын албан хаагчид, мэргэжилтэн, улсын байцаагч, байгаль хамгаалагч, мэргэжилтэн, экспертүүд болон Монгол орны амьтны аймгийг сонирхон судлагч хүн бүхэнд зориулав.



## 1.2. МОНГОЛ ОРНЫ ХОЁР НУТАГТАН, МӨЛХӨГЧДИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн судалгаанд холбогдох шинжлэх ухааны мэдээ, баримтууд манай орны болон олон улсын эрдэмтэн судлаачдын хамтын хүчин чармайлтаар улам баяжсаар байна. Сүүлийн 20 шахам жилийн хугацаанд тус улсад герпетологийн өргөн хүрээг хамарсан, олон чиглэлээр судалгааны ажлууд зохион байгуулагдлаа. Ялангуяа энэ бүлэг амьтдын ангилал зүйг нарийвчлан судалж, зүйлийн бүрэлдэхүүнийг тогтоож, тархцын зүй тогтлыг илрүүлэх талаар судалгааны үлэмж ажил гүйцэтгэсэн.

Ангилал зүйн судалгааны үр дүнд Зүүнгарын гүрвэл *Eremias dzungarica* sp. nov. (Orlova, Royarkov, Chirikova, Nazarov, Munkhbaatar, Munkhbayar and Terbish, 2017) хэмээх зүйлийг шинжлэх ухаанд шинээр бичиж, Кулагины хонин гүрвэл *Phrynocephalus kulagani* (Buehler et al., 2021; Dunayev et al., 2021; Мөнхбаяр нар, 2023), өргөслөг хонин гүрвэл *Phrynocephalus hispidius* (Buehler et al., 2021; Dunayev et al., 2021; Мөнхбаяр нар, 2023) зэргийг бие даасан зүйл болгон салгасны зэрэгцээ, тархац нутгийн судалгаануудыг өргөнөөр хийв.


Дэлхэц нутгийнхаа хүрээнд дэлхийн тархцын захын популяциуд болох шөвгөр мэлхий *Rana arvalis* (Munkhbaatar et al., 2020), дорнодын бамбай хоншоорт могой *Gloydius ussuriensis* (Kropachev et al., 2016) зэрэг зүйлийг Монгол оронд шинээр тэмдэглэв. Монгол оронд явуулсан герпетологийн судалгааны ажлын үр дүнг тусгасан “Монгол орны хоёр нутагтан” (Кузьмин нар, 2017) нэг сэдэвт бүтээл, “Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчид” (Мөнхбаяр нар, 2023) хэмээх өнгөт зурагт таних бичиг болон олон улсын сэтгүүлд хэд хэдэн өгүүлэл, бүтээлүүд хэвлэгдэн гарч нийтийн хүртээл болсон.

Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн байгаль хамгааллын статусыг тодорхойлж үнэлгээ өгөх, хамгаалах арга замыг боловсруулах талаар судалгааны үлэмж ажил гүйцэтгээд байна. Монгол Улсын Улаан номын эхний хэвлэл (1987)-д 2 зүйл хоёр нутагтан (шивэр гүлмэр, дорнодын мэлхий), 4 зүйл мөлхөгч (говийн махир хуруут геккон гүрвэл, толбот гүрвэл, тэмээн сүүл могой, нарийн могой), хоёр дахь хэвлэл (1997)-д хоёр нутагтны хоёр зүйл (модны мэлхий, ногоон бах), мөлхөгчдийн нэг зүйл (тойрмын хонин гүрвэл), гурав дахь хэвлэл (2013)-д мөлхөгчдийн хоёр зүйл (гавшгай гүрвэл, тэмээн сүүл могой)-ийг тус тус шинээр нэмж оруулсан (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2013) байна. Улаан номын зүйлүүд нэмэгдэж, хуудас зузаарч байгаа нь тийм ч сайны дохио биш хэдий ч Монгол орны хоёр нутагтан, мөлхөгч амьтдын талаарх судалгаа гүнзгийрч, бодит мэдээ баримт хуримтлагдсантай холбоотойгоор, тэдний тархац нутаг хумигдаж, тоо толгой нь хомсдохоос урьдчилан сэргийлэх үүднээс хойшлуулшгүйгээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нэг хэлбэр гэж үзэх учиртай. Энэ нь Улаан номд орсон тэдгээр хоёр нутагтан, мөлхөгчид нь өнөөгийн нөхцөлд тархац нутаг, тоо толгойн хувьд үлэмж багасаж, популяцийн түвшинд эрсдэлт төлөв байдалд хараахан очоогүй, гагцхүү хэт буурахаас сэргийлсэн алхам мөн. Хоёр нутагтан, мөлхөгчдийн эдгээр болон бусад зүйлүүд улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, олон улсын гэрээ, конвенц зэрэг эрх зүйн акт, баримт бичгийн хүрээнд хамгаалагдаж байна.

Монгол оронд амьдарч буй 32 зүйлийн хоёр нутагтан, мөлхөгчдийн ховордлын зэрэглэлийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуураар үнэлж, тэдгээр амьтны цаашдын судалгаа, ялангуяа хамгааллын арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэх боломжийг цогцоор авч үзлээ.

Өнөөдрийн байдлаар Монгол оронд тэмдэглэсэн 7 зүйлийн хоёр нутагтан, 25 зүйлийн мөлхөгчид буюу хуурай газрын хүйтэн цуст нугаламт амьтны нийт 32 зүйлийг дээрх шалгуураар үнэлэхэд 28% нь бүс нутгийн хэмжээнд ховордлын зэрэглэлд орсон бөгөөд эдгээр нь бүгд Эмзэг (VU) зэрэглэлд багтсан. Ховордож болзошгүй (NT) зэрэглэлд 16% орсон байхад Мэдээлэл дутмаг (DD) зэрэглэлд 6%, Үнэлэх боломжгүй (NA) зэрэглэлд 13% нь тус тус оржээ. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн 37% нь Анхааралд өртөхөөргүй (LC) зэрэглэлтэй (График 1).

**График 1.** Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн ховордлын зэрэглэл




Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн бүс нутгийн улаан дансны үнэлгээг анги тус бүрээр салган график 2-т авч үзэхэд ялгаатай чиг хандлагатай. Юуны өмнө нугаламт амьтны энэ хоёр анги Монгол оронд зүйлийн бүрэлдэхүүн, тархцын төлөв байдлын хувьд хоорондоо үлэмж ялгаатайн зэрэгцээ тэдгээрт үзүүлж буй нөлөө, дарамт нь ч ихээхэн ялгаатай.

**Хоёр нутагтан.** Энэ удаагийн үнэлгээгээр Монгол орны хоёр нутагтны ихэнх (57.1%) нь буюу Зүүнгарын бах, шивэр гүлмэр, дорнодын мэлхий, модны мэлхий Эмзэг зэрэглэлд оров. Мөн 28.6% нь Анхааралд өртөхөөргүй, нэг зүйл мэлхий (14.3%) Үнэлэх боломжгүй зэрэглэлтэй (График 2.1; Хавсралт 2).

**Мөлхөгчид.** Монгол орны мөлхөгчдийн зүйлийн ховордлын зэргийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуураар үнэлэхэд 20% нь Эмзэг, 20% нь Ховордож болзошгүй, 8% нь Мэдээлэл дутмаг, 12% Үнэлэх боломжгүй байна. Үлдсэн 40% нь Анхааралд өртөхөөргүй зэрэглэлтэй (График 2.2; Хавсралт 2).

**График 2.1.** Монгол орны хоёр нутагтны ховордлын зэрэглэл



**График 2.2.** Монгол орны мөлхөгчдийн ховордлын зэрэглэл




### 1.3. МОНГОЛ ОРНЫ ХОЁР НУТАГТАН, МӨЛХӨГЧДИЙН ТАРХАЛТ

Монгол орны хуурай газрын хүйтэн цуст нугаламт амьтдын зүйлийн тархцыг давхцуулан үзвэл, мөлхөгчдийн зүйлийн баялаг нь Монгол орны өмнөд хэсэгт өндөр. Дорнод говь, Алашаа говь, Говь Алтайн нуруу, Алтайн өвөр болон Зүүнгарын говь зэрэг нутгуудад дээрх зүйлүүд хамгийн олон тоогоор тохиолддог. Өөрөөр хэлбэл, Монгол орны өмнөд хэсгийн говь цөл, цөлөрхөг хээрийн нутгаар олон зүйл мөлхөгчид тархжээ. Харин Монгол орны хойд хэсгийн ой, ойт хээр, хээрийн бүс нутгуудад хоёр нутагтны ихэнх зүйлүүд тохиолддог. Ийнхүү Монгол орны экосистемийн бүсчлэлээр хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлүүд ялгаран тархах ерөнхий зүй тогтол ажиглагдана. Нөгөө талаас, манай орны герпетофауныг бүрдүүлэгч төрөл, зүйлүүдийн олонх нь дэлхийн тархцын захын популяциуд байдаг онцлогтой. Манай оронд тархсан байх боломжтой зүйлүүдээс сүүлийн үеийн судалгаагаар хоёр зүйл нэмэгдэж, Монгол орны герпетофауны зүйл баяжиж байгаа ба өөр бусад зүйлийн дэлхийн тархцын захын популяциуд цаашид тэмдэглэгдэх боломжтойг дурдах нь зүйтэй (Хавсралт 3).

**Хоёр нутагтан.** Зүйлийн баялаг, ховордож буй хоёр нутагтны зүйлүүдийн тархцыг харьцуулахад, өвөрмөц дүр зураг харагддаг. Монголд тэмдэглэгдсэн зүйлүүдийн ихэнх нь Хангай, Хөвсгөлийн уулс, Монгол Дагуурын хээр, Төв халхын хээр, Дорнод Монгол, Их Хянганы уулс, Хэнтийн нуруу зэрэгт тархсан байх бөгөөд мөн ховордож буй хоёр нутагтны зүйлийн тархац, зүйлийн баялгийн давхцал Хэнтийн нуруунд төвлөрч байна. Монгол Дагуурын хээр, Хөвсгөлийн уулс, Их Хянганы уулс зэрэг бусад газруудад ч үүнтэй төстэй дүр зураг ажиглагдана (Зураг 2).

**Мөлхөгчид.** Монгол орны мөлхөгчдийн тархац харьцангуй олон янз байгаа бөгөөд зарим зүйл могой, геккон, гавшгай гүрвэл зэрэг нь амьдрах орчны өвөрмөц нөхцөлд зохицон амьдардаг учраас өөр өөрийн онцлог бүхий нутагт тохиолдоно. Мөлхөгчдийн зүйлийн баялгийн тархцын зураг (Зураг 3)-аас үзвэл, зүйлүүдийн ихэнх нь Монгол орны баруун өмнөд болон өмнөд нутгаар тохиолдоно. Хангайн нурууны баруун хэсэг, Их нууруудын хотгор зэрэг баруун Монголын бүс нутагт тархсан хэд хэдэн зүйл бас бий. Дорнод говь, Алашаа говь, Говь Алтайн нуруу, Алтайн өвөр говь зэрэг бүс нутгуудад мөлхөгчдийн зүйлүүд хамгийн олон тоогоор тохиолдож байна. Эдгээр нутагт ховордлын зэрэг өндөр хэмээн үнэлсэн зүйлүүдийн дийлэнх нь амьдардаг.



**Зураг 2.** Монгол орны хоёр нутагтны тархалт. Өнгө тодрох тусам зүйлийн баялаг нэмэгдэнэ.

## 1.4. МОНГОЛ ОРНЫ ХОЁР НУТАГТАН, МӨЛХӨГЧДИЙН ХОВОРДЛЫН ШАЛТГААН


Үнэлгээний явцад зүйлийн тоо толгойг бууруулж буй үйл явц буюу гол хүчин зүйлсийг шууд (байгалийн нөөцийн олборлолт, агналт г.м) ба дам нөлөөлж буй (орчны хомсдол буюу зориудын болон санамсаргүй хорогдуулах г.м) ховордуулах шалтгаан хэмээн ялган авч үзэв. Мөн зүйл бүрийн ховордлын шалтгааныг анхдагч, хоёрдогч, гуравдагч гэж жагсаан тодрууллаа. Хүснэгт 1-д Эмзэг зэрэглэлтэй зүйлүүдийн ховордлын шалтгааныг тоймлон үзүүлэв.

Ховордож буй хоёр нутагтан, мөлхөгчдийн хувьд орчны хомсдол, бохирдол нь ховордуулах гол шалтгаан болж байна. Бүх зүйлүүд амьдрах орчны эвдрэл, доройтол, хэсэгчлэн хуваагдалт, хомсдол, зарим тохиолдолд бохирдол зэрэг анхдагч болон хоёрдогч ховордуулах шалтгаануудын нөлөөгөөр цөөрнө (График 3).

Ихэнх тохиолдолд байгалийн нөөцийн олборлолт, ялангуяа уул уурхайн үйл ажиллагаа хоёр нутагтанд хүчтэй нөлөөлж, одоогийн тархац нутгийг эвдэн бусниулж, амьдрах орчныг бохирдуулж байна. Ахуйн болон хөдөө аж ахуйн хог хаягдал зэрэг бусад үйл ажиллагаанаас ус мөн бохирддог. Хүмүүс уст цэгийн орчимд шинээр суурьшсанаас малын тоо толгой нэмэгдэж, тэр хэмжээгээр усны ашиглалт ихсэж амьдрах орчин доройтон, хомсдолд орсоор. Мөн цаг уурын дулаарал, хур тунадасны татрал, агаар-хөрсний гангийн улмаас ус, намгархаг газрууд хуурайшиж, тэнд амьдардаг зүйлүүдэд амьдрах орчны хомсдол нүүрлэснээр тоо толгойд нь сөрөг нөлөө үзүүлж эхэлжээ.

Орчны доройтлын гол шалтгаанд ахуйн ба үйлдвэрийн гаралтай бохирдол, ойн ба тал хээрийн түймэр, малын тоо толгой өссөнөөс үүдэлтэй бэлчээрийн талхагдал зэрэг орно. Цаг уурын өөрчлөлтийн зарим үйл явц нь хоёр нутагтан, мөлхөгчдийг ховордуулах гуравдагч шалтгаан болно. Эдгээр амьтдын олонх зүйлүүд нь Монгол орны өмнөд хэсэгт, голдуу хуурай нөхцөлтэй, ган гачигт өртөмтгий бүс нутгуудад амьдардаг. Энэ бүс нутгуудад хүний идэвхтэй үйл ажиллагаа болон байгаль орны өөрчлөлт зэргийн алиных нь үр дагавар хуурай газрын эдгээр хүйтэн цуст амьтдад илүү сөрөг нөлөө үзүүлж байгааг хараахан тогтоогдоогүй.

**График 3.** Ховордлын ангилалд орсон Монгол орны 9 зүйл хоёр нутагтан болон мөлхөгчдөд учирч буй аюул занал (хувцар харуулав)



**Хүснэгт 1.** Ховордлын ангилалд орсон Монгол орны 9 зүйл хоёр нутагтан болон мөлхөгчдөд шууд нүүрлэж буй ховордлын шалтгаануудын тойм. Анхдагч ховордуулах шалтгааныг хар, хоёрдогчийг саарал, гуравдагчийг цайвар саарал өнгөөр тэмдэглэв.

ХХовордлын зэрэглэл	Зүйлийн нэр (Монгол болон шинжлэх ухааны нэр)	Амьдрах орчны доройтол	Амьдрах орчны хуваагдал	Амьдрах орчны хомсдол	Бохирдол	Өвчин	Шимэгчид	Махчид	Эрлийзжилт	Өрсөлдөгчид	Зориудын эндэл	Гэнэтийн эндэл	Цаг уурын өөрчлөлт	Бусад	Мэдэгдээгүй
Эмзэг	Зүүнгарын бах <i>Bufo peszewi</i>														
Эмзэг	Модны мэлхий <i>Dryophytes japonica</i>														
Эмзэг	Дорнодын мэлхий <i>Rana chensinensis</i>														
Эмзэг	Шивэр гүлмэр <i>Salamandrella keyserlingii</i>														
Эмзэг	Говийн махир хуруут гүрвэл <i>Tenuidactylus elongatus</i>														
Эмзэг	Тойрмын хонин гүрвэл <i>Phrynoscephalus helioscopus</i>														
Эмзэг	Гавшгай гүрвэл <i>Lacerta agilis</i>														
Эмзэг	Тэмээн сүүл могой <i>Eryx taticus</i>														
Эмзэг	Эгэл загалмайт могой <i>Vipera berus</i>														

A close-up photograph of a frog floating in clear blue water. The frog's mouth is full of air bubbles, and its large, golden eyes are looking directly at the camera. The water is calm, with soft ripples around the frog.

## ХОЁРДУГААРБҮЛЭГ

МОНГОЛ ОРНЫ ХОЁР НУТАГТНЫ АНГИЙН  
АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ,  
ХАМГААЛАЛ

## 2.1. ШИВЭР ГҮЛМЭР

### *Salamandrella keyserlingii* (Dybowski, 1870)

**Баг:** Сүүлтэй хоёр нутагтан (Caudata)

**Овог:** Гүлмэр (Hynobiidae)

**Англи нэр:** Siberian Salamander

**Ижил нэр:** Сибирийн гүлмэр; *Hynobius cristatus* (Andersson, 1917), *Hynobius doii* (Abé, 1922); *Hynobius keyserlingii* (Dybowski, 1870); *Hynobius michnoi* (Nikolskii, 1925); *Isodactylium wosnessenskyi* (Strauch, 1870); *Salamandrella cristata* (Andersson, 1917); *Salamandrella keyserlingii forma typica, kultukiensis* (Dybowski, 1928); *Salamandrella skvorzovii* (Pavlov, 1934); *Salamandrella wosnessenskyi* (Strauch, 1870); Siberian Newt.

**Ангилал зүйн тойм.** Судлаачид 1920 оноос *Salamandrella* төрлийг *Hynobius* төрлийн ижил нэр хэмээн үзэж ирсэн ч 1980 оноос энэ төрлөөс тусад нь авч үзэх болсон. Энэ зүйл нь нэн өргөн тархацтай. Гэвч энэ зүйлийн газар зүйн хувьслын судалгаа өнөө хүртэл бүрэн гүйцэд хийгдээгүй тул хэчнээн салбар зүйл байгаа талаар эцсийн дүгнэлт хийх боломжгүй. Гагцхүү уг зүйлийн ангилал зүйн анхдагч бичиглэл хийсэн голотип нь манай улстай хил залгаа нутгаас олдсоноос үзэхэд, Монголд шивэр гүлмэрийн эх салбар зүйл байх бүрэн магадлалтай (Terbish et al., 2006a; Кузьмин и др., 2017).

**Таних шинж.** Биеийн урт сүүлний хамтаар 9-10 см. Өргөн хавтгай толгойтой, бүлтгэр нүдтэй, паротид булчирхай тод харагдана. Биеийн хоёр талаар 12-13 босоо судалтай. Мөчид богино, 4 хуруутай. Хоёр хажуугаасаа хавчиг сүүлтэй. Шаргалдуу туяатай бор, хар хүрэн. Шилнээс сүүлний үзүүр хүртэл нурууг дагасан шаргал судалтай. Хэвлий тал цайвар (Кузьмин и др., 2017).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бус нутгийн үнэлгээ:** 2006 онд Эмзэг (VU), АЗс (Terbish et al., 2006a; Тэрбиш нар, 2006a).



2025 онд Эмзэг (АЗс). Тоо толгойн хувьд цөөн болох нь энэ зүйлийн идээшин амьдардаг нутгуудад хийсэн судалгаагаар тогтоогдсон (Мөнхбаяр, 1987; Мөнхбаяр, Тэрбиш, 1997). Идээшил нутгийн өөрчлөлтөөс энэ зүйлийн тоо толгой дараагийн арван жил болон гурван үе удмын хугацаанд 30%-аар буурч болзошгүй, мөн хил залгаа нутгаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшилт үгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

**Үнэлгээ хийсэн:** П.Эрдэнэтүшиг, М.Мөнхбаатар, Х.Тэрбиш (2025).


**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Золжаргал, Г.Онолпрагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Хоёр нутагтны бүлэг дотор өргөн тархацтай зүйлд тооцогддог. Дэлхийн хэмжээнд 12 сая км<sup>2</sup> нутагт тархсан. Орос, Казахстан, Хятад, Монгол, Солонгосын хойг, Японы нутаг дэвсгэрт идээшин амьдарна (IUCN, Conservation International and NatureServe, 2006; IUCN, 2023).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Энэ зүйлийг Умард мөсөн далайн ай савын Сэлэнгэ, Орхон, Туул, тэдгээрийн цутгалууд, Хорьдол Сарьдаг, Улаан тайгаас эх авдаг Шишхэд, Үхэрт, Арсай, Хөг, Гуна, Тэнгис, тэдгээрийн цутгал (Мөнхбаяр, 1976; Кузьмин и др., 1986; Улыкпан, Мөнхбаяр, 1982; Литвинов и Скуратов, 1986; Семенов, Мөнхбаяр, 1996; Тэрбиш нар, 2006a), Хэнтийн нуруунаас эх авч буй Онон, түүний цутгал (Мөнхбаатар нар, 2001), Хэрлэнгийн эх (Хотолхүү, 1969), Хангайн нуруунаас эх авч Их нуурын хотгорын Увс нуурт цутгадаг Тэсийн голын сав (Даваа нар, 1992), Улз голын сав, Чух нуур (н.Ганхуяг, П.Эрдэнэтүшиг, 2022; аман мэдээ), Халх,

Нөмрөгийн голын сав нутгаас тус тус тэмдэглэсэн (Д.Лхагвасүрэн, Д.Нарангарвуу, Г.Довчиндорж, 2022; аман мэдээ) байна.

Тархалтын байдлаас үзвэл, энэ зүйл Монгол орны томоохон голуудын савдагуух нутгуудыг шүтэн тархсан байх бөгөөд далайн түвшнээс дээш 600-2,250 м өндөрт тохиолдоно (Боркин и др., 1988). Мөнхсарьдаг уулын өвөр бэлийн 2,200 м өндөрт, Ариг голын тагийн нугад тэмдэглэгдсэн (Литвинов, 1981; Литвинов и Скуратов, 1986). Монгол орны умард нутгийн ой (1.2; 1.4), тайга (1.1) бүхий ус, намгархаг (5.1; 5.3; 5.4; 5.7; 5.11; 5.13) орчинд өргөн тархжээ.



**Амьдралын онцлог.** Гол төлөв ус бараадан чийгтэй орчин шүтэн тайга, ойт хээрийн бүс, бүслүүрийн гол, мөрөн, нуур, цөөрөм намгархаг газраар тархана. Үржлийн мөчлөгөөс бусад үед хуурай газар амьдарна. Бүрэнхий, шөнийн идэвхтэй. Өдрийн цагаар дархи, модны хожуул, ургамал, хад асга, чулуун дор нуугдана. Бие гүйцсэн бодгалиуд хуурай газрын жижиг сээр нуруугүй амьтдаар, шанаганцар шатандаа усны жижиг хавч хэлбэртнээр хооллоно.

9-р сард өгөршсөн мод, хожуул, газрын ан цаваар ичээлж, 4-р сард ичээнээс гарч усан орчинд үржилд орно. Эм нь 270-300 орчим түрсээ мушгиа уут хэлбэртэйгээр усны ургамалд бэхэлнэ. Авгалдай түрснээс гарах болон шанаганцрын хөгжлийн хугацаа цаг уурын байдлаас хамаарах бөгөөд ойролцоогоор 7-8-р сард дүрс хувиралд орж хуурай газар шилжинэ. Залуу гүлмэрүүд 3 дахь жилдээ бие гүйцэж үржилд орно (Мөнхбаяр нар, 2023).

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний

мэдээлэл байхгүй бөгөөд тархац нутгийнхаа хүрээнд цөөн тоотой тохиолддог (Кузьмин и др., 2017).

**Ховордлын шалтгаан.** Хот суурин газрын тэлэлт (1.1), ашигт малтмалын олборлолт (3.2), зам, тээвэр (4.1), түймэр (7.1.1), орчны бохирдол (9.1.3), ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (11.2) болон хөдөө аж ахуй (2.3.1) зэрэг шалтгааны улмаас тархац нутаг нь багасан хумигдах хандлагатай.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон ба ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1) агнаж, барьж болно. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 16% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (Тэрбиш нар, 2006а). Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгдсэн (Мөнхбаяр нар, 2016).

#### Хамгаалах арга хэмжээ

- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ (3) хэрэгжүүлэхийн тулд түүний популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны төлөв байдал (3.4)-ын судалгааг нарийвчлан гүйцэтгэх
- Зүйлийн генийн санг бүрдүүлэх (5.7.2)
- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.1 ба 1.2)
- Хоёр нутагтны хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3) биологи, экологийн судалгаа явуулах
- Мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх (2.1 ба 2.2) шаардлагатай.

## 2.2. МОНГОЛ БАХ

### *Strauchbufo raddei* (Strauch, 1876)

**Баг:** Сүүлгүй хоёр нутагтан (Anura)

**Овог:** Бах (Bufonidae)

**Англи нэр:** Mongolian Toad

**Ижил нэр:** Сибирийн бах; *Bufo kozlovi* (Zarevskij, 1924); *Bufo raddei* (Strauch, 1876); *Pseudepidalea raddei* (Strauch, 1876); Siberian (Sand) Toad or Radde's toad, Tengger Desert Toad.



**Ангилал зүйн тойм.** Өмнө нь энэ зүйлийг *Bufo viridis* бүлгийн бүрэлдэхүүнд оруулж байсан ба уг бүлгийг хоёр дэд бүлэгт хуваадаг (Amphibiaweb, 2006). Хожим явуулсан биохимийн судалгаагаар *Bufo raddei* зүйлийг *Bufo viridis* бүлгээс ялгаатай, харин *Bufo bufo*, *Bufo melanostictus* зүйлтэй илүү ойрхон хэмээн үзсэн (Maxson, 1981). Ангилал зүйн сүүлийн үеийн судалгаагаар *Bufo* төрлөөс салгаж *Strauchbufo* төрөлд оруулж ангилсан (Fei et al., 2012). Энэ төрөлдөө цорын ганц зүйл бөгөөд салбар зүйл тодорхойлогдоогүй, ангилал зүйн харьцангуй тогтвортой зүйлд тооцогддог (Кузьмин и др., 2017).

**Таних шинж.** Биеийн урт 74 мм. Арьсан дээгүүрээ арзгар төвгөрүүдтэй. Нурууг дагасан нарийн цайвар судалтай. Эмийн зүс тод эрээн цоохор, эрийнх бүдэг ногоовтор сааралдуу бол зулзаган бах ихэвчлэн эр бахтай төсөөтэй (Мөнхбаяр нар, 2023). Нурууны голоор нарийхан цайвар судал хөгжсөн байдгаараа ногоон бах, бор бахаас ялгагдана.

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бус нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish et al., 2006a; Terbish et al., 2006b). 2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).


**Үнэлгээ хийсэн:** П.Золжаргал, Х.Тэрбиш, М.Мөнхбаатар (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Г.Онолрагчаа, Ж.Гүррагчаа, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Орос (Байгаль нуурын орчмын нутаг, Алс Дорнод), Хятад, Монгол, Солонгосын хойгт тархах боломжтой (IUCN, Conservation International and Nature Serve, 2006; IUCN, 2023). Энэ зүйл Төв Азид хамгийн өргөн тархацтай хоёр нутагтын нэг юм.

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол орны хамгийн түгээмэл тархалттай бах юм (Terbish et al., 2006). Тархалтын ерөнхий төлөв байдлаас үзвэл, тус орны говь цөл, тал хээр, ойт хээрийн бүсийн гол, нуур, булаг

шанд, баян бүрд зэрэг ус, намгархаг (5.1; 5.2; 5.3; 5.4; 5.5; 5.6; 5.7; 5.8; 5.9; 5.11; 5.12; 5.13) газруудыг шүтэн амьдарна (Terbish *et al.*, 2006). Нууруудын хөндийн баруун умард хэсэг, Бигэр нуурын хотгороос зүүн тийш Их Хянганы уулс, Монгол орны умард нутгаас өмнө зүг Алтайн Өвөр говь хүртэл нэлээд өргөн уудам нутагт тархсан бөгөөд хэд хэдэн хязгаарлагдмал популяци бий. Энэ зүйл Их нууруудын хотгор, Хангай нурууны баруун хэсэг, Хөвсгөлийн уулс, Зүүнгарын говь зэрэг нутгаас хараахан олддоогүй (Тэрбиш, 1989; Боркин и др., 1988). Монгол оронд далайн түвшнээс дээш 500-3,800 м өндөрт тохиолдоно (Банников, 1958; Боркин и др., 1986; 1988).



**Амьдралын онцлог.** Гол мөрөн, нуур цөөрмийн эрэг орчим, тогтмол ус, намаг, цэцэрлэг, ногооны газар, барилга байшингийн суурь, суваг шуудуу, уурхайн худгийн хашлага, мэрэгчдийн нүхэнд амьдарна. Шөнийн идэвхтэй. Өдрийн цагаар дээр дурдсан газруудад орогноно. Их төлөв цох, эрвээхэйн төөлүүр, усны шавж, царцаа, ялаа, батгана, аалз тэргүүтнээр хооллоно. Түүний тэжээлд хүнсний ногооны хөнөөлт шавж багагүй хувийг эзэлнэ.

4-р сард ичээнээс гарч 9-р сарын эцэс хүртэл идэвхтэй амьдарна. Хавар үржлийн үе болмогц усанд орж орой үдшийн цагаар вааглан дуугаралдана. 5-р сарын эхээр эм нь 3,000 гаруй төрц усан дотор гаргана. Төрц нь пүнтүүз шиг цэлцгэнүүр бүрхүүлтэй хэдэн метр урт нарийхан тууз мэт байх бөгөөд усны ургамал, ёроолын биет дээр тохож орхисон байдаг. Төрцөөс 6-р сарын эхээр шанаганцар гарч, усны жижиг амьтдаар хооллон өссөөр 7-р сарын эцсээр сүүл нь богиносож, дөрвөн мөч урган гарч, улмаар хуурай газарт шилжинэ. Намрын дунд сард нүх үүр, эрэг ганга, газар шороон дотор шургаж ичээнд орно.

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй. Монгол оронд хамгийн өргөн тархсан, үржлийн үедээ тархац нутгийнхаа хүрээнд тохиолдоц харьцангуй элбэг. Зүүн Монголын тал хээрийн бүсийн Буйр нуур, Халх голын бэлчир орчимд 1 цагийн дотор 60 бах ажиглагдаж байв (Мөнхбаяр, Эрэгдэндагва, 1970). Мөн Хөх нуурын орчимд 10 м<sup>2</sup> талбайд 6 бие гүйцсэн бодгаль, 200 орчим зулзаган бах, Дөч голын эрэг дагууд нэг га талбайд 264 бодгаль тоологдож байв (Мөнхбаатар нар, 2003). Төв Монголын тал хээрийн бүсэд Нарийн тээл голын нугад 1 м<sup>2</sup> талбайд 3-7, Батсүмбэр орчмын намгархаг газар 7, Бор нуур сумын Шар чулууны орчим 4-20 зулзаган бах ажиглагдана (Кузьмин и др., 2017). Түүнчлэн Түйн голын дагуух жижиг цөөрөмд 32-135 бодгаль тоолж (Kuzmin, 2015) байжээ.

**Ховордлын шалтгаан.** Олон янзын амьдрах орчинд нэлээд өргөн тархацтай тул ховордуулах шалтгаан мөн л төдий олон янз байдаг. Хот суурин газрын тэлэлт (1.4), ашигт малтмалын олборлолт (1.3), зам, тээвэр (1.4.4), түймэр (7.4), орчны бохирдол (6.2; 6.3), ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (7.1; 7.3), хөдөө аж ахуй (1.1; 1.1.4) зэрэг шалтгааны улмаас тархац нутаг нь багасан хумигдах хандлагатай ч одоогоор энэ зүйлийг ховордуулах хэмжээнд хүрээгүй (Terbish *et al.*, 2006) гэж үзжээ.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн өржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Монгол орон дахь энэ зүйлийн тархац нутгийн 8% орчим нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (Terbish *et al.*, 2006; Кузьмин и др., 2017).

**Хамгаалах арга хэмжээ.** Хоёр нутагтны хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн судалгаа явуулах шаардлагатай.

## 2.3. ЗҮҮНГАРЫН БАХ

### *Bufotes pewzowi* (Bedriaga, 1898)

**Баг:** Сүүлгүй хоёр нутагтан (Anura)

**Овог:** Бах (Bufonidae)

**Англи нэр:** Pewzow's Toad

**Ижил нэр:** Ногоон бах, Певцовын бах, Төв Азийн бах; *Bufo danatensis* ssp. *taxkorensis* (Fei, 1999); *Bufo nouettei* (Mocquard, 1910); *Bufo tianschanica* (Toktusunov, 1984); *Bufo viridis* var. *pewzowi* (Bedriaga, 1898); *Bufo viridis* var. *strauchi* (Bedriaga, 1898); *Bufo viridis* ssp. *unicolor* (Kastschenko, 1909); *Bufo viridis* var. *Grumgrzimaloi* (Bedriaga, 1898); *Pseudepidalea pewzoni* (Bedriaga, 1898); *Pseudepidalea taxkorensis* (Fei et al., 1999); *Bufo viridis* (Банников, 1958; Obst, 1963; Piechocki and Peters, 1966; Мөнхбаяр, 1968; 1970; 1981; Peters, 1971; 1982; Боркин, 1984; Орлова, 1984; Бобров, 1986; Орлова и Утешев, 1986; Тэрбиш, 1986; Кузьмин и др., 1986; Тэрбиш и Кузьмин, 1985; Мөнхбаяр, Тэрбиш, 1991); *Bufo danatensis* (Pisanets et al., 1985; Боркин и др., 1986; Боркин и Кузьмин, 1988; Семенов и Мунхбаяр, 1996; Мөнхбаяр нар, 2001; Terbish et al., 2006); *Bufo pewzowi* (Тэрбиш нар, 2006а; 2006б; Terbish et al., 2006а; 2006б); *Bufotes pewzowi* (Stoeck et al., 2000; 2001; 2006; 2008; Frost, 2016; Kuzmin et al., 2017; Мөнхбаяр нар, 2023); Green Toad, Central Asian Green Toad.



**Ангилал зүйн тойм.** Киргизийн нутаг амьдардаг ногоон бах полиплоид хромосомтой болохыг анх 1976 онд судлан илрүүлсэн нь ногоон бахын бүлгийн ангилал зүйн судалгаа цаашид эрчимжих үндсэн сэдэл болов. Тухайлбал, Туркмений Данатын бүс нутгийн ногоон бахын ангилал зүйн талаар хийсэн судалгааны үр дүнд

полиплоид хромосомын бүрдэлтэй *Bufo danatensis* Pisanetz, 1978 хэмээх зүйлийг шинээр бичиглэжээ. Түүнчлэн Монгол орны нутаг дэвсгэрт тархсан ногоон бах нь тетраплоид хромосомтой ( $4n=44$ ,  $NF=88$ ) хэлбэр болохыг тогтоосон (Боркин и др., 1986). Энэ үеэс эхлэн Төв Азийн өргөн уудам нутаг тархсан полиплоид ногоон бахыг



Эм

нийтэд нь *Bufo danatensis* хэмээх зүйлд хамруулах болов. Гэвч генетик, морфологи, ангилал зүйн талаарх цогц судалгааны үр дүнд ногоон бахын бүлэгт хамаардаг, полиплоид хромосомтой хэд хэдэн зүйл тодорхой болсон байна (Stoeck *et al.*, 2000; 2001; 2006; 2008). Эдгээрээс манай орны нутаг дэвсгэрт тетроплоид хромосомтой *Bufo peszewi* гэх зүйл амьдардаг.

**Таних шинж.** Биеийн урт 90 мм. Толгойн урт нь ойролцоогоор биеийн уртын 1/3-тэй тэнцэнэ. Эм нь эрээс биеэр том байхын зэрэгцээ зүсээрээ хоорондоо мэдэгдэм ялгаатай. Эмийн нуруун тал бор саарал, эсвэл ногоовтор, түүн дээр гадуураа хөвөөтэй, тод ногоон том толботой. Хоолой, хэвлийн төгсгөл хэсэг нь цулгүй цайвар цагаан, харин хэвлийн бусад хэсэгт жижиг бараан толбо бий. Эрийн нуруун хэсэг нь харьцангуй нэг төрлийн цайвар ногоон, тод ногоон өнгийн толбогүй.

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Эмзэг (VU), B1ab(iii) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).

2025 онд Эмзэг (VU) B1ab(iii). Монгол орон дахь тархац нутгийн нийт талбай

ойролцоогоор 11,870 км<sup>2</sup>. Энэ зүйлийг манай орны арваас цөөн байршил нутагт (Зүүнгарын говийн 4 баянбүрд болон Булган, Үенч гол, тэдгээрийн уулархаг нутгийн цутгал голууд) тэмдэглэжээ.

**Үнэлгээ хийсэн:** Х.Тэрбиш, П.Золжаргал, М.Бүрнээ, Г.Довчиндорж (2025)

**Үнэлгээг хянасан:** М.Мөнхбаяр, М.Мөнхбаатар, П.Эрдэнэтүшиг, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Казахстан, Киргиз, Узбекистан, Тажикстан, Хятад, Монголын баруун өмнөд нутагт тархжээ. Афганистаны нутагт тархсан байх магадлалтай.

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол Алтайн нурууны баруун өмнөөс эх авсан Булган, Үенч гол, тэдгээрийн цутгалууд, Хүйтэн булаг, Ихэр толь, Шар булаг, Баян мод зэрэг булаг шанд (5.1), Зүүнгарын говийн Дамжигийн ус, Уушгийн усны баян бүрдээр (5.9) тархсан. Монгол оронд далайн түвшнээс дээш 1,150-2,000 м өндөрт тохиолдоно (Мөнхбаяр, 1976; Тэрбиш, 1985; Тэрбиш и Кузьмин, 1985; Орлова и Тэрбиш, 1986).

**Амьдралын онцлог.** Бие гүйцсэн бодгаль ихэвчлэн цох, шоргоолж, хос далавчтан зэрэг шавж, харин шанаганцар нь нэг эст

замгаар хооллоно. Тэд 5-р сарын дундуур төрцөө шахах ба үр хөврөлийн болон шанаганцрын хөгжил ойролцоогоор 2 сар гаруй үргэлжилнэ. Шанаганцрууд 7-р сарын төгсгөл, 8-р сарын эхээр дүрс хувирснаар залуу бахууд хуурай газарт гарна. 10-р сарын эхээр ичээлж, 4-р сард ичээнээс сэзнэ.



**Тоо толгой, нягтшил.** Амьдрах орчноос хамаарч тоо толгой нь харилцан адилгүй. Улиастайн голд шөнө 1-2 цагийн турш явуулсан ажиглалтаар 5-30 бодгаль тохиолдож байв. Зарим баян бүрд, уст цэгийн орчимд үржлийн болон ичээний үедээ олноор цуглана. Тухайлбал, Хүйтэн булаг орчмын 200 м<sup>2</sup> талбайд 104 бодгаль, Улаан үзүүрийн булагт 240 м<sup>2</sup> талбайд 172 бодгаль тус тус цугларсан байв (Тэрбиш, 1985; Тэрбиш и Кузьмин, 1988; Peters, 1971).

**Ховордлын шалтгаан.** Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл (6.2.1; 6.3.1), худалдаа, үйлчилгээ (6.2.3; 6.3.3), ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдлын (6.2.2; 6.3.2) улмаас энэ зүйлийн амьдрах орчин доройтож байна. Байгалийн нөөцийн (уул уурхай) олборлолтын (1.3.1) улмаас амьдрах орчны хомсдол болон бохирдол үүссэн. Амьдралын үндсэн орчин болсон баян бүрд, гол, горхины ойролцоо нутгийн иргэд, малчид олноор нүүдэллэн суурьшиж, мал сүрэг уст цэгийг талхалснаас (1.1.4.1) түүний амьдрах орчин доройтож байна. Агаарын ба хөрсний ган (7.1), цочир хүйтрэл (7.3) зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн улмаас булаг, шанд татран ширгэх, ус намгархаг газар хатаж хуурайших зэрэг нь энэ зүйл бахын тоо толгойд сөрөг нөлөө үзүүлнэ. Мөн үнэг, хярс зэрэг махчин амьтад, өдрийн болон шөнийн махчин шувууд (8.2), загас (8.3), гадаад, дотоод шимэгчдийн (8.5) нөлөөгөөр тоо толгой нь хомсдолд орох магадлал өндөр. Хязгаарлагдмал тархац (9.1), бага нягтшил

(9.5), авгалдайн болон залуу бодгалиудын үхэл хорогдол (9.3) зэрэг дотоод хүчин зүйлс энэ зүйлийн тоо толгойд мөн сөргөөр нөлөөлсөөр байна.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон ба ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1) агнаж, барьж болно. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Говийн Их Дархан цаазат газрын “Б” хэсэг, Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгджээ (Мөнхбаяр нар, 2016).

#### Хамгаалах арга хэмжээ

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Эмзэг” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологийн, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судлах, ер нь судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор мониторингийн судалгааны экспедицийг улсын төсвөөр 3 жил тутамд зохион байгуулах
- Гений сан бүрдүүлэхэд (5.7.2) анхаарах
- Хоёр нутагтны хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологийн, экологийн судалгааг хийх
- Хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 2.4. МОДНЫ МЭЛХИЙ

### *Dryophytes japonicus* (Günther, 1859)

**Баг:** Сүүлгүй хоёр нутагтан (Anura)

**Овог:** Модны мэлхий (Hylidae)

**Англи нэр:** Far Eastern Treefrog

**Ижил нэр:** *Hyla japonica* (Gunther, 1859); *H. stephensi* (Boulenger, 1887); *H. ussuriensis* (Nikolsky, 1918); Japanese Treefrog.



**Ангилал зүйн тойм.** Ангилал зүйн судалгаа бүрэн гүйцэд хийгдээгүй. Европын болон Хятадын зарим судлаачид *Hyla arborea* гэх зүйлийн салбар зүйл гэж үздэг ч хожим хийсэн генетикийн судалгааны үр дүн энэ зүйлийг бие даасан зүйл болохыг нотолсон (Daito, 1968; Kawamura and Nishioka, 1977; Kuramoto, 1984; Kuzmin, 1999; Frost, 2007;

IUCN, Conservation International and Nature Serve, 2006). Fei (1999) умард Хятад, Солонгосын хойг, Оросын дорнод хэсэг, Монголд тархсан модны мэлхийг *H. japonica* зүйлээс ялгаатай, харин *H. ussuriensis* хэмээх зүйлд хамаарна хэмээн үзсэн (IUCN, 2006). Сүүлийн үеийн молекул генетикийн судалгаагаар, *H. japonica* зүйлийг *Dryophytes*

төрөлд оруулж *D. japonicus* хэмээн нэрлэх болсон (Duellman *et al.*, 2016). Түүнчлэн *D. japonicus* комплекс зүйлүүдийн тархац, генетик, морфологийн ялгаатай байдлыг харгалзан салбар зүйлүүдийг тодосгох санал дэвшүүлжээ (Borzee *et al.*, 2025). Цаашид Төв Ази болон Монголд тархсан *D. japonicus* зүйлийн ангилал зүйг нарийвчлан судлах шаардлагатай.

**Таних шинж.** Биеийн урт 42.3 мм-ээс ихгүй жижиг мэлхий. Өргөн хавтгай толгойтой, урт нь их биеийн уртын 1/3-тэй тэнцүү. Сонголын хэнгэрэг тод илэрсэн, хэмжээгээр нүднээс бага. Зууван дугуй хэлбэрийн бүлтгэр нүдтэй. Өмнөд мөчид, тэдгээрийн хурууны хөгжил сайн. Хөлийн бүх хурууны өндөг нь наалдамхай зээрэнцэг хөхлөгтэй. Арьс нь гөлгөр, нуруун тал цайвар ногооноос хар ногоон. Хааяа хүрэн зүстэй бодгаль тааралдана. Эрийн хоолой хар саарал. Модны мэлхийн өнгө амархан хувьсдаг. Орчны температур, гэрэлтүүлгийн хэмжээ өндөр байхад өнгө нь цайвар ногоон байснаа шөнө сааралдуу хүрэн болно (Мөнхбаяр нар, 2023).

#### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).


**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Эмзэг (VU), D2 (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b). 2025 онд Эмзэг (VU), D2. Монгол дахь энэ зүйлийн эзлэн амьдрах нутгийн талбай 19,980 км<sup>2</sup>, одоогоор таваас цөөн байршил нутагт идээшин амьдардаг болохыг тогтоосон ч тархац нутаг нь байнга хумигдаж байгаа талаар баттай нотолгоо байхгүйгээс B1 ab (iii) шалгуураар үнэлэх боломжгүй тул D2 шалгуураар үнэлэв. Хэрэв ховордлын талаар баттай мэдээлэл хуримтлагдвал дахин үнэлж, ховордлын зэрэглэлийг ахиулах боломжтой. Хил залгаа улс орнуудын хооронд мэдэгдэхүйц нүүдэл шилжилт үгүй тул дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Үнэлгээ хийсэн:** М.Мөнхбаатар, Х.Тэрбиш, Ж.Гүррагчаа, С.Гомбобаатар (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, Д.Золжаргал, П.Эрдэнэтүшиг, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Орос, Хятад, Монгол, Солонгосын хойг, Японд тархсан (IUCN, Conservation International and Nature Serve, 2006; IUCN, 2023).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Их төлөв гол мөрний сав дагуу, уулс хоорондын хөндий, хотсын ус, намгархаг (5.1; 5.3; 5.4; 5.7; 5.13) нутгуудаар идээшин амьдарна (Мөнхбаяр, Тэрбиш, 1997). Орхон-Сэлэнгийн бэлчир, Шаамарын Их, Бага Бүүрэг толгой, Ерөө, Хараа гол, Цөх гол, Булган аймгийн Тулгатын даваа, Дорнод аймгийн Баян-Уул сумын Онон голын хясаа, Халх гол сумын Халх голын зүүн эргээс тус тус тэмдэглэжээ (Боркин и др., 1988; Семенов и Мунхбаяр, 1996; Мөнхбаяр, Тэрбиш, 1997; Terbish *et al.*, 2006; Borkin *et al.*, 2011; Borzee *et al.*, 2019; Мөнхбаяр нар, 2023).



**Амьдралын онцлог.** Умард хэсгийн гол, мөрнүүдийн сав дагуу, өндөр өвст татмын нуга, намаг, мод, бут бүхий ус, намгархаг, чийглэг газрыг шүтэн амьдарна. Бургас, улиас, шинэс, үхрийн нүд зэрэг мод, бутны навч, мөчир, тариалангийн талбайд тохиолдоно. Борооны дараа хад, чулуун дээгүүр олноор явж таарна.

Модны мэлхий 9-р сарын сүүлийн хагаст ичээлж, 4-р сарын эцэс, 5-р сарын эхээр ичээнээс гарна (Швецов, 1973; Шкатулова и др., 1978). Мэрэгчдийн нүх, хад чулуу, мод, бут, хөвхний доорх хонгил хөндий, ан завсар зэрэг нь модны мэлхийн ичээлэх ая тухтай орчин болно. Бүрэнхий шөнийн идэвхтэй, бүрэнхийгээс үүр гэгээртэл вааглана. Хамгийн идэвхтэй үе нь 21-22 цагийн орчимд тохионо (Боркин и др., 1988). Жилд нэг удаа

тус бүр 2 мм хэмжээтэй 760 хүртэл тооны өндөг гаргана (Мөнхбаяр, 1976). 6-р сарын төгсгөлөөр шанаганцрууд үзэгдэж эхэлнэ. Модны мэлхийн авгалдай өдрийн идэвхтэй бөгөөд тэд зөвхөн урсгал усанд амьдарч усны гадаргуу орчмоор идээшилнэ. Дүрс хувирлын үйл явц 7-р сарын төгсгөлөөс 8-р сарын эцэс хүртэл үргэлжлэх бөгөөд энэ үеэс залуу бодгалиуд хуурай газрын амьдралд шилжинэ. Дүрс хувирлын дараах залуу зулзаган мэлхийн биеийн хэмжээ 20 мм-ээс хэтрэхгүй (Кузьмин, 1988; Боркин и др., 1988).

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй. Орхон голын сав, Шаамарын Их бүүрэг орчимд 1965 онд хийсэн судалгаагаар, 1,000х3 м талбайд 30 бодгаль, 1968 онд мөн дээрх нутагт адил хэмжээний талбайд 23 бодгаль тус тус тоологдсон (Мөнхбаяр, 1976; Боркин и др., 1988). 1984 онд хийсэн судалгаагаар, Шаамар орчмын янз бүрийн усан сангийн 1000 м<sup>2</sup> талбайд 6.8-60 бодгаль тэмдэглэжээ (Боркин и др., 1988). Зарим газар 100-500 хүртэл толгойгоор тохиолдоно (Боркин и др., 1988). 2000 оны эхэн үеэс тус газрын модны мэлхийн тоо эрс буурч, 1 м<sup>2</sup> талбайд 3-5 зулзаган мэлхий ажиглагдах болсон (Кузьмин, 2012).

**Ховордлын шалтгаан.** Модны мэлхий манай оронд хязгаарлагдмал тархацтай тул амьдрах орчны өөрчлөлт нь ховордлын гол шалтгаан болно. Тухайлбал, хот суурин газрын тэлэлт (1.1), ашигт малтмалын олборлолт (3.2), зам, тээвэр (4.1), түймэр (7.1.1), орчны бохирдол (9.1.3), ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (11.2) болон бусад шалтгааны (хөдөө аж ахуй (2.3.1) г.м) улмаас энэ зүйлийн тархац нутаг нь багасан хумигдах хандлагатай байна. Модны мэлхийн тоо толгой цаг агаарын төлөв байдлаас хамаарч ихээхэн хэлбэлзэнэ. Өвөл их хүйтэрсэн, эсвэл хур бороо бага жил модны мэлхийн тоо толгой эрс хорогдоно. Мөн элдэв махчид (8.1.1) тэдний тоо толгойд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлнэ (Terbish *et al.*, 2006).

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон ба ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1) агнаж, барьж болно. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газар, Хан Хэнтийн дархан цаазат газар, Онон-Болжийн байгалийн цогцолборт газруудад хамрагдсан.

#### **Хамгаалах арга хэмжээ**

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Эмзэг” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Энэ зорилгоор мониторингийн судалгааны экспедицийг улсын төсвөөр 3 жил тутамд зохион байгуулах
- Гений сан бүрдүүлэх (5.7.2)
- Хоёр нутагтны хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн судалгааг явуулах
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 2.5. ШИВЭР МЭЛХИЙ

### *Rana amurensis* (Boulenger, 1886)

**Баг:** Сүүлгүй хоёр нутагтан (Anura)

**Овог:** Мэлхий (Ranidae)

**Англи нэр:** Siberian Wood Frog

**Ижил нэр:** *Rana temporaria* (Linnaeus, 1758) (Никольский, 1905; Шагдарсүрэн, 1958); *Rana asiatica* (Bedriaga, 1898) (Никольский, 1914; Царевский, 1930; Гумилевский, 1932); *Rana chensinensis* (David, 1876) (Банников, 1958; Мөнхбаяр, 1962; 1968; 1970; Obst, 1962); *Rana cruenta* (Pallas, 1814) (Мөнхбаяр, 1976); Khabarovsk Frog.



**Ангилал зүйн тойм.** Энэ зүйлийг *R. a. amurensis*, *R. a. coreana* хэмээх хоёр салбар зүйлд ялгаж ирсэн боловч *R. a. coreana*-г бие даасан *Rana coreana* зүйл болохыг нь тогтоожээ (Song et al., 2006). Одоогийн байдлаар *Rana amurensis* зүйл нь өөр салбар зүйлд хуваагдаагүй байна (Кузьмин и др., 2017).

**Таних шинж.** Биеийн урт нь 78 мм. Хоншоор үл ялиг шөвгөр. Биеийн хоёр хажуу, нурууны хойд хэсэг, хөл гуяны дээгүүр улаан өнгийн олон тооны мөхлөгөн гөвдрүүтэй. Нурууны

хажуугийн хуниасны хоорондуур жижиг төвгөрүүдтэй. Тэр нь зарим бодгальд хоорондоо нийлсэн. Нурууны хажуугийн хуниас нь цайвар шаргал, биеийн дээд тал нь хулсан шар, хэвлий нь том улаан цоохор толботой. Харин 2008 онд Хараа голын цутгал Шатангийн голын шивэр мэлхийн популяцийн дотроос альбинизмын үзэгдэл илэрсэн. Энэ нь зөвхөн манай орны төдийгүй энэ зүйлийн дэлхийн ариалын хэмжээнд анх удаа гарсан тохиолдол юм. Биеийн зүсийг тодорхойлдог нөсөөт бодисын өөрчлөлтөөр шингэн ягаан, шаравтар арьстай, час улаан

нүдтэй бодгаль олдсон (Мөнхбаяр нар, 2023).

#### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).


2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

**Үнэлгээ хийсэн:** Х.Тэрбиш, П. Эрдэнэтүшиг, Г.Онолрагчаа, М.Бүрнээ (2025).

**Үнэлгээ хянасан:** Х.Мөнхбаяр, М.Мөнхбаатар, П.Золжаргал, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Орос, Хятад, Монгол, Солонгосын хойг болон Казахстанд байх боломжтой (IUCN, Conservation International and Nature Serve, 2006; IUCN, 2023).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Тархац нутаг, амьдрах орчны хэлбэрээр *Bufo raddei* зүйлийн бахтай ойролцоо бөгөөд тал хээр, ойт хээрийн бүсийн ус намгархаг (5.1; 5.3; 5.4; 5.7; 5.13) нутгуудаар байршина (Боркин и др., 1988). Хангайн нурууны дорнод хэсэг, Хэнтийн нуруу, Монгол Дагуурын хээр, Их Хянганы уулсаар тархсан. Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ, Номхон далайн ай савын Онон, Хэрлэн, Халх, Нөмрөг гол, тэдгээрийн цутгалуудын дагуу нутагшин амьдарна (Боркин и др., 1988; Terbish *et al.*, 2006). Өгий, Буйр зэрэг тал газрын нуурууд, ус намгархаг газарт элбэг. Монгол оронд далайн түвшнээс дээш 580-1,200 м өндөрт тохиолдоно (Боркин и др., 1988).



**Амьдралын онцлог.** Гол мөрөн, нуур цөөрмийн эрэг орчим, намгархаг газар, ялангуяа эгс, хулстай тогтмол усанд элбэг

тохиолдоно. Элдэв шавж, аалз, нялцгай биетнээр голчлон хооллоно. Шанаганцар нь замаг, жижиг шавж, хорхойг иднэ. Ихэвчлэн өдрийн идэвхтэй. Намрын дунд сарын эхнээс хаврын дунд сар хүртэл ичээнд орно. Үржих хугацаа нь Монгол орны хувьд 4-р сарын эцсээс 5-р сарын дунд үе юм. Өндөгнөөс 6-р сарын эхээр шанаганцар гарч, улмаар хөгжсөөр мэлхийнцэр болж 7-р сард хуурай газарт шилжинэ.

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй. Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл (Terbish *et al.*, 2006a).

**Ховордлын шалтгаан.** Олон янзын амьдрах орчинд нэлээд өргөн тархацтай тул ховордуулах шалтгаан мөн л төдий олон янз. Тухайлбал хот суурин газрын тэлэлт (1.4), ашигт малтмалын олборлолт (1.3), зам, тээвэр (1.4.4), түймэр (7.4), орчны бохирдол (6.2; 6.3), ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (7.1; 7.3), хөдөө аж ахуй (1.1; 1.1.4) зэрэг шалтгааны улмаас тархац нутаг нь багасан хумигдах хандлагатай ч, одоогоор энэ зүйлийг ховордуулах хэмжээнд хүрээгүй (Terbish *et al.*, 2006a) гэж үзжээ.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Шивэр мэлхийн тархац нутгийн зарим хэсэг Хан Хэнтийн дархан цаазат газар, Горхи-Тэрэлж, Онон-Болжийн байгалийн цогцолборт газрууд болон Тосон Хулстай, Яхь нуур, Хар Ямаатын байгалийн нөөц газруудад хамрагджээ.

**Хамгаалах арга хэмжээ.** Хоёр нутагтны хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.3), энэ зүйлийн хамгааллын менежментийг зохион байгуулах, биологи, экологийн (3.3) судалгаа явуулах.

## 2.6. ДОРНОДЫН МЭЛХИЙ

### *Rana chensinensis* (David, 1875)

**Баг:** Сүүлгүй хоёр нутагтан (Anura)

**Овог:** Мэлхий (Ranidae)

**Англи нэр:** Asiatic Grass Frog

**Ижил нэр:** *Rana nigromaculata* (Hallowell, 1860) (Мөнхбаяр, Эрэгдэндагва, 1970); Chinese Brown Frog.



**Ангилал зүйн тойм.** Палеарктикт нэн өргөн тархацтай энэ зүйл мэлхийн ангилал зүйн асуудал нэлээд маргаантай. Тухайлбал, *Rana chensinensis* хэмээх энэ мэлхийг судлаачид өөр өөр зүйлд хамааруулан *R. dybowskii* (Gunter, 1876), *R. semiplicata*, *R. temporaria* (Nikolsky, 1918) гэх зэргээр бичиж байв. Ер нь *Rana chensinensis* 24 хромосомтой байдгаараа бор мэлхийн бүлгийн бусад зүйлээс эрс ялгагддаг (Боркин, 1975). Одоо ч энэ бүлэг мэлхийн ангилал зүйн асуудал бүрэн гүйцэд шийдэгдээгүй (AmphibiaWeb, 2006; IUCN, 2007). Кариологийн судалгааны дүнгээс үзэхэд, Монгол оронд тархсан шивэр мэлхий болон дорнодын мэлхий хоёр нь тус тусдаа бие даасан зүйл болох нь эргэлзээгүй. Монгол оронд амьдардаг энэ зүйлийн ангилал зүйг цаашид нарийвчлан судлах шаардлагатай. Учир нь Дарьганга болон Их Хянганы уулсаар тусгаарлагдсан популяци амьдарч байгаа бөгөөд тэд генетикийн хувьд хоорондоо ялгаатай салбар зүйл, эсвэл бүр бие даасан зүйл ч байх магадлалтай.

**Таних шинж.** Биеийн урт 64 мм. Нуруу, биеийн хажуу олон тооны жижиг мөхлөгүүдтэй бөгөөд тэдгээрийн зарим нь хоорондоо нийлж далны орчимд Л хэлбэртэй өнцөг үүсгэнэ. Биеийн ерөнхий зүс бор. Нуруу ба хажуу талын төвгөрүүдийг тойрсон бараан толботой. Гуяны дээгүүр хэд хэдэн хөндлөн хар судалтай. Нүдний өмнөд өнцгөөс эхэлсэн бараан судал хамрын сүвийг дайран улам бүдгэрсээр хоншоорын үзүүр хүрнэ. Дээд уруулын дагуу тууш цайвар судалтай. Далны орчмоор бараан судалтай. Нурууны хажуугийн хуниас цайвар. Гуяны дотор тал ногоовтор, хэвлий нь цайвар, эм мэлхийн хэвлий ягаавтар туяатай (Боркин и др., 1988; Мөнхбаатар, 2004).

#### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Эмзэг (VU), B1ab(iii) (Terbish et al., 2006a; Terbish et al., 2006b).

2025 онд Эмзэг (VU), B1ab(iii). Дорнод Монголын бүс нутагт Дагшийн гол, Хусын гол, Халхын гол, Азаргын гол, Хөх нуур, Дэгээ гол, Хонгорын гол, Матад сумын нутаг зэрэг 9 газраас энэ зүйл мэлхийг тэмдэглэсэн. Амьдрах орчны бохирдол, хүн амын суурьшил, түймэр, малын тоо толгойн өсөлт, бэлчээрийн талхагдал зэрэг шалтгааны улмаас энэ зүйлийн тархац нутаг хумигдаж байгааг харгалзан B1ab(iii) шалгуураар үнэлж, Эмзэг зэрэглэлд оруулав. Энэ зүйлийн популяцийн тоо толгой буурч байгаа талаар зарим мэдээ материал нийтлэгдсэний зэрэгцээ бие биеэс алслагдан тусгаарлагдсан хоёр популяци Монголд амьдардаг болохыг тогтоосон. Хэрэв энэ

зүйлийн тоо толгойн хомсдол, амьдрах орчны доройтлын талаар илүү нарийвчилсан нотолгоо байвал А шалгуураар дахин үнэлж ховордлын зэрэглэлийг ахиулах боломжтой. Хил залгаа улс орнуудаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшилт үгүй тул бүс нутгийн дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Үнэлгээ хийсэн:** М.Мөнхбаатар, Х.Тэрбиш, П.Золжаргал (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Ж.Гуррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025)

**Дэлхийн тархац.** Хятад, Монгол, Хойд Солонгос, Орост тархсан (IUCN, Conservation International and Nature Serve, 2006; IUCN, 2023).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Ойт хээр, хээрийн бүсийн цэнгэг устай гол нуур, булаг шанд, намгархаг (5.4; 5.7) газрыг шүтэн амьдарна (Мөнхбаатар, 2004). Монгол орны дорнод хэсэгт Их Хянганы уулс, Халх голын сав, Буйр нуур болон Дарьгангын галт уулын бүс нутагт тусгаарлагдсан популяци амьдардаг (Боркин и др., 1988; Семенов, Мөнхбаяр, 1996; Мөнхбаатар, 2004; Conservation International and Nature Serve, 2006; IUCN, 2007). Сүхбаатар аймгийн Ганга нуур, Дагш гол, Дуут нуур, Хөх нуур зэрэг газраас тэмдэглэжээ (Мөнхбаяр, Тэрбиш, 1997). Хонгор, Ар Нөмрөг, Хус, Бичигт, Азарга, Дэгээ, Халх гол, тэдгээрийн цутгалуудаар тархсан. Монголд далайн түвшнээс дээш 583-1,500 м өндөрт тохиолдоно (Боркин и др., 1988). Монгол оронд нийт 19,995 км<sup>2</sup> талбайд тархсан хэмээн үнэлсэн. Дорнодын мэлхий тал хээрийн гол, нуур, цөөрмийн зэгс, шагшуурга, дов сондуул бүхий ус, намгархаг газрыг түшин амьдарна. Голын эргээр яваа хүн малын хөлийн чимээгээр ус руу үсрэн орж эрэг доогуур нуугдана. Энэ мэлхий Дорнод Монголд Дарьгангаас Нөмрөгийн гол хүртэл тархсан боловч газар сайгүй байдаггүй, харин наран эзвэр, тунгалаг тогтмол ус, гол горхины тогтуун урсгалтай хэсэг, булан тохойгоор тохиолдоно. Оросын судлаач Е.В. Ротшильдийн аман мэдээгээр, Дарьгангад энэ мэлхий харуй бүрийгээр идэвхтэй байжээ. Харин 1999 оны 6-р сарын сүүлчээр Нөмрөгийн голын салаа, Нарийн

голд үдээс хойш 3-4 цагийн үед идэвхтэй бодгалиуд ажиглагдсан (Мөнхбаатар, 2004).



**Амьдралын онцлог.** Улирлын идэвхийн талаар Монгол оронд судалгааны материал байхгүй. Гэвч идэвхтэй бодгалийг 10-р сарын 17-ны өдөр Дарьгангаас тэмдэглэж (Мөнхбаатар, 2004) байжээ. Алс Дорнодод хийсэн судалгаанаас үзэхэд, энэ мэлхий гол горхины хайргатай ёроолд шурган өвөлждөг (Боркин и др., 1988; IUCN, Conservation International and Nature Serve, 2006). Хөгжлийн байдлаас үзэхэд, хавар эрт түрсээ шахдаг бололтой. Дарьганга орчимд 2002 оны 5-р сарын эхээр энэ зүйл мэлхий голын эргийн мөсөн дор нуугдаж идэвхгүй, хөдөлгөөнгүй байсан бөгөөд харин усны гүехэн, наран эзвэр гадар төрцөө шахсан байлаа. Нэг мэлхийн гаргасан төрцийг тоолж үзэхэд, 1,800 орчим байв. Дорнодын мэлхий энэ хугацаанд төрцөө бараг шахаж дуусдаг бололтой. Учир нь судалсан 2 эмийн өндөгний хоолойд нэгд нь 73, нөгөөд нь 26 ширхэг төрц үлдсэн байлаа. Хятадын Бээжин хотын ойролцоох усан сангуудад дорнодын мэлхий 3-р сард, Сычуань, Төвөдийн өндөрлөгийн зүүн бүс нутгуудад 6-р сарын эцсээр тус тус үржиж эхэлдэг (Lui and Hu, 1961; Lui, 1950). Харин Оросын Алс Дорнодод 4-р сард ичээнээс гарсны дараа шууд төрцөө шахдаг бөгөөд 2,100-3,500 хүртэл тооны өндөг гаргана (Коротков, 1974). 7-р сарын хоёрдугаар хагаст Их Хянганы нурууны Нөмрөг орчимд хөгжлийн янз бүрийн шатанд байгаа шанаганцар олноор тохиолдсон (Мөнхбаатар, 2004). Элдэв зүйлийн замаг, ургамлын ялзарсан үлдэгдэл, дээд ургамлын эд, эрхтний хэсгээр хооллоно. Харин бие гүйцсэн мэлхий төрөл бүрийн сээр нуруугүй амьтдаар

хооллоно. Дарьганга болон Нөмрөгийн голын популяцийн 1 ба түүнээс дээш насны бодгалиудын идэш тэжээлд хажуу хөвөгч хавчнууд (*Gammaridae*), элдэв аалз, хачиг, *Myriapoda*, *Collembola*, *Aphidinea*, *Cicadodea*, *Lepidoptera*, *Coleoptera*, *Hymenoptera*, *Diptera* мэтийн төрөл бүрийн бүлгийн сээр нуруугүй амьтад зонхилно (Боркин и др., 1988; AmphibiaWeb, 2006).

**Тоо толгой, нягтшил.** Монгол орны популяцийг жижиг популяци гэж үздэг (Terbish *et al.*, 2006) бөгөөд одоогоор энэ зүйлийн популяцийн хэмжээний талаарх мэдээлэл тодорхойгүй. Дагш голд хийсэн судалгаагаар, 1 км урт трансектэд 60, Дарьгангад 100 м трансектэд 34 (үржлийн үе), Их хянганы уулст хоёр өдрийн ажиглалтаар 20 бодгаль тус тус тоологдсон (Мөнхбаяр, 1976; Батсайхан аман мэдээ). 1999 оны 6-р сард Нөмрөгийн голд баруун талаас цутгадаг Нарийн голын эргээр 1 км замналд дунджаар 10 гаруй бодгаль, 2002 оны 5-р сарын сүүлээр Ханын голд 500 м замналд 35 орчим бодгаль тэмдэглэгдэж (Мөнхбаатар, 2004) байжээ.

**Ховордлын шалтгаан.** Хязгаарлагдмал тархац нутаг болон популяц бүхий энэ зүйл ган (7.1), зуд, хуурайшилт (7.3) зэрэг цаг уурын эрс өөрчлөлт, онцгой үзэгдэлд нэн мэдрэмтгий, эмзэг. Сүүлийн жилүүдэд энэ зүйлийн тархац нутгийн хүрээнд хот суурин газрын тэлэлт (1.4), ашигт малтмалын олборлолт (1.3), зам, тээвэр (1.4.4), түймэр (7.4), усан орчны бохирдол (6.3), ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (11.2), хөдөө аж ахуй (1.1) зэрэг шалтгааны улмаас тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь буурах хандлагатай (Terbish *et al.*, 2006) байна.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг

зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон ба ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1) агнаж, барьж болно. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Нөмрөгийн дархан цаазат газарт хамрагдсан.

Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгдсэн (Мөнхбаяр нар, 2016).

#### **Хамгаалах арга хэмжээ**

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Эмзэг” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Энэ зорилгоор мониторингийн судалгааны экспедицийг улсын төсвөөр 3 жил тутамд зохион байгуулах
- Гений сан бүрдүүлэх (5.7.2)
- Хоёр нутагтны хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 2.7. ШӨВГӨР МЭЛХИЙ

### *Rana arvalis* (Nilsson, 1842)

**Баг:** Сүүлгүй хоёр нутагтан (Anura)

**Овог:** Мэлхий (Ranidae)

**Англи нэр:** Moor Frog

**Ижил нэр:** *Rana altaica* (Kashchenko, 1909); *Rana angustifrons* (Thomas, 1855); *Rana arvalis* ssp. *altaica* (Kashchenko, 1899); *Rana arvalis* ssp. *wolterstorffi* (Fejérváry, 1919); *Rana oxyrhina* (Filippi, 1865); *Rana oxyrhinus* var. *striatus* (Koch, 1872); *Rana oxyrhinus* (Steenstrup, 1847); *Rana terrestris* (Andrzejowski, 1832); Altai Brown Frog.

**Ангилал зүйн тойм.** Энэ зүйлийн ангилал зүйн судалгаа Монгол орны хувьд бүрэн гүйцэд хийгдээгүй.

**Таних шинж.** Биеийн хэмжээ 36-84 мм. Бидэнд олдсон шөвгөр мэлхийн хамгийн томынх нь биеийн урт 43.4 мм. Нуруун тал нь их төлөв хар хүрэн, эсвэл бор хүрэн зүстэй ба хөх толботой. Шөвгөр хоншоортой. Хэвлий нь цайвар ч шингэн ягаавтар туяатай. Монгол орны гурван зүйл мэлхий цөм өвсний мэлхийн экологийн бүлэгт багтана. Өвсний мэлхий ихэвчлэн бор шарга, харин усны мэлхий ногоон зүстэй. Бор шарга зүстэй, хэвлий тал нь толбогүй, шингэн ягаандуу туяатай, нуруун дээгүүрээ тууш цуварсан гөвгөрүүдтэй, толгойн ар талд “Л” үсгийн хэлбэртэй төвгөртэй. Зарим бодгаль нь нурууны голоор тууш цайвар судалтай, мөнөөх “Л” үсэг мэт төвгөргүй. Бүх олдворын урьд хөлийн угт тод хар зураастай, хойд хөлийн 5-р хурууны ар талд орших өсгийн дотоод төвгөр мэдэгдэхүйц том, хавтгай зэрэг онцлогтой. Өсгийн дотоод төвгөр нь шивэр мэлхий, дорнодын мэлхий хоёрт жижигхэн. Энэ нь шөвгөр мэлхийг дээрх хоёр зүйлээс ялгах гол шинж болно. Нэг популяцийн дотор нурууны голоор тууш цайвар судалтай болон судалгүй, нуруун дээгүүрээ олон гөвгөрүүдтэй бодгалиуд холилдон орших нь сонирхолтой. Гэвч митохондрийн ДНХ-ийн судалгаагаар, тэдгээр нь хоорондоо ямар ч ялгаагүй болох нь тодорхой болсон. Нурууны голоор цайвар судалтай бодгалиуд нь шивэр мэлхийтэй, толгойн ар талд “Л” үсгийн хэлбэртэй болон арьсны тууш гөвгөрүүдтэй, нурууны голоор



цайвар судалгүй бодгалиуд нь дорнодын мэлхийтэй төстэй.

#### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).


**Бүс нутгийн үнэлгээ:** 2025 онд Үнэлэх боломжгүй (NA) зэрэглэлээр үнэлэв. Монголд анх удаа 2019 онд тэмдэглэгдсэн. Ийнхүү энэ зүйлийг одоогоор ганцхан байршил нутагт идээшин амьдарч байгааг тогтоосон хэдий ч эзлэн амьдрах талбайн хэмжээ болон тархац нутаг нь байнга хумигдаж байгаа талаар баттай нотолгоо байхгүй тул дээрх зэрэглэлд оруулав.

**Үнэлгээ хийсэн:** М.Мөнхбаатар, Х.Тэрбиш, П.Золжаргал (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Европын хойд, төв болон зүүн хэсгийн ихэнх хэсэгт Австри, Беларус, Бельги, Хрват, Чех, Дани, Эстони, Финлянд, Франц, Герман, Унгар, Латви, Литва, Молдав, Недерланд, Норвеги, Румын, Словак, Швед, Украин, зүүн Казахстан, Оросын Байгаль нуур, Якут, Хятадын Шиньжаны нутгаар тархжээ (IUCN, 2023).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол оронд анх удаа 2019 оны 7-р сард Хөвсгөл аймгийн Улаан Уул сумын нутаг Улаан Тайга, Хар Бусын голын саваас тэмдэглэсэн. Улаан тайгын өндөрлөг уулсын жижиг гол (5.1), голын татмын нуга, ус намгархаг (5.3; 5.4; 5.7; 5.11; 5.13) газрууд, ойт хээрийн жижиг нуур, цөөрөмд (5.7) тохиолдоно (Munkhbaatar *et al.*, 2020).



**Амьдралын онцлог.** Биологи, экологийн асуудал Монгол орны нөхцөлд одоогоор судлагдаагүй. Харин 2019 оны 7-р сарын эхээр бидний судалгаа явуулсан нутагт шөвгөр мэлхийн үржлийн үе төгсөж, шанаганцрын шатнаас дөнгөж гарсан жижиг мэлхий усны эрэг рүү гарч байгаа нь ажиглагдсан. Нилээн дулаанд дуртай зүйл. Бие гүйцсэн бодгалиуд үүрээр болон оройн харуй бүрийгээр +25+30°C-д идэвхжинэ. Үржлийнхээ үед 24 цагийн идэвхтэй. Орчин тааламжтай үед шилжилт хөдөлгөөн их хийхгүй. Амьдралынхаа туршид үржлээс бусад үед хуурай газартай холбоотой амьдарна. Мод, бутны ёроол, хөндий, унасан навч, чулуун дор орогноно. Элдэв амьтдын нүх, үүрэнд өвөлжинө. Тархац нутгийнхаа хэмжээнд далайн түвшнээс дээш 800-2,140 м өндөрт амьдарна (Munkhbaatar *et al.*, 2020).

**Тоо толгой, нягтшил.** Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаарх судалгаа манай оронд хийгдээгүй байна.

**Ховордлын шалтгаан.** Энэ зүйл нь хязгаарлагдмал тархац нутагтай, тусгаарлагдмал популяци тул ашигт малтмалын олборлолт (1.3.1), зам, тээвэр (1.4.4), түймэр (7.4), ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (7.4; 7.7) зэргээс шалтгаалан тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь буурах магадлалтай.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Шөвгөр мэлхийн үндсэн тархац нутаг Улаан тайгын дархан цаазат газар болон Тэнгис-Шишгэдийн байгалийн нөөц газарт хамрагджээ.

#### Хамгаалах арга хэмжээ

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Үнэлэх боломжгүй” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Энэ зорилгоор мониторингийн судалгааны экспедицийг улсын төсвөөр 3 жил тутамд зохион байгуулах
- Гений сан бүрдүүлэх (5.7.2)
- Хоёр нутагтны хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй.



## **ГУРАВДУГААРБҮЛЭГ**

**МОНГОЛ ОРНЫ МӨЛХӨГЧДИЙН АНГИЙН  
ГҮРВЭЛИЙН САЛБАР БАГИЙН АМЬТДЫН  
БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ**

## 3.1. НОХОЙ ГҮРВЭЛ

### *Teratoscincus przewalskii* (Strauch, 1887)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Геккон гүрвэл (Gekkonidae)

**Англи нэр:** Plate-tailed Gecko

**Ижил нэр:** *Teratoscincus* sp. (Эрэгдэндагва, 1961); *Teratoscincus scincus* (Мөнхбаяр, 1962); *Teratoscincus przewalskii* (Obst, 1962).



**Ангилал зүйн тойм.** Нохой гүрвэл (*Teratoscincus przewalskii*) нь Дундад Азийн бүс нутагт тархсан *T. scincus* болон *T. roborowskii* зэрэг зүйлүүдтэй удам төрлийн хувьд ойролцоо зүйл хэмээн үздэг. Одоогоор салбар зүйлийг ялгаагүй.

**Таних шинж.** Их биеийн урт 92 мм. Том толгойтой, их бие нь бөөрөнхийвтөр ба нуруу, их биеийн хайрс нь хэмжээгээр хэвлийнхээс жижиг, олон хар цэгтэй, хэвлийн хайрс нь тийм хар цэггүй учир гөлгөр цагаан, сүүл нь махлаг, маш амархан хугарч унана. Сүүлийн урт их биеийн уртаас ямагт богино, сүүлийн дунд хэсгээс үзүүр хүртэл бие биеэ дэрлэж тогтсон хумс мэт хавтгай том хайрстай. Нүд нь бүлтгэр том, түүний голч нь 5.3 мм хүрнэ. Чихний хоёр сүв нь хоорондоо таславчгүй учир гэрэл нэвт харагдана. Цайвар шаргал зүстэй, санчиг, хүзүүн дээгүүрээ хөндлөн бор хүрэн толботой, энэ нь их бие, нурууны дагуу хойшлох тутам цайвар хүрэн болно. Сүүлийн угаас хумслаг хайрс хүртэлх зайнд хөндлөн тогтсон хоёр бүдэг цайвар хүрэн

толботой, хэвлий нь үл мэдэг шаравтар туяатай цагаан цайвар. Болгоомжгүй чанга бариваас арьс нь зулгарч гэмтэхээс гадна, сүүл нь амархан тасарна.

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Terbish et al., 2006a).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Уламжлалт анагаах ухаанд ашиглах байдал ажиглагдаагүй. Харин амьтны дэлгүүрт худалдаалах, сонирхлын үүднээс орон гэртээ байлган тэжээх явдал хааяа ажиглагдаж байна. Хэрэв эдгээр үйл явц эрчимжвэл нохой гүрвэлийн популяцийн тоо толгой буурах магадлалтай. Популяцийн чиг хандлага, тоо толгой одоогоор тодорхойгүй байгаа ч Хятадад энэ зүйлийн тоо толгой өндөр байгааг тооцвол, хөрш улсын популяциас тэтгэгдэх боломжтой. Энэ зүйлийг одоогоор Ховордож болзошгүй зэрэглэлд оруулсан ч цаашид худалдаалах үйл явц эрчимжих эсвэл Хятадын популяцийн тоо толгой буурвал А шалгуураар (популяцийн бууралт) дахин үнэлж ховордлын зэрэглэлийг ахиулах боломжтой. Популяцийн хэмжээ, чиг хандлагыг цаашид нарийвчлан судлах шаардлагатай.


**Үнэлгээ хийсэн:** Х.Тэрбиш, М.Мөнхбаатар, Г.Довчиндорж, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, П.Золжаргал, Г.Онолрагчаа, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Хятадын Өвөр Монголын өөртөө засах орон, Гансу мужийн хойд хэсэг,

Шинжаан-Уйгарын өөртөө засах орны Хами орчмын цөлийн бүс нутгаар тархжээ.

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Алтайн өвөр болон Галбын говийн бүс нутагт тархсан. Хойд говийн Баян загт тэмдэглэсэн тухай мэдээг нягтлах шаардлагатай. Хармаг, сухай, заг бүхий манхан, эсвэл молцог элстэй орчинд (8.1; 8.2) их төлөв идээшин амьдарна. Шөнө гөрөөлөх үедээ цөлийн уулсын бэл, хайргат цөлөөр мөлхөнө.



**Амьдралын онцлог.** Шөнийн амьдралтай, өдрийн цагаар заг зэрэг мод, бутлаг ургамлын үндсэнд ухсан нүх болон чулуу, шаврын ан завсар орогноно. Заримдаа газрын хөрсийг налуулж малтсан нүхэнд өдрийг өнгөрүүлнэ. Шөнийн харанхуйд нохой гүрвэлтэй газар гар чийдэнгээр гэрэлтүүлэхэд нүд нь бадмаараг мэт хоёр улаан цэг харагдана. Элдэв шавж хорхой, аалз хэлбэртэн тухайлбал, загийн шар, яггүй хортой ямаан ууцыг хүртэл иднэ. Зуны сүүл сард хоёр өндөг гаргаж үржих ба ихэвчлэн 8-р сарын эхээр өндөгнөөс үрвэл төрнө.

**Тоо толгой, нягтшил.** Алтайн Өвөр говьд харьцангуй элбэг. Эхийн голд хийсэн судалгаагаар, 18-19 бодгаль/га нягтшилтай амьдарна. Замын хүрэн элс орчмын нутагт зөөлөн бороотой үед 1.5 цагт сухай, хармагийн бутны дор идэвхтэй гүрвэл 22-ийг ажиглажээ (Ананьева и др., 1997). Ш.Болдбаатар Зээмэгийн говьд 22-24 цагийн хугацаанд 27 бодгаль тоолсон байна (Мөнхбаяр, 1976).

**Ховордлын шалтгаан.** Судалгааны мэдээ баримт хомс. Хэт хүйтрэл (7.3) зэрэг

байгалийн гэнэтийн үзэгдлийн улмаас ичээндээ бөөнөөр хорогдож болно. Шөнийн махчин шувууд, үнэг, хярс, дэлдэн зараа (8.2) барьж идсэнээр түүний тоо толгойд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн үндсэн тархац нутаг Говийн Их дархан цаазат газрын "А" хэсэг, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар, Говийн Бага дархан цаазат газрын "А" болон "Б" хэсэгт тус тус хамрагджээ.

#### Хамгаалах арга хэмжээ

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр "Ховордож болзошгүй" хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг үндэсний бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судлах, ер нь судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Энэ зорилгоор мониторингийн судалгааны экспедицийг улсын төсвөөр 3 жил тутамд зохион байгуулах
- Зүйлд чиглэсэн гений санг бүрдүүлэх (3.4.2) арга хэмжээг зохион байгуулах
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.2. ТӨМӨР ГҮРВЭЛ

### *Alsophylax pipiens* (Pallas, 1827)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Геккон гүрвэл (Gekkonidae)

**Англи нэр:** Kaspischer Even-fingered Gecko

**Ижил нэр:** *Lacerta pipiens* (Pallas, 1827); *Alsophylax macrotis* (Boulenger, 1885).



**Ангилал зүйн тойм.** Монотип зүйл. Төрөл дотроо Кашгарт тархсан *A. przewalskii* хэмээх зүйлтэй хамгийн ойр гэж үздэг.

**Таних шинж.** Их биеийн урт 4.1 см. Сүүлний урт их биетэйгээ бараг тэнцүү. Толгой, бие нь хавтгай. Нуруун тал нь жижиг мөхлөгөн хайрсаар бүрхэгдсэн бөгөөд тэдний дунд хэмжээгээр том дугариг тав мэт цайвардуу өнгийн хайрс товойн гарсан. Энэ төвгөр хайрснууд нь хөндлөн эгнээ үүсгэн байрлаагүй байх бөгөөд хоорондын зай нь тэдгээрийн голчоос илүү. Хэвлийн

хайрс хажуугийнхаас том, хоолойн хайрс нь нурууны төвгөр хайрсны хоорондох мөхлөгөн хайрстай адил жижиг. Хөлийн хуруунууд хажуугаараа эвэрлэг шүдлэггүй, хамрын сүв нь эрүүн завсрын болон дээд уруулын нэгдүгээр хайрсны завсар орж тогтсон. Төмөр гүрвэл цайвар хөхдүү зүстэй, их биеийн дээгүүр бүдэг бараан хүрэн өнгийн 5 хүртэлх тооны хөндлөн судалтай. Ийм судал сүүл, мөчдийн дээгүүр ажиглагдана. Хэвлий нь цайвар шаргал. Толгойн хоёр хажуугаар шаравтар өнгийн тууш судал хамрын сүвнээс нүд хүртэл үргэлжилнэ.

### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Тэрбиш нар, 2006а; Terbish *et al.*, 2006а).


2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Цөлийн бүсийн янз бүрийн амьдрах орчинд, өргөн уудам нутаг тархсан, тоо толгой элбэг зүйл. Хүний үйл ажиллагаа, үйлдвэрлэл, техникийн нөлөөнд өртөмтгий бус.

**Үнэлгээ хийсэн:** Х.Тэрбиш, М.Мөнхбаатар, Г.Довчиндорж, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Золжаргал, Г.Онолрагчаа, Г.Довчиндорж, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Орос (Волга мөрөн Уралын нурууны хооронд), Ираны зүүн умард нутаг, Казахстан (Каспын тэнгисээс Зайсан нуур), Туркменистаны умард хэсэг, Узбекистан, Афганистаны умард хэсэг, Хятадын баруун умард нутаг, Монголын өмнөд нутгаар (Говь цөл) (Банников и др., 1977; Щербак и Голубев, 1986; Ананьева и Орлов, 1995; Uetz *et al.*, 2006) тархжээ. Энэ зүйлийн Монгол орны тархац нь дэлхийн тархцын дорнод хил болдог.

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Алтайн Өвөр говь, Монгол Алтайн нурууны өмнөд хэсэг, Говь Алтайн нуруу, Зүүнгарын говь, Хойд говь, Алашаа говь, Дорнод говийн нутгаар тархжээ (Ананьева и др., 1997; Terbish *et al.*, 2006а). Энэ зүйлийн Монгол дахь тархан идээших талбай 416,793.0 орчим км<sup>2</sup> (Terbish *et al.*, 2006а). Цөл, цөлөрхөг хээрийн хад, чулуутай уулс, толгодын бэл, энгэр хажуугаар далайн түвшнээс дээш 600-1,550 м өндөрт нутаглана (Тэрбиш, 1989; Ананьева и др., 1997).



**Амьдралын онцлог.** Цав толгодын хормой бэлээр хад чулуутай хайрга (6), шаварлаг эрэг ганга, сийрэг бут сөөгтэй (3.4) газар амьдарна. Олноороо нэг дор тохиолдох, нэг ерөнхий үүрэнд өндөглөсөн байхаас үзвэл, бүлийн амьдралтай байх боломжтой. Шөнийн идэвхтэй, өдрийн цагт голдуу чулуун дор орогноно. Ихэнхдээ ямаан ууц хэмээх хортой аалзтай хамт байх нь элбэгээс үзэхэд, тэдний хооронд хам амьдралын ямар нэгэн холбоо байж таарна. Жижиг шавжаар голдуу хооллоно. Өндөглөж үржинэ. Нэг, эсвэл хоёр өндөг гаргана. Ихэвчлэн 7-р сарын эцсээс 8-р сарын дундуур өндөгнөөс гүрвэл гарна.

**Тоо толгой, нягтшил.** Алтайн Өвөр говьд өдөр 100 м маршрутад хад чулуу, унасан загийн дороос 5-12 тооны бодгаль ажиглах боломжтой. Мөн хад чулууны ан цавд 8-12 хүртэл тоогоор бүүрлэн амьдрах нь бий. Алтайн Ар говийн Баян тээг орчмын нутагт 50 м<sup>2</sup> талбайд 2-3 хүртэл бодгаль хавтгай чулуун дор тохиолдоно.

**Ховордлын шалтгаан.** Тархац нутаг, тоо толгой, нягтшилд сөрөг нөлөөтэй бодит шалтгаан, хүчин зүйл одоогоор үгүй. Гэвч уул уурхай, ашигт малтмал (1.3.1) зэрэг байгалийн нөөцийн олборлолтын үйл ажиллагааны улмаас түүний амьдрах орчин эвдрэн доройтох магадлалтай.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн үндсэн тархац нутаг Говийн Их дархан цаазат газрын "А", "Б" хэсэг, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар, Говийн Бага дархан цаазат газрын "А" болон "Б" хэсэгт тус тус хамрагджээ.

**Хамгаалах арга хэмжээ.** Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа гүйцэтгэх шаардлагатай.

### 3.3. ГОВИЙН МАХИР ХУРУУТ ГҮРВЭЛ

#### *Tenuidactylus elongatus* (Blanford, 1875)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Геккон гүрвэл (Gekkonidae)

**Англи нэр:** Gobi Naked-toed Gecko

**Ижил нэр:** *Cyrtopodion elongatum* (Blanford, 1875); *Gymnodactylus elongatus* (Boulenger, 1885); *Gymnodactylus elongatus* (Мунхбаяр, 1976); *Cyrtodactylus elongatus* (Zhao and Adler, 1993); *Tenuidactylus elongatus* (Щербак и Голубев, 1984); *Cyrtopodion elongatus* (Мунхбаяр и Тэрбиш, 1988; Ананьева и др., 1997; Тэрбиш нар, 2006а; Terbish *et al.*, 2006а; Terbish *et al.*, 2006b).



**Ангилал зүйн тойм.** Энэ гүрвэл нь *Cyrtopodion agamuroides*, *C. scaber*, *C. montiumsalsorum*, *C. kachensis*, *C. watsoni* зэрэг зүйлийн хамт нэг бүлэгт хамаарах монотип зүйл. Н.Н. Щербак, М.Л. Голубев (1986) нар геккон овгийн гүрвэлийн талаар хийсэн судалгааны үр дүнд *Cyrtopodion*-ийг *Tenuidactylus* төрөлд хамаарах дэд төрөл хэмээн ангилжээ. Гэвч махир хуруут гүрвэлийн бүлгийн төрөл, дэд төрлийн асуудал судлаачдын дунд өнөө хир нэг мөр шийдэгдээгүй. Говийн махир хуруут гүрвэл бол *Tenuidactylus* төрлөөс Төв Азид нэвтрэн тархсан цорын ганц зүйл юм.

**Таних шинж.** Их биеийн урт нь 5.2 см. Толгой нь дээд талаараа хэмжээгээрээ бараг ижил, мөхлөгөн хайрсаар бүрхэгдсэн. Хамрын сүв нь эрүүн завсрын хайрс, дээд уруулын нэг хайрс, хамрын хоёр хайрсны дунд байрлана. Нуруун дээгүүр байрлах гурвалжин хайрс нь чихний сүвний диаметрээс багагүй. Эдгээр хайрс нь хөндлөн тууш зөв эгнээ үүсгэдэггүй.

Төгсгөлийн сүвний орчимд өнцөг үүсгэж байрласан зургаан сүв бий. Сүүл нь дээд талаараа цагариглаж байрласан трапец хэлбэрийн хайрснуудаар, доод талаараа нэг эгнээ том хайрсаар тус тус бүрхэгдсэн байна. Хөлийн хуруу нь хажуу талаараа шүдлэг цацаггүй. Бие нь ерөнхийдөө цайвардуу хүрэн өнгөтэй, нуруу сүүл, мөчдийн дээгүүр бараан хүрэвтэр, хөндлөн бор судлуудтай. Залуу гүрвэлд энэ судал нэлээд тод.

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Эмзэг (VU), D2 (Тэрбиш нар, 2006а; Terbish *et al.*, 2006а). 2025 онд Эмзэг (VU), D2. Монгол оронд хязгаарлагдмал тархацтай ховор зүйл. Энэ зүйл нэлээд өвөрмөц амьдрах орчныг шүтэн бага талбайд тархсан. Ийнхүү энэ зүйл цөөхөн үндсэн байршил нутагтай, уул уурхайн үйл ажиллагаа ирээдүйд ховордуулж болзошгүй, хөрш улсын популяцийн бодгалийн шилжилт, суурьшилт тодорхойгүй зэргийг үндэслэн D2 шалгуураар үнэлж дээрх зэрэглэлийг хэвээр үлдээв.


**Үнэлгээ хийсэн:** Х.Тэрбиш, М.Мөнхбаатар, П.Эрдэнэтүшиг, Ж.Гүррагчаа, Г.Довчиндорж (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Золжаргал, Г.Онолрагчаа, Г.Довчиндорж, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Хятадын Согоо нуур, Хамийн баянбүрд, Монголын Алтайн Өвөр говиор тархсан (Terbish *et al.*, 2006а; Uetz *et al.*, 2006).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Алтайн Өвөр говийн Ногоон доvon, Шар хулсны баянбүрд, Ногоон цав, Ингэн хөөврийн хоолой, Цуглабарын нуруу, Цувраа хар,

Хэрмэн цав, Бүгийн цав, Наран булаг, Хайч уул, Зулганайн баянбүрд зэрэг цөлийн хадархаг (6) нутгаар тархана (Мөнхбаяр, 1976; 1977; Мөнхбаяр, 1981; Семенов и Мунхбаяр, 1996; Мунхбаяр и Тэрбиш, 1997; Terbish *et al.*, 2006a). Монголд далайн түвшнээс дээш 700-1,300 м өндөрт нутаглана (Боркин и др., 1990). Алтайн Өвөр говийн уулс, цав, толгодын хормой, бэл, хажуу, энгэр, хавцал, хөндийн хад чулуут (3.4; 6) нутгаар идэш тэжээлийн нөөц нэн хязгаарлагдмал, өвөрмөц орчинд амьдардаг петрофиль, стенотоп зүйл (Ананьева и др., 1997). Монгол орны хэмжээнд 28,549 км<sup>2</sup> нутагт тархан амьдарч байна.



**Амьдралын онцлог.** Бүрэнхий, шөнийн амьдралтай. Гэвч хавар, намрын үүлэрхэг, сэрүүн өдрүүдэд өдрийн цагт идэвхтэй хөдөлнө. Зуны халуунд өдрийн цагт гол төлөв хад чулууны ан завсар, хөндий, хавтгай чулуу, унанги загийн дор орогноно. Ногоон цавд хийсэн судалгаагаар, говийн махир хуруут гүрвэлийн идэш тэжээлд тооны хувьд хатуу далавчтан, сарьсан далавчтан багийн шавж (тус бүр 33.3 %) зонхилж, мөн аалзыг (14.3%) нэлээд хэмжээгээр идсэн байжээ. Алтайн Өвөр говийн Цуглабарын ус орчимд энэ зүйл гүрвэлээр сум могой хооллосон тохиолдол тэмдэглэгдсэн. Өндөг төрүүлнэ. 8-р сарын аравдаар зулзаган үрвэл тааралдаж байв.

**Тоо толгой, нягтшил.** Тоо толгой, хоногийн ба улирлын идэвх, үржил, хөгжлийн талаар судалгааны мэдээ баримт үгүй байна.

**Ховордлын шалтгаан.** Идэш тэжээл хязгаарлагдмал, хур тунадас бага, ган гачигт өртөмтгий (7.1), агаарын хэм огцом өөрчлөгддөг хуурай халуун уур амьсгал бүхий (7.3) онцгой орчинд идээшин амьдардаг тул байгалийн элдэв нөлөөнд өртөж тоо толгой нь буурах магадлалтай. Тухайлбал, байгалийн нөхцөлд өрсөлдөгчдийн (8.1) нөлөөнд өртөх, махчдын золиос болох (8.2;

8.3) магадлал өндөр тул эзэмшил нутаг хумигдаж (9.9), нягтшил (9.5) нь багассанаар хүйсийн харьцаа алдагдах (9.6), өсөлтийн эрчим удаахрах (9.7), тоо толгой нь хэлбэлзэх (9.8) зэргээр популяцийн төлөв байдал доройтох магадлал нэн өндөр. Тухайн нутагт ган гачиг тохиолдон шөнийн амьдралтай шавжийн тоо толгой буурснаас тэжээлийн хомсдолд ордог.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон ба ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1) агнаж, барьж болно. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг Говийн Их дархан цаазат газарт хамрагдсан. Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгджээ (Мөнхбаяр нар, 2016).

#### **Хамгаалах арга хэмжээ**

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Эмзэг, D2” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах үндэсний эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Энэ зорилгоор мониторингийн судалгааны экспедицийг улсын төсвөөр 3 жил тутамд зохион байгуулах
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

## 3.4. ЗАМБА ГҮРВЭЛ

### *Paralaudakia stoliczkana* (Blanford, 1875)

Баг: Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

Овог: Замба гүрвэл (Agamidae)

Англи нэр: Mongolian Agama

Ижил нэр: Замба зараа; *Agama stoliczkana* (Blanford, 1875); *Laudakia stoliczkana* (Blanford, 1875); *Stellio stoliczkanus* (Blanford, 1875); *Laudakia stoliczkana* (Macey et al., 2000); *Paralaudakia stoliczkana* (Baig et al., 2012); Mongolia Rock Agama.



**Ангилал зүйн тойм.** *Laudakia* төрлийн гүрвэлүүдийг 54 морфологийн шинжээр харьцуулж энэ төрлийг *Laudakia* болон бие даасан *Paralaudakia* хэмээх 2 төрөлд ялган үзэх болжээ (Baig et al., 2012). Монголд тархсан замба гүрвэл нь *Paralaudakia* төрөлд хамаарна. Манай оронд энэ гүрвэлийн эх салбар зүйл *P. s. stoliczkana* (Blanford, 1875)-аас гадна, *P. s. altaica* (Мөнхбаяр, 1971) тархсан (Мөнхбаяр нар, 2023).

**Таних шинж.** Их биеийн урт 15 см, сүүлний урт 21 см. Монгол орны хамгийн том гүрвэл. Дээд уруулын хайрс 10-16, тэдгээрийн 6-9 нь нүднээс урагш оршино. Сүүлний хайрс ихэвчлэн дөрвөн эгнээгээр, зарим хэсэгтээ гурваар үелсэн байна. Толгой хүзүү, гуя, сүүлний угийн хайрс хэмжээгээр томорч, арзгар өргөслөг болсон. Биеийн зүс хар, бор, хүзүүний орчмоор шар толботой, хэвлий

шаргал, амьдрах орчныхоо хад чулууны хаг өнгөрийг дагасан ивээл өнгөтэй (Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бус нутгийн үнэлгээ:** 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Terbish et al., 2006a; Terbish et al., 2006b).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Популяцийн тоо толгойн өнөөгийн хэмжээ тодорхойгүй. Амьдрах орчны нөхцөлөөс хамааран алаг цоог тархсан. Энэ амьтныг дорнын анагаах ухаанд эмчилгээний зорилгоор ашиглаж ирсэн. Хятадад архинд хандлан худалдаалдаг гэсэн мэдээ бий. Цаашид худалдаа, арилжаа популяцийн хэмжээнд нөлөөлөхүйц өсвөл энэ зүйлийг А шалгуураар дахин үнэлж ховордлын


зэрэглэлийг ахиулж болох юм. Одоогоор баримт бага байгаа тул энэ зүйлийг дээрх зэрэглэлээр үнэлэв.

**Үнэлгээ хийсэн:** П.Эрдэнэтүшиг, Х.Тэрбиш, П.Золжаргал (2025).

**Үнэлгээ хянасан:** Х.Мөнхбаяр, М.Мөнхбаатар, Г.Онолрагчаа, Ж.Гуррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Хятад (Шинжаан, Гансу), Монголын өмнөд ба баруун өмнөд нутгаар тархсан (Uetz *et al.*, 2021, Terbish *et al.*, 2006).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Алтайн Өвөр говь, Говь Алтай, Говийн Тэнгэр уулсын хажуу хормойн хад асга, харгана сөөгтэй газар, уулс хоорондох хотос хөндий, цөлийн баян бүрд орчмын хадархаг уулсаар (6) тархсан. Нэлээд өргөн уудам нутагт тархсан боловч тархац нутгийнхаа дотор экологийн хувьд аятай таатай нөхцөл тухайлбал, бут мод, хад чулуутай (3.4) газрыг шүтэн амьдарна (Эрэгдэндавга, 1958; Мөнхбаяр, 1976а; Мөнхбаяр и Тэрбиш, 1991; Ананьева и др., 1997; Terbish *et al.*, 2006). Монгол оронд далайн түвшнээс дээш 1,200-2,400 м өндөрт тохиолдоно (Боркин и др., 1990). Монгол оронд тархсан талбайн хэмжээ 98,255 км<sup>2</sup> гэж үнэлэгдсэн ч энэ зүйлийн популяци нь хэсэгчлэн хуваагдаж тусгаарлагдсан (Д.В.Семенов, аман мэдээ). Монгол-Германы экспедицийн хүрээнд 1974-1978 онд Ховд аймгийн нутаг, Их нуурын хотгорын Ховд голын савд орших Баян ууланд 86 бодгаль замба гүрвэл тавьж нутагшуулсан (Stubbe *et al.*, 1981).



**Амьдралын онцлог.** Уул нуруудын хад асга, харгана сөөгтэй газар, гол ус, зарим баянбүрд, булаг шанд бараадан амьдарна. Өдрийн идэвхтэй. Ихэвчлэн шавж, аалз хэлбэртнээр хооллодог боловч хавар харганын цэцэг идэх нь элбэг. 9-р сарын сүүлч 10-р сарын эхээр ичээлж, 4-5-р сард ичээнээс гарч үржилд орно. 10 орчим өндгийг 5-р сард гаргана. 7-р сарын сүүлч 8-р сарын

дундуур өндөгнөөс үрвэл төрнө. Үрвэлүүд 2 жилийн дараа бие гүйцнэ. Эзэмшил нутгаа хамгаалан өргөс хайрсаа арзайлган, толгой цээжээ өндөлзүүлэн сүүлээрээ чулуу гуядан сүр хүчийг үзүүлнэ. Гол дайсан нь махчин шувууд, дэлдэн зараа, суусар, үнэг, хярс болно (Мөнхбаяр нар, 2023).

**Тоо толгой, нягтшил.** Тархац нутагт 12-15 м өргөнтэй, 1 км урттай судалгааны талбайд 10-15 бодгаль тоологдсон (Peters, 1971; Орлова и Тэрбиш, 1986). Зарим цэгүүдэд 18-19 бодгаль/га тохиолдсон (Тэрбиш, 1995).

**Ховордлын шалтгаан.** Хятадад үндэсний ба олон улсын хэмжээнд хүнс (3.1), эмийн түүхий эд (3.2), зугаа цэнгэлийн (3.5) зориулалтаар зах зээлд нэг ширхгийн ойролцоогоор 5 ам. доллароор худалдаалдаг боловч олборлож буй хэмжээ нь тодорхойгүй. Хэрвээ түүний тархац нутгийн хэмжээнд уул уурхай, ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа (1.3.1) явагдвал тэдгээрийн амьдрах орчныг сүйтгэж, улмаар тоо толгойд нь сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй (Terbish *et al.*, 2006а).

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Үндсэн тархац нутаг Говийн Их дархан цаазат газрын “А”, “Б” хэсэг, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газарт хамрагджээ.

**Хамгаалах арга хэмжээ**

- “Ховордож болзошгүй” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах үндэсний эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2).
- Ангилал зүй (3.1), популяци (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөний судалгаанд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах.
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2).
- Хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй.

## 3.5. ЦООХОР ХОНИН ГҮРВЭЛ

### *Phrynocephalus versicolor* (Strauch, 1876)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Замба гүрвэл (Agamidae)

**Англи нэр:** Tuvan Toad-headed Agama

**Ижил нэр:** *Phrynocephalus carinatus* (Tzarevsky, 1927); *Phrynocephalus carinilabris* (Bedriaga, 1909); *Phrynocephalus ciliaris* (Bedriaga, 1909); *Phrynocephalus pewzonii* (Bedriaga, 1906).



**Ангилал зүйн тойм.** Монгол оронд цоохор хонин гүрвэлийн эх салбар зүйл *P. v. versicolor*-ээс гадна, *P. v. hispida* (Зүүнгарын говь), *P. v. kulagini* (Ховдын тойрог), *P. v. bogdanowi* (Монгол орны зүүн өмнөд нутаг) гэсэн салбар зүйлүүд бий гэж тэмдэглэсэн. Цаашдын нарийвчилсан судалгаагаар Монгол оронд цоохор хонин гүрвэлийн зөвхөн эх салбар зүйл тархдаг болохыг тогтоосон. Бусад салбар зүйлээс *P. hispidus*, *P. kulagini* хэмээх хоёр зүйл болгон ялгаж, *P. v. bogdanowi* нь *P. v. versicolor*-ийн синоним болохыг тодорхойлжээ (Милишников и Лихнова, 1986; Лихнова, 1992; Семенов и Щенброт, 1989; Ананьева и др., 1997; Buehler et al., 2021; Dunayev et al., 2021; Ganbold et al., 2022; Solovyeva et al., 2023).

**Таних шинж.** Их биеийн урт 6 см, сүүлний урт 7 см. Хоолой, хэвлий, нурууны хайрс гөлгөр, харин цээжний хайрс үл ялиг арзгар. Биеийн зүс нь амьдрах орчныхоо ерөнхий өнгийг даган хувьсамтгай, олон янз боловч ихэнхдээ саарал, бор саарал. Мөн нуруун дээгүүрээ хар, хар хүрэн шаравтар, тод саарал зэрэг янз бүрийн өнгийн толбо, тахирласан зураас болон цэгүүдтэй. Суганы

хонхорт улаан толботой, энэ толбо нь хөх өнгийн эмжээртэй байж болно. Хэвлий цайвар. Сүүл дээд, доод талдаа хөндлөн бараан судлуудтай. Залуу бодгалиудын сүүлний уг хэвлийн талдаа шаргалдуу өнгөтэй (Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бус нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish et al., 2006a; Terbish et al., 2006b).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой элбэг, нягтшил өндөртэй зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлсэн тул дээрх үнэлгээг хэвээр үлдээв.


**Үнэлгээ хийсэн:** П.Эрдэнэтүшиг, М.Мөнхбаатар, Х.Тэрбиш (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Золжаргал, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Оросын зүүн өмнөд нутаг (Тува), Казахстаны зүүн хэсэг, Хятадын хойд ба баруун хэсэг (Шинжаан, Гансу, Нингха, Өвөр Монгол) болон Монголд тархсан

(Мөнхбаяр, 1976а; Тэрбиш, 1989; Ананьева и др., 1997; Шенброт и Семенов, 1986; Uetz *et al.*, 2021; Terbish *et al.*, 2006; Buehler *et al.*, 2021; Dunayev *et al.*, 2021).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Энэ зүйл нь *Phrynoscephalus* (Agamidae овог) төрлөөс Төв Азийн цөлд хамгийн түгээмэл тохиолддог (Ананьева и др., 1997; Wang and Fu, 2004). Говь цөл, цөлөрхөг хээр, хээрийн (3.4; 8.2) элдэв хэв шинжийн амьдрах орчинд түгээмэл тохиолдоно (Ананьева и др., 1997; Тэрбиш, 2004; Wang and Fu, 2004). Монгол орны говь, цөлд амьдардаг хамгийн өргөн тархалттай, тоо толгойн өндөр нягтшил бүхий дөрвөн зүйл гүрвэлийн (*P. versicolor*; *A. pipiens*; *E. przewalskii*; *E. multiocellata*) нэг юм (Rogovin *et al.*, 2001; Тэрбиш, 2004). Дарьганга бол цоохор хонин гүрвэлийн дэлхийн тархцын хамгийн зүүн хил болдог (Terbish *et al.*, 2006). Дорнод говь, Умард говь, Алашаа говь, Монгол Алтайн нурууны өмнөд хэсэг, Алтайн өвөр ба Зүүнгарын говь, Говь Алтайн нуруу, Их нууруудын хотгор, Дорнод Монголын зүүн өмнөд хэсэг, Хангайн нурууны өмнөд хэсэг зэрэг нутгуудаар тархсан (Мөнхбаяр, 1976а; Боркин и др., 1990; Ананьева и др., 1997; Terbish *et al.*, 2006). Энэ зүйлийн талаарх судалгааг Монгол-Оросын хамтарсан Биологийн иж бүрэн экспедицийн цөлийн судалгааны хөтөлбөрийн хүрээнд 1977-1985 онд Алтайн Өвөр говийн Эхийн голын баянбүрд, түүний орчмын суурин судалгааны 6 талбайд (Семенов и Боркин, 1985; Семенов, 1985; 1986; 1987; 1991), 1995-1996 онд Говь Гурван сайханы байгалийн цогцолборт газрын баянбүрд, цав толгод, заган ой, харганат цөл, элсэн манхан бүхий нутагт тус тус явуулжээ (Reading *et al.*, 1999). Монгол оронд далайн түвшнээс дээш 600-2,000 м өндөрт тохиолдоно (Боркин и др., 1990; Ананьева и др., 1997). Энэ зүйлийн Монголд тархан амьдрах нутаг 647, 991 км<sup>2</sup> гэж үнэлэгдсэн.



**Амьдралын онцлог.** Говь цөл, цөлөрхөг хээр, хээрийн ургамлан бүрхэвч багатай сайр садарга, хайрга чулуут, элсэрхэг нутгаар түгээмэл тархана. Өдрийн идэвхтэй. Ихэвчлэн шавж, аалз хэлбэртнээр хооллох боловч гол тэжээл нь шоргоолж юм. 9-р сард ичээлж, 4-5-р сард ичээнээс гарч үржилд орно. 5-р сард 1-5 ширхэг өндөг гаргах ба 7-р сард өндөгнөөс үрвэл төрнө. Үрвэлүүд хоёр ичээлсний дараа бие гүйцнэ. Гол дайсан нь махчин шувууд, дэлдэн зараа, зарим могой (Ананьева и др., 1997).

**Тоо толгой, нягтшил.** Энэ зүйлийн тоо толгой, нягтшил өндөр бөгөөд 1 га талбайд 106 (1-106) хүртэл бодгаль тоологдож, дунджаар 37 бодгаль/га нягтшилтай байсан (Rogovin *et al.*, 2001).

**Ховордлын шалтгаан.** Ашигт малтмалын хайгуул, уул уурхайн үйлдвэрлэлийн үед хөрс хуулах (1.3.1), газар тариалангийн зориулалтаар хагалан (1.1) боловсруулах явцад түүний амьдрах орчин доройтож, улмаар тоо толгойд нь сөргөөр нөлөөлнө. Мөн малын хөлд гишгэгдэх (1.1.4), машинд дайруулах (1.4.4) эрсдэл бий. Жил дараалсан гангийн улмаас хоол тэжээлийн хомсдолд орох, өвлийн хахир хүйтнээс (7.3) ичээндээ хөлдөх зэргээр тоо толгой нь хорогдох магадлал өндөр. Гэхдээ хүрээлэн буй орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны аль нь энэ зүйлийн тоо толгойд илүү сөрөг нөлөөлдгийг хараахан тогтоогоогүй (Terbish *et al.*, 2006).

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Энэ зүйлийн тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (Terbish *et al.*, 2006).

#### **Хамгаалах арга хэмжээ**

- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.6. ТОЙРМЫН ХОНИН ГҮРВЭЛ


### *Phrynocephalus helioscopus* (Pallas, 1771)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Замба гүрвэл (Agamidae)

**Англи нэр:** Sunwatcher

**Ижил нэр:** *Lacerta helioscopus* (Pallas, 1773); Sunwatcher Toadhead Agama (Frank and Ramus, 1996).



**Ангилал зүйн тойм.** Дэлхийн тархац нутгийн хэмжээндээ 5 салбар зүйлтэй бөгөөд Монголд *Phrynocephalus helioscopus varius* нь тархсан (Solovyeva *et al.*, 2011; Solovyeva *et al.*, 2012).

**Таних шинж.** Их бие 5 см, сүүл нь 5.4 см. Нурууны хайрс биеийн хажуугийн хайрснаас хэмжээгээр арай том, их биеийн хажуу тал, нуруу болон сүүлний угаар байрлах нэг эгнээ бүлэг хайрсны хэмжээ бусдаас томорч богинохон өргөс, хатгуур маягтай болсон. Сүүл нь угийн хэсгээрээ өргөсөж хавтгайрсан, үзүүр тийш огцом нарийсна. Гол төлөв цайвар бор зүстэй. Хоншоор, дух зулайн хэсэг бараавтар, нүдний дээд тал нурууны өнгөтэй адил. Шилэн хүзүүн дээр нарийхан цэнхэр өнгийн судлаар хагас, эсвэл бүтэн эмжигдсэн улаан ягаан өнгийн хос толботой. Энэ толбоны араас эхлэн нурууны голоор тасархайтсан 2-3 бараан судал бий. Эдгээр бараан судлын хажуугаар цэнхэр өнгийн толбууд зэрэгцэн

байрлана. Хэвлий, сүүлний доод тал цагаан шаргал, хүзүүний хэсэгт бараавтар толбууд ажиглагдана. Үржлийн үед эр бодгалийн сүүлний үзүүр доод талаараа улаан өнгөтэй (Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).

2025 онд Эмзэг (VU) (D2). Энэ зүйлийн Монгол дахь тархац нутгууд нь дэлхийн тархцын зүүн хойд хязгаар болно. Монгол оронд энэ зүйлийн тархац нутгийн нийт хэмжээг 6,719 км<sup>2</sup> гэж үнэлсэн.

**Үнэлгээ хийсэн:** Х.Тэрбиш, П.Эрдэнэтүшиг (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, М.Мөнхбаатар, П.Золжаргал, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Ираны умард нутаг, Турк, Казахстан, Туркменистан, Узбекистан, Хятад, Монголд тархсан (Банников и др., 1977; Боркин и др., 1990; Ананьева и др., 1997; Terbish *et al.*, 2006).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Зүүнгарын говьд, Булган голоос хойш Ярант, Салхитын хөтөл, Их, Бага Онгогийн цөл, цөлөрхөг хээр, хээрт (3.4; 8.2) нутаглана (Тэрбиш и Мөнхбаяр, 1991; Тэрбиш и Пүрэвжав, 2000; Terbish *et al.*, 2006).



**Амьдралын онцлог.** Тачир ургамалтай цөлөрхөг хээр газар амьдарна. Өдрийн идэвхтэй. Хүчтэй салхи, зөөлөн бороотойд ч идэвхтэй. Ихэвчлэн шавж, аалз хэлбэртнээр хооллоно. 9-р сарын сүүл 10-р сарын эхээр ичээлж, 3-р сарын төгсгөлөөр ичээнээс гарч үржилд орно. 5-р сард 3-5 ширхэг өндөг гаргах ба 7-р сард өндөгнөөс үрвэл төрнө. Зуны улиралд 13-15 см гүн нүх ухаж орогноно. Хөрсний ан цав, бутны ёроолд буй шавж, мэрэгчдийн нүхэнд түр хорогдоно. Өвлийн ичээний нүхний гүн 45-55 см хүрнэ. Гол дайсан нь жижиг махчин шувууд, дэлдэн зараа, зарим могой болно (Тэрбиш и Пүрэвжав, 2000; Meyer and Zinke, 1992).

**Тоо толгой, нягтшил.** Энэ зүйлийн тоо толгойн талаарх судалгааны мэдээ баримт хомс. Германы судлаач Meyer, Zinke нар (1992) Зүүнгарын говьд тойрмын хонин гүрвэл 3-5 бодгаль/га нягтшилтай хэмээн үнэлсэн байдаг.

**Ховордлын шалтгаан.** Манай орны хувьд хязгаарлагдмал тархацтай амьтан бөгөөд популяци нэн эмзэг учир амьдрах орчин доройтох (6.2), хүний элдэв нөлөө (10) зэрэг

нь ховордлын шалтгаан болно. Шонхор, хэрээ, цахлай, бамбай хоншоорт могойн хоол (8.2; 8.3) болдог (Мөнхбаяр нар, 2013).

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон ба ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1) агнаж, барьж болно. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг Булган гол-Онгогийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгджээ (Мөнхбаяр нар, 2016).

#### **Хамгаалах арга хэмжээ**

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Эмзэг, D2” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах үндэсний эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судлах, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй.

## 3.7. КУЛАГИНЫ ХОНИН ГҮРВЭЛ

### *Phrynocephalus kulagini* (Bedriaga, 1909)

---

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Замба гүрвэл (Agamidae)

**Англи нэр:** Kulagin's variegated toadhead agama

**Ижил нэр:** *Phrynocephalus versicolor kulagini* (Bedriaga, 1909); *Phrynocephalus versicolor* var. *Kulagini* (Bedriaga, 1909); *Phrynocephalus versicolor kulagini* (Nikolsky, 1915); *Phrynocephalus versicolor kulagini* (Barabanov and Ananjeva, 2007); *Phrynocephalus kulagini* (Dunayev et al., 2021); *Phrynocephalus versicolor kulagini* (Ganbold et al., 2022); *Phrynocephalus kulagini* (Solovyeva et al., 2023).



**Ангилал зүйн тойм.** Цоохор хонин гүрвэл (*Phrynocephalus versicolor*)-ийн салбар зүйл хэмээн үздэг байсан бөгөөд сүүлд бие даасан зүйл болгон ялгасан (Милишников и Лихнова, 1986; Лихнова, 1992; Семенов, 1987; Семенов и Щенброт, 1989; Ананьева и др., 1997; Buehler *et al.*, 2021; Dunayev *et al.*, 2021; Ganbold *et al.*, 2022; Solovyeva *et al.*, 2023).

**Таних шинж.** Биеийн төрх, хэмжээ, өнгөний хувьд цоохор хонин гүрвэлтэй тун төстэй боловч сугандаа улаан толбо үгүй (Buehler *et al.*, 2021; Dunayev *et al.*, 2021; Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Үнэлгээ хийгдээгүй.

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.


2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй. Цаашид дээрх чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

**Үнэлгээ хийсэн:** П.Эрдэнэтүшиг, М.Мөнхбаатар, П.Золжаргал (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, Х.Тэрбиш, Г.Онолрагчаа, Ж.Гүррагчаа, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Оросын зүүн өмнөд нутаг (Тува), Монголд тархсан (Buehler *et al.*, 2021; Dunayev *et al.*, 2021; Ganbold *et al.*, 2022).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол оронд Их нууруудын хотгор, Шаргын говь хүртэл тархсан байх магадлалтай. Тархац



нутгийн хил, зурвас нутгаар бусад зүйлийн хонин гүрвэлүүдтэй симпатри хэлбэртэй оршдог байх боломжтой (Buehler *et al.*, 2021; Dunayev *et al.*, 2021; Ganbold *et al.*, 2022).

**Амьдралын онцлог.** Амьдрах орчны сонголт нь цоохор хонин гүрвэлтэй төстэй.

**Тоо толгой, нягтшил.** Хангалттай мэдээ, баримт хомс.

**Ховордлын шалтгаан.** Өмнө нь цоохор хонин гүрвэлийн салбар зүйлд хамаарч байсан тул бие даасан зүйлийн хувьд ховордлын шалтгаан хараахан тодорхойгүй.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Увс нуурын дархан цаазат газар, Хяргас нуур, Хар-Ус нуур, Монгол Элсний байгалийн цогцолборт газруудад хамрагджээ.

**Хамгаалах арга хэмжээ**

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судлах шаардлагатай бөгөөд судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.8. ӨРГӨСЛӨГ ХОНИН ГҮРВЭЛ

### *Phrynocephalus hispidus* (Bedriaga, 1909)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Замба гүрвэл (Agamidae)

**Англи нэр:** Dzhungar Variegated Toadhead Agama

**Ижил нэр:** *Phrynocephalus versicolor* var. *Hispida* (Bedriaga, 1909); *Phrynocephalus versicolor hispidus* (Nikolsky, 1915); *Phrynocephalus versicolor hispida* (Tuniyev et al., 2014); *Phrynocephalus hispidus* (Dunayev et al., 2021); *Phrynocephalus versicolor hispidus* (Ganbold et al., 2022); *Phrynocephalus hispidus* (Solovyeva et al., 2023).

**Ангилал зүйн тойм.** Энэ зүйлийг цоохор хонин гүрвэл *Phrynocephalus versicolor*-ийн салбар зүйл хэмээн үздэг байсан бөгөөд сүүлийн үеийн судалгааны үр дүнд бие даасан зүйл болгон ялгасан (Мишишников и Лихнова, 1986; Лихнова, 1992; Семенов, 1987; Семенов и Щенброт, 1989; Ананьева и др., 1997; Buehler et al., 2021; Dunayev et al., 2021; Ganbold et al., 2022; Solovyeva et al., 2023).

**Таних шинж.** Биеийн төрх, хэмжээ, өнгөний хувьд цоохор хонин гүрвэлтэй тун төстэй боловч суганы хонхорт улаан толбо байхгүй (Buehler et al., 2021; Dunayev et al., 2021; Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Үнэлгээ хийгдээгүй.

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй. Цаашид дээрх чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

**Үнэлгээ хийсэн:** П.Эрдэнэтүшиг, П.Золжаргал, М.Мөнхбаатар (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, Х.Тэрбиш, Г.Онолрагчаа, Ж.Гүррагчаа, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Хятадын баруун хойд хэсэг (Шинжаан, Гансу), Монголд тархсан (Buehler et al., 2021; Dunayev et al., 2021; Ganbold et

al., 2022).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Зүүн гарын говь, Алтайн Өвөр говиор тархсан. Тархац нутгийнхаа хил, зурвас нутгаар бусад зүйлийн хонин гүрвэлүүдтэй симпатри хэлбэртэй оршдог байх боломжтой (Buehler et al., 2021; Dunayev et al., 2021; Ganbold et al., 2022).

**Амьдралын онцлог.** Амьдрах орчны сонголт нь цоохор хонин гүрвэлтэй адилхан тул амьдралын онцлог ижил.

**Тоо толгой, нягтшил.** Мэдээлэл дутмаг.


**Ховордлын шалтгаан.** Өмнө нь цоохор хонин гүрвэлийн салбар зүйлд хамаарч байсан тул бие даасан зүйлийн хувьд ховордлын шалтгаан хараахан тодорхойгүй байна.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн үндсэн тархац нутаг Говийн Их дархан цаазат газрын “Б” хэсэг, Ээж хайрханы дурсгалт газар, Говийн Их дархан цаазат газрын “А” хэсэгт тус тус хамрагджээ.

**Хамгаалах арга хэмжээ**

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн



динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судлах шаардлагатай бөгөөд судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан

хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх

- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.9. МОГОЙ ГҮРВЭЛ

### *Eremias multiocellata* (Gunther, 1872)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Жинхэнэ гүрвэл (Lacertidae)

**Англи нэр:** Multi-cellated Racerunner

**Ижил нэр:** *Podarces multiocellata* (Strauch, 1876); *Podarces planiceps* (Strauch, 1876); *Eremias yarkandensis* (Blanford, 1875).



**Ангилал зүйн тойм.** Могой гүрвэлийн *E. m. bannikowi* (Szczerbak, 1973); *E. m. multiocellata* (Gunther, 1872); *E. m. kozłowi* (Bedriaga, 1907); *E. m. yarkandensis* гэсэн 4 салбар зүйлийг тэмдэглэсэн бөгөөд Монгол оронд *E. m. bannikowi*; *E. m. multiocellata* хэмээх хоёр салбар зүйл тохиолдоно (Шербак, 1974; Боркин и др., 1990). Цаашид зүйлийн дотоод ангилал зүйн талаар нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай.

**Таних шинж.** Их бие 7.5 см. Хамрын доод бамбай хайрс эрүүн завсрын бамбай хайрсанд хүрээгүй. Нүдний дээд болон дух, дух зулайн бамбай хайрс жижиг мөхлөгүүдээр бүрэн тусгаарлагдаагүй. Нүдний дээд хайрсны өмнөх зайд харилцан адилгүй хэмжээний хэд хэдэн мөхлөгөн хайрстай. Духны бамбай хайрсанд тууш

гурви үл мэдэг илэрсэн. Хоолойн хайрс 25-33, нурууны хайрс 51-57, гуяны сүв 10-12, сүүлийн 9-10 дугаар үеийн нэг эгнээнд 21-31 хайрстай. Нуруу тал нь хүрэвтэр, эсвэл ногоовтор туяатай бор. Нурууг дагасан тасархай хар толботой. Энэ тууш хар толбоны завсрын зай нь цайвар судал мэт харагдана. Их биеийн хажуугаар голдоо цайвар хөх нүдэн толбо, цайвар юм уу хар судлаар хүрээлэгдсэн хөх, шаравтар дугариг толбууд хоёроос гурван эгнээгээр байрлана. Суганы архан дээд талд ихэвчлэн нэг шар толботой. Хэвлий нь цайвар шарга, эсвэл цагаан (Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish *et al.*, 2006a).


2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

**Үнэлгээ хийсэн:** П.Золжаргал, Х.Тэрбиш, М.Мөнхбаатар (2025).

**Үнэлгээ хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Г.Онолрагчаа, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Оросын зүүн өмнөд нутаг (Тува), Казахстаны зүүн болон зүүн өмнөд нутаг, Узбекистан, Хятадын баруун хойд нутаг (Шинжаан, Чингхайгаас зүүн тийш Өвөр Монгол, баруун тийш Лианонинг хүртэл), Монголын өмнөд нутаг болон Киргизстанд тархсан (Uetz *et al.*, 2006).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол орны говь цөлийн бүс нутгаар түгээмэл тархсан дөрвөн зүйл (*P. Versicolor*, *A. Pipiens*, *E. Przewalskii*, *E. multiocellata*) гүрвэлийн нэг юм (Ананьева и др., 1998; Тэрбиш, 2004). Алтайн Өвөр говь, Их нууруудын хотгор, Монгол Алтайн нуруу, Говь Алтайн нуруу, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Умард говь, Дорнод говь, Алашаа говь зэрэг нутагт тархсан (Мөнхбаяр, 1976a; Ананьева и др., 1997; Terbish *et al.*, 2006). Монгол оронд далайн түвшнээс дээш 600-2,700 м өндөрт тохиолдоно (Ананьева и др., 1997). Монгол орны баруун бүс нутгаар *E. m. bannikowi*, бусад нутгаар *E. m. multiocellata* хэмээх салбар зүйл тус тус тархжээ (Щербак, 1974).



**Амьдралын онцлог.** Харгана, бударгана голлосон бут, сөөглөг ургамалтай хатуу хайрган хөрстэй, хад чулуутай цөл, заримдаг цөл (3.4; 6; 8.2; 8.3), сөөг ургамалд хурж тогтсон элсэн хуримтлал бүхий нутагт зонхилон амьдарна. Элдэв шавж, хорхой иднэ. Амьд үрвэл төрүүлж үржинэ. Ихэвчлэн 3-5 хүртэл зулзага гаргана.

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Газар тариалан (1.1.1), мал аж ахуй (1.1.4), ашигт малтмалын олборлолт, уул уурхайн үйлдвэрлэлийн (1.3.1) улмаас түүний амьдрах орчин доройтох нь энэ зүйлийн тоо толгой буурах шалтгаан болно. Түүний тархац нутагт ган (7.1), зуд болж агаарын хэм огцом өөрчлөгдөх (7.3) зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд өртөх магадлал өндөр. Махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2), идэш тэжээлийн золиос (8.3) зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр могой гүрвэлийн тоо толгой буурч болно.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (Terbish *et al.*, 2006; UNEP-WCMC, 2006; Мөнхбаяр нар, 2023).

#### Хамгаалах арга хэмжээ

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.10. ГОВИЙН ГҮРВЭЛ

### *Eremias przewalskii* (Strauch, 1878)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Жинхэнэ гүрвэл (Lacertidae)

**Англи нэр:** Gobi Racetrunner

**Ижил нэр:** *Podarces (Eremias) przewalskii* (Strauch, 1876); *Podarces (Eremias) kessleri* (Strauch, 1876); *Podarces (Eremias) brachydactyla* (Strauch, 1876).



**Ангилал зүйн тойм.** Бие даасан харьцангуй тогтвортой зүйлд тооцогддог ч *E. p. przewalskii* салбар зүйл Монгол орны өмнөд нутгаар, *E. p. tuvensis* салбар зүйл баруун хойд нутгаар тус тус амьдарна (Щербак, 1974; Орлова, 1992). Цаашид зүйлийн дотоод ангилал зүйн талаар нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай.

**Таних шинж.** Их биеийн урт 10 см. Сүүлийн урт 7.5-13.5 см. Нүдний доод бамбай хайрс амандаа хүрээгүй. Доод уруулын бамбай хайрс 6-9. Дух хамрын бамбай хайрс ямагт 1, нүдний дээд бамбай хайрс духны болон дух зулайн хайрснаас жижиг мөхлөгөн хайрсаар тусгаарлагдаагүй. Дээд уруулын бамбай хайрс 8-13. Нурууны хайрс гөлгөр, нэг эгнээнд орших хайрсны тоо 30-41. Гуяны сүвний тоо 11-17. Сүүлийн 9-10 дугаар үеийн нэг эгнээнд 26-37 хайрстай. Нуруун тал цайвар шаргал юм уу цайвар боровтор, эсвэл элсэн шаргал. Ийм дэвсгэр дээр

хүрэвтэр өнгийн нарийн судлууд торлосон, эсвэл том толбо маягтай байрлана. Мөн энэ хоёрын завсрын шинжийг хадгалсан зүстэй бодгалиуд ч бий. Зарим бодгалийн их биеийн хажуугаар голдоо цэнхэр өнгийн нүдлэг толботой. Хэвлий нь цайвар шаргал.

#### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Үнэлгээ хийгдээгүй (IUCN, 2006).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).


2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үзэж дээрх үнэлгээг хэвээр үлдээв. Хэрвээ энэ зүйлийг дорнын анагаах ухаанд ашиглах зорилгоор арилжаалах үйл явц ихэсвэл дахин үнэлгээг хийх шаардлагатай.

**Үнэлгээ хийсэн:** П.Золжаргал, Х.Тэрбиш, М.Мөнхбаатар (2025).

**Үнэлгээ хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Г.Онолпрагчаа, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Орос (Тувагийн өмнөд хэсэг), Хятадын умард нутаг, Монголд тархсан (Flint, 1960; Pope, 1935; Schmidt, 1927; Szczerbak, 1974; Мөнхбаяр, 1976а; Orlova, 1992; Тэрбиш нар, 2006).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол орны баруун болон өмнөд нутгийн цөлийн элсэрхэг хөрстэй нутгаар түгээмэл (Банников, 1958; Щербак, 1974; Мөнхбаяр, 1976; Тэрбиш, 1989), мөн Их нууруудын хотгор, Монгол Алтайн нуруу, Говь Алтайн нуруу, Алтайн Өвөр говь, Нууруудын хөндий, Умард говь, Дорнод говь, Алашаа говь зэрэг нутгуудад тархсан (Terbish *et al.*, 2006). Монгол оронд далайн түвшнээс дээш 760-1,800 м өндөрт тохиолдоно (Щербак, 1974; Ананьева и др., 1997).



**Амьдралын онцлог.** Хармаг, заг, нохой шээрэн, харгана, бударгана мэт мод сөөг ургасан дов элс, молцог элс, дэл элс, манхан элс, элсэн тарамцаг (3.4; 8.2) бол говийн гүрвэлийн нэн тааламжтай амьдрах орчин нь болно. Элдэв хорхой шавжаар хооллоно. Намрын эхээр боловсорсон үед нь хармагийн жимс иднэ. Гэхдээ энэ нь хөнөөл учруулахаасаа илүү хармагийн ургацыг дээшлүүлэхэд нөлөөлдөг байж болох юм. Хармагийн жимсийг идээд ясыг нь ялгадсаар нүхэн дотроо гаргаж, тэр нь байнгын чийгтэй байдаг элсэн дотор ургаж хармагийн бут хүчирхэг болдог. Энэ төрөлд багтах 30 шахам зүйлийн дотроос амьд зулзага төрүүлдэг хоёрхон зүйл байдгийн нэг нь говийн гүрвэл юм. Өвөл ичнэ. Хавар ичээнээс гарч 5-р сарын дундуур хөөцөлдөнө. 8-р сарын эхээр 4-5 үрвэл төрүүлнэ.

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Одоогоор энэ зүйлийн популяци тогтвортой, ховордуулах шалтгаан үгүй хэмээн үздэг. Хэдий ийм ч энэ зүйлийг Дорно дахинд ардын уламжлалт эмнэлэгт эмийн түүхий эд болгохоор олборлож, амьтны дэлгүүрт худалдаалдаг (3.2.1) тухай албан бус мэдээ бий. Уул уурхай, ашигт малтмалын олборлолтын (1.3.1) улмаас түүний амьдрах орчин доройтож, тоо толгой нь ховордож болзошгүй. Мөн махчин амьтдын тоо толгойн өсөлт (8.2), ган, зуд (7.1; 7.3) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр хорогдох магадлал өндөр.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (Terbish *et al.*, 2006; UNEP-WCMC, 2006; Мөнхбаяр нар, 2023).

#### **Хамгаалах арга хэмжээ**

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.11. МОНГОЛ ГҮРВЭЛ

### *Eremias argus* (Peters, 1869)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Жинхэнэ гүрвэл (Lacertidae)

**Англи нэр:** Mongolian Racerunner

**Ижил нэр:** *Podarces argus* (Strauch, 1876); *Eremias barbouri* (Schmidt, 1925).



**Ангилал зүйн тойм.** Ананьева нар (1997) *E. a. barbouri* (Schmidt, 1925), *E. a. argus* (Peters, 1869) гэсэн хоёр салбар зүйл Монголд тархсан хэмээн үзсэн (Terbish *et al.*, 2006). Цаашид зүйлийн дотоод ангилал зүйн талаар нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай.

**Таних шинж.** Их биеийн урт 71 мм-ээс хэтрэхгүй. Нүдний дээд бамбай хайрс дух, дух зулайн хайрснаас жижиг мөхлөгөн хайрсаар тусгаарлагдаагүй. Дух-хамрын бамбай хайрс хоёр, гэвч 1-2 нэмэгдэл жижиг мөхлөгтэй байж болно. Нүдний доод бамбайн хайрс дээд уруулын хайрсны завсарт ороогүй буюу аманд хамаарахгүй. Гуяны сүвний эгнээ өвдөгний үед хүрээгүй. Их биеийн зүс хүрвэтэр туяатай цайвар шаргал юм уу цайвардуу бор, нурууны тууш дагуу толбоор тасархайтсан 10 хүртэлх цайвар, цагаан судалтай. Хөлийн дээгүүр дугариг цагаан толботой. Хэвлий цагаан, эсвэл шаравтар, эр бодгалийнх улаавтар харагдана (Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (IUCN, 2023)

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл бөгөөд популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үнэлж дээрх үнэлгээг хэвээр үлдээв.


**Үнэлгээ хийсэн:** П.Золжаргал, М.Мөнхбаатар, Х.Тэрбиш (2025)

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Г.Онолрагчаа, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Орос (Байгаль нуурын өмнөд хэсэг, Чит мужийн баруун өмнөд хэсэг, Буриад), Хятад (Өвөр Монгол, Лианонгийн өмнөд хэсгээс Жиангсу хүртэл, баруун тийш Кингхай хүртэл), Монгол орны төв болон дорнод хэсэг, Хойд Солонгост тархсан (Uetz *et al.*, 2021).

### Монгол орны тархац, амьдрах орчин.

Цөлөрхөг хээр, хээрийн бүсийн хуурай хэв шинжийн янз бүрийн амьдрах орчинд (3.4; 8.2) идээшин амьдарна (Ананьева и др., 1997). Хангай, Хэнтийн нурууны зарим хэсэг, Дорнод Монголын тал хээр, Умард говийн уулын хээрийн зарим нутагт тохиолдоно (Terbish *et al.*, 2006). Монгол Алтайн нурууны Булган голын сав, Алтайн Өвөр говь, Нууруудын хөндий, Говь Алтайн нуруу, Дорнод говь зэрэг нутгийн цөлөрхөг хээр, хээрээр тархжээ (Ананьева и др., 1997). Говь Алтайн нурууны Говь Гурван сайханы байгалийн цогцолбор газрын нам уулс болон талархаг нутагт (баянбүрд, харгана бүхий аараг толгод, загт цөл, элсэн манхан) тохиолдоно (Мөнхбаяр, 1981; Reading *et al.*, 1999). Монгол оронд далайн түвшнээс дээш 600-2,050 м өндөрт амьдарна (Боркин и др., 1990). Энэ зүйлийн Монгол дахь тархан амьдрах нутаг нь 767,569 км<sup>2</sup>. Өргөн уудам тархацтай, тоо толгой элбэг амьтан тул хээрийн бүсийн хэв шинжийг илэрхийлэгч нэг индикатор болдог. Тархцын зүүн хэсгээр номинатив салбар зүйл, баруун хэсгээр нь *E. a. barbouri* салбар зүйл тархжээ (Боркин, 1990).



**Амьдралын онцлог.** Харганат болон хялганат хээр, нарсан ойн цоорхой, тачир ургамалтай хайрга чулуут дов толгод, хуурай сайр, эрэг ганганы хөвөө ирмэгээр голцуу тохиолдоно. Өдрийн идэвхтэй гүрвэл, 4-р сард ичээнээс гарч 9-р сарын дундуур ичнэ. Шавж хорхой, аалзаар хооллоно. Өндөглөж үржинэ. 2-3 өндөг гаргана (Мөнхбаяр нар, 2023).

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Ховордлын талаар мэдээ баримт байхгүй. Газар тариалан (1.1.1), мал аж ахуй (1.1.4), байгалийн нөөц, ашигт малтмалын олборлолт, ашиглалт (1.3.1), дэд бүтцийн хөгжлийн (1.4) улмаас түүний амьдрах орчин доройтож, тоо толгой нь буурч болзошгүй. Махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2), махчид ба золиос бологчдын идэш тэжээлийн холбоо (8.3), ган (7.1), зуд (7.3) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр монгол гүрвэлийн тоо толгой буурах магадлал өндөр.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 8% орчим нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (Terbish *et al.*, 2006; UNEP-WCMC, 2006; Мөнхбаяр нар, 2023).

### Хамгаалах арга хэмжээ

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх.

## 3.12. ТОЛБОТ ГҮРВЭЛ

### *Eremias arguta* (Pallas, 1773)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Жинхэнэ гүрвэл (Lacertidae)

**Англи нэр:** Steppe Racerunner

**Ижил нэр:** *Lacerta arguta* (Pallas, 1773); *Podarcis variabilis* (Wagler, 1830); Racerunner, Arguta.



**Ангилал зүйн тойм.** Хүлээн зөвшөөрөгдсөн зургаан салбар зүйл байдгаас *Eremias arguta* (Pallas, 1773) Казахстанд тархсан, *E. a. deserti* (Gmelin, 1789) нь Урал голоос баруун зүгт хойд Кавказын зүүн хэсэг (Румын, Молдова, Украин), *E. a. transcaucasica* (Darevsky, 1953) өмнөд Кавказын зүүн хэсэгт, *E. a. uzbekistanica* (Chernov, 1934) Узбекистан болон Туркменистан, өмнөд Казахстан, Киргизстан, Тажикстан улсын хилийн бүс нутгуудад, *E. a. Darevskii* (Tsaruk, 1986) Киргизийн Исик-Кулийн хотгорт, *E. a. Potanini* (Bedrjaga, 1912) Казахстаны Балхаш нуур, Зайсангийн хотгортой зэргэлдээх нутгаас олддог (IUCN, 2023). Монгол оронд салбар зүйлийн судалгаа хараахан хийгдээгүй, цаашид зүйлийн ангилал зүйн нарийвчилсан судалгаа шаардлагатай.

**Таних шинж.** Их биеийн урт 9.5 см. Нүдний дээд бамбай хайрс дух зулайн бамбай хайрснаас жижиг мөхлөгөн хайрсаар тусгаарлагдаагүй. Дух хамрын хайрс нэг. Духны өмнөх бамбай хайрс хоёр бөгөөд зарим бодгальд бас нэг жижиг нэмэгдэл мөхлөгтэй. Духны бамбай хайрсны тууш гурви маш тод илэрсэн. Нүдний доод бамбай

хайрс аманд хамаарахгүй. Дээд уруулын бамбай хайрсаар тусгаарлагдсан. Нурууны хайрс 47-58, хоолойн хайрс 25-34, гуяны сүв 6-14. Сүүл богино, угаараа бүдүүн, үзүүр рүүгээ огцом нарийссан. Их бие цайвар, эсвэл боровтор хүрэн дэвсгэртэй бөгөөд түүн дээр нурууны хоёр талаар үргэлжлэн эгнэсэн хэд хэдэн том тод хүрэн толботой, хэвлий цайвар (Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Энэ зүйлийн Монгол дахь тархац нутаг нь түүний дэлхийн тархцын зүүн хязгаар болно. Монгол оронд энэ зүйлийн тархац нутгийн хэмжээ бага, хязгаарлагдмал нутаг дэвсгэрийг хамардаг.

**Үнэлгээ хийсэн:** П.Золжаргал, Х.Тэрбиш, М.Мөнхбаатар (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Г.Онолрагчаа, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Зүүн умард Румын, Украйны өмнөд нутаг, Турк (Szczerbak, 1974), Оросын баруун өмнөд (өмнөдөөс умард Кавказ, зүүн тийш Урал хүртэл), Гүржийн зүүн хэсэг, Молдавын өмнөд, Армен (Севан голын сав), Умард Иран, Умард Азарбайжан, Казахстаны баруун, зүүн хэсэг, Узбекистан, Тажикистан, Киргизстан, Хятадын баруун умард хэсэг (Шинжаан, Өвөр Монгол), Монголын баруун өмнөд хэсгээр тархжээ (Uetz, 2006).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Ховд аймгийн Үенч, Булган, Алтай сумын нутаг, Зүүн гарын говийн заг, нохой шээрэн, тэсэг, ортууз, баглуур зэрэг бут, сөөг бүхий хайрга чулуут цөлөөр (3.4; 8.2) тохиолдоно (Мөнхбаяр, Шагдарсүрэн, 1968; Орлова и Тэрбиш, 1986; Тэрбиш, 1989; Мөнхбаяр, 1987; Семенов и Мунхбаяр, 1996; Мөнхбаяр, Тэрбиш, 1997). Энэ зүйлийн Монгол дахь тархац нь дэлхийн тархцын зүүн умард хил болдог. Монголд далайн түвшнээс дээш 1,200-2,000 м өндөрт тохиолдоно (Орлова и Тэрбиш, 1986; Аненьева и др., 1997).



**Амьдралын онцлог.** Заг, тэсэг, нохой шээрэн бүхий хайргат цөл, ортууз, баглуур, монгол өвст заримдаг цөл, хармагтай дов элсэнд амьдарна. Их төлөв нүх ухаж орогнох боловч заримдаа бусад амьтны нүх, ургамлын үндэсний хоорондох зай, газрын ан цавд орогноно. 4-р сарын дунд үеэс ичээнээс гарч 10-р сарын эхээр ичнэ. Өдрийн турш идэвхтэй. Их төлөв цох, эрвээхэй, шоргоолж, аалзаар хооллоно. Мөн үр зулзагаа идэх тохиолдол бий (Мөнхбаяр нар, 2023).

**Тоо толгой, нягтшил.** Тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлагын талаарх мэдээлэл хангалтгүй. Хөрш зэргэлдээх Хятадын популяциас сэлбэгдэх боломжтой ч популяцийн тоо хэмжээ, нүүдэл шилжилтэд саад болох өндөр уул болон бусад шалтгааны талаарх мэдээлэл бараг үгүй. Цаашид дээрх чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай. Монгол оронд энэ зүйлийн тархац нутаг хязгаарлагдмал,

ховор зүйл гэж үздэг (Terbish *et al.*, 2006).

**Ховордлын шалтгаан.** Ховордлын талаар мэдээ баримтгүй. Ашигт малтмалын хайгуул, олборлолт, уул уурхайн үйлдвэрлэлийн (1.3.1) улмаас түүний амьдрах орчин доройтож, улмаар тоо толгой нь буурч болзошгүй. Махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2), махчид ба золиос бологчдын идэш тэжээлийн холбоо (8.3), ган (7.1), зуд (7.3) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр толбот гүрвэлийн тоо толгой буурах магадлал өндөр.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон ба ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1) агнаж, барьж болно. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Говийн Их дархан цаазат газрын “Б” хэсэгт хамрагджээ. Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэв (Мөнхбаяр нар, 2016).

#### **Хамгаалах арга хэмжээ**

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Ховордож болзошгүй” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах үндэсний эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2).
- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах.
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2).
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.13. ЗАГАЛТ ГҮРВЭЛ

### *Eremias vermiculata* (Blanford, 1875)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Жинхэнэ гүрвэл (Lacertidae)

**Англи нэр:** Variegated Racerunner

**Ижил нэр:** *Poderces (Eremias) pewzowi* Strauch, 1876; Central Asian racerunner.



**Ангилал зүйн тойм.** Энэ зүйлийн ангилал зүйн судалгаа Монгол орны хувьд бүрэн гүйцэд хийгдээгүй.

**Таних шинж.** Их биеийн урт 6.5 см. Нүдний доод бамбай хайрс амандаа ямагт хамаарсан. Доод эрүүний 5 дугаар бамбай хайрс, доод уруулын бамбай хайрстай хамаараагүй. Нүдний дээд бамбай хайрс жижиг мөхлөгөн хайрсаар эргэн тойрон хүрээлэгдсэн. Сүүлийн 9-10 дугаар үеийн нэг эгнээ хайрс 29-39, гуяны сүв 16-25. Загалт гүрвэл элсэн шаргал. Ийм дэвсгэр дээрх хар өнгийн зурааснууд тууш, торлосон, тахирласан хорхой маягийн гэсэн гурван

хэлбэрээр тохиолдоно. Хэвлий цагаан, эсвэл шаргал (Мөнхбаяр нар, 2023).

#### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутгийнхаа хүрээнд өндөр нягтшилтай, тоо толгой элбэг зүйл бөгөөд популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үнэлж дээрх үнэлгээг хэвээр үлдээв.


**Үнэлгээ хийсэн:** М.Мөнхбаатар, Х.Тэрбиш,

П.Золжаргал, (2025).

**Үнэлгээ хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Г.Онолрагчаа, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Казахстаны зүүн хэсэг, Хятадын баруун умард нутаг (Шинжаанаас зүүн тийш Өвөр Монгол хүртэл), Монгол орны төв болон өмнөд нутгаар тархсан (Мөнхбаяр, 1976а; Ананьева и др., 1998; Кубыкин, 1984; Uetz *et al.*, 2006).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Алтайн Өвөр говь, Алашаа говийн баянбүрдээр (8.2) тархсан. Умард говьд хоёр цэгт тэмдэглэсэн (Мөнхбаяр, Тэрбиш, 1981; Семенов и Боркин, 1986; Ананьева и др., 1997; Terbish *et al.*, 2006). Монгол оронд далайн түвшнээс дээш 750-1,450 м өндөрт тохиолдоно (Боркин, 1986; 1986а; Семенов и Боркин, 1986; Ананьева и др., 1997).



**Амьдралын онцлог.** Цөлийн бут, сөөг бүхий элсэрхэг нутагт тархсан. Хатуу хайргат цөлд ховор тохиолдоно. Өдрийн идэвхтэй, өвөл ичнэ. Шавж хорхойгоор хооллоно. Өндөглөж үржинэ. Заг, хармаг, торлог, улаан бударгана, будраа, чихэр өвс бүхий баянбүрд, дов элсэнд нэлээд элбэг. Харин хайргат цөл, марцархаг газруудад тоо толгойн хувьд бага нягтшилтай (Мөнхбаяр нар, 2023).

**Тоо толгой, нягтшил.** Тархац нутгийнхаа хүрээнд өндөр нягтшилтай, элбэг зүйл. 1 га-д 50 хүртэл бодгаль тоологддог (Terbish *et al.*, 2006; Мөнхбаяр нар, 2023).

**Ховордлын шалтгаан.** Ашигт малтмалын хайгуул, олборлолт, уул уурхайн үйлдвэрлэлийн (1.3.1) улмаас түүний амьдрах орчин доройтож, улмаар тоо толгой нь буурч болзошгүй. Махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2), махчид ба золиос бологчдын идэш тэжээлийн холбоо (8.3), ган (7.1), зуд (7.3) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр загалт гүрвэлийн тоо толгой буурах магадлалтай.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Говийн Их дархан цаазат газрын “А”, “Б” хэсэг, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар, Говийн Бага дархан цаазат газрын “А” хэсэгт хамрагджээ.

#### **Хамгаалах арга хэмжээ**

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.14. ЗҮҮНГАРЫН ГҮРВЭЛ

*Eremias dzungarica* (Orlova, Poyarkov Jr., Chirikova, Nazarov, Munkhbaatar, Munkhbayar and Terbish, 2017)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Жинхэнэ гүрвэл (Lacertidae)

**Англи нэр:** Dzungarian Racerunner

**Ижил нэр:** *Eremias multiocellata* (Gunther, 1872).



**Ангилал зүйн тойм.** Энэ зүйлийг *Eremias przewalskii*-*E. multiocellata* комплекс зүйлд хамтатган, *E. multiocellata*-д хамааруулж байсан бөгөөд молекул генетикийн судалгаагаар бие даасан зүйл болгохыг тогтоосон (Orlova et al., 2017).

**Таних шинж.** Бие гүйцсэн бодгалийн биеийн урт 6.5 см, сүүл нь биеэсээ ойролцоогоор 1.5 дахин урт. Нүдний доорх бамбай хайрс нь аманд хүрэхгүй, доод уруулын бамбай хайрс 6-8. Нурууны толбо зузаан хараар бүрхэгдсэн толботой, эхний 2-3 нь эрэгтэй

дээр тод өнгөтэй. Биеийн хажуугийн толбо ногоон хөх, жигд бус хар толботой (Orlova et al., 2017).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Үнэлгээний хийгдээгүй (IUCN, 2023)

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Үнэлгээ хийгдээгүй (Terbish et al., 2006a; Terbish et al., 2006b).

2025 онд Үнэлэх боломжгүй (NA). Тархац нутаг, тоо толгойн хэмжээний талаарх мэдээ, баримт хомс.

**Үнэлгээ хийсэн:** М.Мөнхбаатар, Х.Тэрбиш, П.Золжаргал, (2025).

**Үнэлгэээ хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Г.Онолрагчаа, Ж.Гүррагчаа, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Энэ зүйл нь Казахстаны зүүн хэсэг Айгыркум элсэнд, мөн Улкен-Каратал, Бух-тарма усан сангийн элсэрхэг эрэг, Аштутас ууланд бий. Мөн Хятадын Шинжаан-Уйгурын хойд хэсэгт Тянь Шанийн уулсаас хойш тархсан байх боломжтой (Orlova *et al.*, 2017; Buehler *et al.*, 2021).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол оронд хязгаарлагдмал тархацтай. Ховд аймгийн Үенч сум, Булган сумын Баян-Мод, Ихэр-Толь булгийн ойр орчмоор тохиолдоно (Orlova *et al.*, 2017).



**Амьдралын онцлог.** *E. multiocellata*-тай төстэй амьдрах орчинд амьдрах боловч 2,600 м-ээс дээш өндөрт байдаг. Энэ зүйл нь заг, харгана, бударгана, багалуур зэрэг ургамлын бүрхэвч сийрэг, хад, чулуурхаг орчинд (6; 8.2) тархжээ. Ховд аймгийн Үенч сумын ойролцоо *E. dzungarica* нь *E. multiocellata*-тай амьдрах орчин давхацдаг боловч экологийн хувьд хуваагдан өөр өөр бичил орчныг шүтдэг. *E. multiocellata* нам дор өндөрлөг элсэнд тархдаг бол *E. dzungarica* нь зэргэлдээх уулсын чулуурхаг бэлд тохиолддог (Orlova *et al.*, 2017; Buehler *et al.*, 2021).

**Тоо толгой, нягтшил.** Энэ талаарх мэдээ, баримт хомс.

**Ховордлын шалтгаан.** *E. multiocellata* гүрвэлийн зүйлд хамаарч байсан тул бие даасан зүйлийн хувьд ховордлын шалтгаан хараахан тодорхойгүй.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Булган гол-Онгогийн байгалийн цогцолборт газарт хамрагджээ.

#### Хамгаалах арга хэмжээ

- Ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.15. ГАВШГАЙ ГҮРВЭЛ

### *Lacerta agilis* (Linnaeus, 1758)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Жинхэнэ гүрвэлийн овог (Lacertidae)

**Англи нэр:** Sand Lizard

**Ижил нэр:** *Lacerta boemica* (Suchov, 1929); *Lacerta paradoxa* (Bedriaga, 1886); *Lacerta stirpium* (Daudin, 1802).



**Ангилал зүйн тойм.** Филогенетикийн судалгаагаар (Kalyabina *et al.*, 2001) популяцийн гурван бүлгийг тодорхойлсон ч ангилал зүйн байдлыг үнэлэхийн тулд нийт тархац нутгийн хүрээнд нэмэлт судалгаа хийх шаардлагатай (Crochet and Dubois, 2004). Мөн энэ зүйл нь “олон” дэд зүйлтэй (Spreybroeck *et al.*, 2016), есийг нь ерөнхийд нь хүлээн зөвшөөрдөг (Andres *et al.*, 2014) гэхдээ бусад тодорхойлогдсон дэд зүйлүүдийн тоо болон тэдгээрийн тархцын хил хязгаарын хувьд зохиогчдын хооронд тодорхой хэмжээний зөрчил бий (IUCN, 2023). Монголд *L. a. exigua* (Eichwald, 1831) хэмээх салбар зүйлийг тэмдэглэсэн (Тэрбиш, Мөнхбаяр, 1988).

**Таних шинж.** Их биеийн урт 9-11 см. Сүүл нь их биеэсээ ойролцоогоор 1,5 дахин урт. Хоолойн хайрс 14-25 см, эрүүн завсрын хайрс хамрын сүвэнд, зулайн хайрс нүдний арын дээд хайрсанд тус тус хамаараагүй. Хамрын арын хайрс 1-3, нүдний доод бамбайн хайрсны өмнө орших дээд уруулын

бамбайн хайрс ихэвчлэн 4, хааяа 3, эсвэл 5 байна. Хэвлийн хайрснууд их биеийн дагуу 6 эгнээгээр байрлана. Төгсгөлийн сүвний хайрсны урд талаар 4-8 бамбай хайрс хүрээлэн оршино. Гуяны сүв өвдөгний үед хүрсэн. Хойд хөлийн 4-р хурууны доод талд 16-23 хавтгай илтэс (хайрс) бий. Эм бодгаль ерөнхийдөө саарал, эсвэл хүрээтэр, нурууны дагуу нэлээд тод бараан өнгийн судлуудтай. Эдгээр судал дээр цагаан хүрээтэй зөв биш хэлбэрийн хар, хар хүрэн, эсвэл хүрэн толботой. Харин бие гүйцсэн эр бодгалийн бие олон тооны бараан толбо бүхий ногоон зүстэй (Мөнхбаяр нар, 2010).

#### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).

2025 онд Эмзэг (VU), D2. Энэ зүйлийн Монгол дахь тархац нутгууд нь дэлхийн тархцын зүүн хязгаар болно. Монгол оронд

энэ зүйлийн тархац нутгийн нийт хэмжээ бага газар нутгийг хамардаг.

**Үнэлгээ хийсэн:** Х.Тэрбиш, М.Мөнхбаатар, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, П.Золжаргал, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Франц, Англи, Бельги, Нидерланд, Герман, Норвег, Швейцар, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Хорват, Польш, Швед, Босни Херцеговин, Унгар, Сербии Монтенегро, Албани, Грек, Румын, Латви, Литва, Македон, Эстони, Болгар, Украин, Беларусь, Турк, Орос, Молдова, Гүрж, Армен, Азарбайжан, Казахстан, Хятад, Монгол, Киргизстанд тус тус тархжээ (Uetz *et al.*, 2006).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол Алтайн нурууны баруун, баруун өмнөд хэсэг, Баян, Сонгинот голын сав дагуу арцны бүлгэмдэлтэй уул толгодоор тархана (Тэрбиш, Мөнхбаяр, 1988; Terbish *et al.*, 2006). Монгол оронд далайн түвшнээс дээш 1,700-2,500 м өндөрт тохиолдоно (Тэрбиш, Мөнхбаяр, 1988).



**Амьдралын онцлог.** Монгол оронд бараг судлагдаагүй.

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Ашигт малтмалын хайгуул, олборлолт, уул уурхайн

үйлдвэрлэлийн (1.3.1) улмаас түүний амьдрах орчин доройтож, тоо толгой нь буурч болзошгүй. Махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2), махчид ба золиос бологчдын идэш тэжээлийн холбоо (8.3), ган (7.1), зуд (7.3) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр гавшгай гүрвэлийн тоо толгой буурах магадлал өндөр.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалтай газар нутгийн Ёлт, Сонгинот, Хар Ямаатын голын савд хамрагдана.

#### Хамгаалах арга хэмжээ

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Эмзэг, D2” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах үндэсний эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 3.16. ЗУЛЗАГАЛАГЧ ГҮРВЭЛ

### *Zootoca vivipara* (Jacquin, 1787)

**Баг:** Хайрстан (Squamata), Гүрвэлийн салбар баг (Sauria)

**Овог:** Жинхэнэ гүрвэл (Lacertidae)

**Англи нэр:** Viviparous Lizard

**Ижил нэр:** *Lacerta vivipara* (Nikolsky, 1905).



**Ангилал зүйн тойм.** Энэ зүйлийн ангилал зүйн судалгаа Монгол орны хувьд бүрэн гүйцэд хийгдээгүй.

**Таних шинж.** Их биеийн урт 7-6 см. Хоолойн хайрс 13-23. Эрүү завсрын хайрс хамрын сүвэнд хамаарахгүй. Хамрын арын хайрс нэг, хааяа хоёр. Нүдний доод бамбай хайрсны өмнө орших дээд уруулын бамбай хайрс ихэвчлэн 3-4, хааяа 5. Нүдний дээд хайрс зулайн хайрсанд хамаарсан. Хоолой нугалаа байхгүй, эсвэл сул илэрсэн. Хэвлийн хайрс биеийн тууш дагуу 6-8 тооны эгнээгээр байрлана. Төгсгөлийн сүвний хайрсны урд талаар 4-8 тооны бамбай хайрс ихэвчлэн хоёр эгнээгээр оршино. Гуяны сүв өвдөгний үед хүрсэн. Биеийн хажуугаар дээд, доод талаасаа цайвар толбоор эмжигдсэн бараан

зурвас бий. Нурууны дагууд ихэвчлэн бараан судалтай. Эрийн хэвлий хул шар, эмийнх цагаан шаргал, эсвэл ногоовтор (Мөнхбаяр нар, 2010).

#### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бус нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, хэвийн нягтшилтай зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үзэв. Энэ зүйл дэлхийн хэмжээнд өргөн тархсан бөгөөд Монголд дэлхийн тархцын нэгээс бага хувь тохиолдож байгаа хэдий ч энэ нь тус улсын нийт нутаг дэвсгэрийн


нэгээс илүү хувийг эзэлж байгаа юм. Энэ үзүүлэлт хамгааллын үнэлгээний нэг үндсэн шалгуур болно. Хөрш зэргэлдээх Хятад болон Оросын популяциас зохих хэмжээнд тэтгэгдэх боломжтой.

**Үнэлгээ хийсэн:** Х.Тэрбиш, М.Мөнхбаатар, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ (2025).

**Үнэлгээ хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, П.Золжаргал, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Ирланд, Пиренейн хойгоос зүүн тийш Колым, Шантарын арлууд, Сахалин хүртлэх Евразийн өргөн уудам нутагт тархжээ (Ананьева и др., 1997). Тархалтын хойд хил Хойд туйл хүрнэ (Банников и др., 1977).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол Алтайн нурууны баруун хойд нутаг, Хэнтийн нуруу, Хөвсгөл, Их Хянганы уулсын ой тайга (1.1), ойт хээрийн (1.4) бүсээр тархжээ. Дархадын хотгорын Улаан тайга орчимд уулын тундрт тэмдэглэсэн (Мөнхбаатар, Цэвээнмядаг, 2002; Мөнхбаатар, 2003; Terbish *et al.*, 2006).



**Амьдралын онцлог.** Шилмүүст болон холимог ойд рашаан ус, горхи булаг, нуга газрыг бараадаж амьдарна. Зуны дулаан цагт өглөө эрт юм уу зөөлөн борооны дараа идэвх нь нэмэгдэнэ. Усанд сэлж, усан дор хэсэг хугацаагаар байж чадна. Ургамлын үндэсний завсар зай, модны хонгил хөндий, унасан дархины дор юм уу нүхэнд орогноно. Цох, сарьсан далавчтан, дэвхрэг, ялаа батгана, чийгийн улаан хорхой, аалзаар хооллоно. 7-р сарын эцэс, 8-р сарын эхээр амьд зулзага төрүүлж үржинэ. Дунджаар 8-10 үрвэл төрүүлнэ.

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Ховордлын талаар мэдээ баримт хомс. Ашигт малтмалын хайгуул, олборлолт, уул уурхайн үйлдвэрлэлийн (1.3.1) улмаас түүний амьдрах орчин доройтож, тоо толгой нь буурч болзошгүй. Мөн махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2), махчид ба золиос бологчдын идэш тэжээлийн холбоо (8.3), ган (7.1), зуд (7.3) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр зулзагалагч гүрвэлийн тоо толгой буурах магадлал өндөр.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 25% орчим нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (UNEP-WCMC, 2006; Мөнхбаяр нар, 2023).

#### Хамгаалах арга хэмжээ

- Ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй.

**ДӨРӨВДҮГЭЭРБҮЛЭГ**

**МОНГОЛ ОРНЫ МӨЛХӨГЧДИЙН АНГИЙН  
МОГОЙН САЛБАР БАГИЙН АМЬТДЫН  
БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ**



## 4.1. ТЭМЭЭН СҮҮЛ МОГОЙ

### *Eryx tataricus* (Lichtenstein, 1823)

**Баг:** Хайрстан (Squamata), Могойн салбар баг (Serpentes)

**Овог:** Аварга могойн овог (Boidae)

**Англи нэр:** Tatory Sand Boa

**Ижил нэр:** *Boa tatarica* (Lichtenstein, 1823); *Eryx miliaris tataricus*, *Eryx speciosus* (Tsarevsky, 1915); *Eryx vittatus* (Szczerbak, 2003).

**Ангилал зүйн тойм.** *Eryx miliaris*-тай маш төстэй (Ezkandarzadeh et al., 2013). Ezkandarzadeh нар (2013) Монгол оронд энэ хоёр зүйл байгааг мэдээлж, тархцын тоймлосон боловч Zhao and Adler (1993) болон Terbish нар (2006) Монгол оронд зөвхөн *E. tataricus* тохиолддог бөгөөд тус зүйл гурван дэд зүйлтэй (*Eryx tataricus speciosus* (Carevsky, 1916); *E. t. tataricus* (Lichtenstein, 1823); *E. t. vittatus* (Cernov, 1959)) хэмээн үзсэн. Энэ зүйлийн ангилал зүйн асуудал маргаантай хэвээр байна (IUCN, 2023).

**Таних шинж.** Их биеийн урт 98 см, сүүлийн урт 6-7 см. Эрүүн завсрын бамбай хайрснаас хойш ихэвчлэн 2-3, хааяа 4 бамбай хайрс оршино. Нүд нь хажуу тийш юм уу яльгүй дээш чиглэсэн. Нүдний хооронд нэг эгнээнд 7-9 тооны зөв биш олон өнцөгт бамбай хайрстай. Нүдний эргэн тойронд 10-14, ихэвчлэн 11-12 хайрс хүрээлэн оршино. Дээд уруулын хоёр дахь бамбай хайрс, гурав дахиас ихэвчлэн намхан, их биеийн хайрс 43-49, хэвлийн хайрс нарийхан учир их биеийн доод талыг бүрэн эзлээгүй, тоо нь 169-213. Их бие нь шаравтар бор ба түүн дээр бор хүрэн, хар хүрэн, харавтар өнгийн торлосон толбууд нуруу, биеийн хажуугаар байрлана. Хэвлий нь цайвар, толбо нь нэлээд шигүү (Мөнхбаяр нар, 2010).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Terbish et al., 2006a; Terbish et al., 2006b).

2025 онд Эмзэг (VU), B1ab(ii). Энэ зүйл өргөн уудам нутагт тархсан хэдий ч тоо толгой цөөн,



нягтшил бага. Тархац нутгийн зарим хэсэг нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан ч ашигт малтмал зэрэг байгалийн нөөцийн олборлолт, хур тунадасны татрал, ургацын бууралттай уялдсан идэш тэжээлийн хомсдол зэрэг хүний үйл ажиллагаа, байгалийн хүчин зүйлсийн улмаас амьдрах орчин доройтож, тоо толгой нь буурах эрсдэл эрс нэмэгдэж байна. Одоогоор энэ зүйлийг ховор зэргийн ангилалд оруулах боломжгүй ч цаашдын судалгаагаар популяцийн тоо толгой буурч байгаа нь тогтоогдвол А шалгуураар дахин үнэлэх шаардлагатай.


**Үнэлгээ хийсэн:** М.Мөнхбаатар, Х.Тэрбиш, П.Эрдэнэтүшиг (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Золжаргал, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Иран, Казахстаны зүүн нутаг, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистаны баруун нутаг, Тажикстан, Хятад, Монгол, Киргизстанд тархсан (Uetz et al., 2006).

### Монгол орны тархац, амьдрах орчин.

Алашаа говийн Борзон, Алтайн Өвөр говийн Зээмэг, Ногоон цав, Толь булаг, Эхийн гол, Тахийн шар нурууны баруун хэсэг, Ногоон довонгийн ус, Умард говийн Уулын худаг зэрэг газарт тархсан (Мөнхбаяр, 1976а; Семенов и Мунхбаяр, 1996; Мөнхбаяр, Тэрбиш, 1997; Terbish *et al.*, 2006). Монгол оронд далайн түвшнээс дээш 700-1,800 м өндөрт тохиолдоно (Ананьева и др., 1997).



**Амьдралын онцлог.** Жинхэнэ элсэн цөлийн амьтан. Алтайн Өвөр говьд заг бүхий элсэн цөлд (8.1) амьдарна. Эхийн голд идэшний ногоо, жимс жимсгэнийн талбай (11.1; 11.3), байшингийн доод хонгилоор тохиолдоно. Мэрэгч амьтдын нүхэнд орогноно. Гүрвэл, мэрэгч, бор шувууны багийн жижиг шувуудаар хооллоно. Амьд зулзага төрүүлнэ. Хоргүй могой (Мөнхбаяр, Тэрбиш 2010).

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2), махчид ба золиос бологчдын идэш тэжээлийн холбоо (8.3), ган (7.1), зуд (7.3) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр тэмээн сүүл могойн тоо толгой буурах магадлал өндөр.

**Хамгаалсан байдал.** Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын II хавсралтад бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018; <http://checklist.cites.org>). Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх,

хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон ба ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1) агнаж, барьж болно. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутаг Говийн Их дархан цаазат газрын “А”, “Б” хэсэг, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар, Говийн Бага дархан цаазат газрын “А” хэсэгт хамрагдсан.

Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгджээ (Мөнхбаяр нар, 2016).

### Хамгаалах арга хэмжээ

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Эмзэг, B1ab(ii)” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг төрийн бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 4.2. УСНЫ МОГОЙ

### *Natrix natrix* (Linnaeus, 1758)

**Баг:** Хайрстан (Squamata), Могойн салбар баг (Serpentes)

**Овог:** Нарийн могойн овог (Colubridae)

**Англи нэр:** European Grass Snake

**Ижил нэр:** *Tropidonotus natrix* (Linnaeus, 1758); *Coluber natrix* (Linnaeus, 1758); *Coluber persa* (Pallas, 1814); *Coluber scutatus* (Pallas, 1771); *Coluber torquatus* (Lacépède, 1789); *Natrix megalosephala* (Orlov and Tuniyev, 1987); *Natrix vulgaris* (Laurenti, 1768); *Tropidonotus ater* (Eichwald, 1831); *Natrix natrix* (Банников, 1958); *Natrix natrix natrix* (Obst, 1963); Grass Snake.



**Ангилал зүйн тойм.** Политип зүйл. Судлаачид усны могойг 3-10 хүртэл салбар зүйлд ангилал боломжтой хэмээн үздэг ч одоогоор нэгдсэн ойлголтод хараахан хүрээгүй байна. Монгол оронд *Natrix natrix scutata* (Банников и др., 1977; Ананьева нар, 1977) хэмээх салбар зүйл тархжээ.

**Таних шинж.** Их биеийн урт 120 см. Хамрын хоорондох бамбай хайрс трапец хэлбэртэй. Нүдний өмнөх бамбай хайрс нэг (маш ховор хоёр). Нүдний ард гурав, хааяа хоёр, эсвэл дөрвөн бамбай хайрстай. Их биеийн нэг эгнээний хайрс 19. Хэвлийн хайрс 152-193. Сүүлийн дор 50-89 хос хайрстай, ар шилэн дээрээ шар өнгийн хос том толботой. Биеийн зүс хар, эсвэл хар бараавтар, хэвлий нь сүүн цагаан өнгөтэй, түүн дээр хөндлөн хар толбууд бий.

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Terbish et al., 2006a).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Монгол оронд хязгаарлагдмал баг нутагт, ховор, цөөн тоогоор тохиолдох бөгөөд бага судлагдсан зүйл.


**Үнэлгээ хийсэн:** Х.Тэрбиш, М.Мөнхбаатар, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Золжаргал, П.Эрдэнэтүшиг, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Марокко, Алжир, Португал, Испани, Франц (Корсика), Англи, Нидерланд, Герман, Норвег, Швейцар, Люксембург, Итали, Тунис, Дани, Австри, Чех, Словени, Хорват, Швед, Польш, Босни Херцеговин,

Унгар, Албан, Финланд, Ирак, Кипр, Румын, Македон, Латви, Литва, Эстони, Украин, Болгар, Беларус, Турк, Орос, Молдав, Сири, Гүрж, Армени, Ираны умард нутаг, Азарбайжан, Казахстан, Туркменистан, Хятадын баруун умард нутаг (Шинжаан-Уйгар), Монголын умард нутгаар тархсан (Uetz *et al.*, 2006; Terbish *et al.*, 2006a).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Дэлхийн тархцын өмнөд хил Монгол орны хойд нутгийн шилмүүст болон холимог ой, нуга, намгархаг зарим нутагтай давхцадаг. Сэлэнгэ, Орхон, Сүхдэй, Онон, Улз голуудын сав, Хөвсгөл орчмын нутгаар тархжээ (Мөнхбаяр, 1976б; Семенов и Мунхбаяр, 1996; Ананьева и др., 1997; Terbish *et al.*, 2006a). Монгол оронд усны могойг тэмдэглэсэн цөөн хэдэн цэг нь далайн түвшнээс дээш 500-600 м өндөрт байв. Гэвч энэ зүйлийн өндрийн тархалтын талаарх бодит баримт хараахан тодорхой бус. Бусад улсад хийсэн судалгааны дүнгээс үзвэл, далайн түвшнээс дээш 2,000-2,500 м өндөрт тохиолддог байна (Ананьева и др., 1997). Энэ зүйлийн Монгол дахь эзлэн амьдрах талбайн хэмжээг 130,692 орчим км<sup>2</sup> гэж үнэлсэн.



**Амьдралын онцлог.** Нуур цөөрөм (5.5; 5.6; 5.7), гол горхи (5.1), нуга намаг, бамбалзуур (5.4) зэргийг шүтэн амьдарна. Мэрэгчдийн нүх, хад чулууны доорх хөндий хонгил, ан цав, ургамлын үндэсний завсар зайд орогноно. Усанд сайн сэлж, шумбадаг бөгөөд усанд хагас цаг хүртэл хугацаагаар байж чадна. Ихэвчлэн янз бүрийн насны бах, мэлхий, загас, гүрвэл, мэрэгчид, жижиг шувууд, тэдгээрийн ангаахай, дэгдээхэйгээр хооллоно. Хоргүй могой.

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон дахь популяцийн талаар мэдээ, баримт үгүй.

**Ховордлын шалтгаан.** Хур тунадас багасаж, гол, горхи хатаж ширгэн (7.1), амьдрах орчин доройтсоноос энэ зүйл бөөнөөрөө устах эрсдэлтэй. Мөн гол, мөрний сав дагуух ашигт малтмалын хайгуул, олборлолт зэрэг уул уурхайн (1.3.1) үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нөлөөгөөр амьдрах орчин доройтох нь энэ зүйл амьтны тоо толгойд сөргөөр нөлөөлж буй хүний үндсэн хүчин зүйл болно. Голын ус бохирдсоноос (6.3.1; 6.3.2; 6.3.8) энэ зүйлийн идэш бологч амьтдын тоо толгой мөн буурч байна. Орос, Хятадад энэ зүйлийг цуглуулан амьтны дэлгүүрт худалдаалдаг (3.5.1).

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 11% орчим нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (Мөнхбаяр нар, 2023).

#### Хамгаалах арга хэмжээ

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Ховордож болзошгүй” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах үндэсний эрх зүйн баримт бичгийг төрийн бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 4.3. НАРИЙН МОГОЙ

### *Orientocoluber spinalis* (Peters, 1866)

**Баг:** Хайрстан (Squamata), Могойн салбар баг (Serpentes)

**Овог:** Нарийн могойн овог (Colubridae)

**Англи нэр:** Slender Racer

**Ижил нэр:** *Masticophis spinalis* (Peters, 1866); *Hierophis spinalis* (Schmidt, 1988).

**Ангилал зүйн тойм.** *Hierophis* төрөл нь парафилетик бөгөөд *H. spinalis* нь *Hierophis*-ийн бусад зүйлээс илүү *Eirenis*-тэй илүү ойр байдаг болохыг тогтоосон (Nagy *et al.*, 2004). *H. spinalis*-ийг *Eirenis*-д шилжүүлэх тухай зохиогчийн энэхүү саналыг судлаачид төдийлөн хүлээн зөвшөөрөөгүй. Kharin (2011) энэ зүйлийг *Orientocoluber* төрөлд хамааруулсан (IUCN, 2023). Энэ зүйлийн ангилал зүйн судалгаа Монгол орны хувьд бүрэн гүйцэд хийгдээгүй.

**Таних шинж.** Их биеийн урт 86 см. Сүүл нь их биеийнхээ уртаас 3-4 дахин богино. Маш нарийн биетэй. Хоншоор дугуйвтар бөгөөд дээд тал нь хавтгай. Нүдний өмнөх хайрс 2, хааяа 1. Нүдний арын хайрс нь 2. Дээд уруулын бамбай хайрс 7-8. Түүний 4 ба 5-р хайрс нь нүдэнд хамаарна. Сүүлийн доод хайрс 91-101 хос. Их биеийн ерөнхий дэвсгэр цайвар бор, дух зулайн хайрснаас эхлэн нурууны тууш дагууд цагаан шаргал өнгийн тод судалтай. Энэ судлын 2 талаар нэлэнхий үргэлжилсэн, эсвэл тасархайтсан нарийн хар зураас эмжин байрлана. Дээд уруул, нүдний өмнөх болон нүдний арын бамбай хайрснууд цайвар шар юм уу цагаан өнгөтэй. Хэвлий цайвар (Мөнхбаяр, Тэрбиш 2010).

#### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Үнэлгээ хийгдээгүй (NA) (IUCN, 2006), Анхааралд өртөхөөргүй (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Хязгаарлагдмал тархацтай, бага судлагдсан зүйл.




Энэ зүйл өргөн уудам нутагт тархсан ч, тоо толгой цөөн. Ган зуд болох, идэш тэжээлийн хомсдол, байгалийн нөөц, ашигт малтмалын олборлолт зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр түүний амьдрах орчин доройтож, тоо толгой нь буурч байгааг тогтоовол А шалгуураар дахин үнэлж зэрэглэлийг ахиулах боломжтой.

**Үнэлгээ хийсэн:** М.Мөнхбаатар, Х.Тэрбиш, П.Золжаргал (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, П.Эрдэнэтүшиг, Ж.Гүррагчаа, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Орос, Казахстаны дорнод нутаг, Хятадын хойд нутаг (Шинжаны баруун нутгаас Хеионджианы зүүн нутаг хүртэл, хойшоо Жиангсу, Шантунг, Нонан, Гансу, Сюяан, Шанси, Хопей, Жехол), Монгол, Солонгосын хойгт тархсан (Uetz *et al.*, 2006).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Цөл, цөлөрхөг хээр, хуурай хээрийн бүсийн хад асгатай уулсын энгэр, бэл (6), дэрс, хармаг, бударгана зэрэг бут, сөөг бүхий элсэрхэг хөрстэй цөл, цөлийн хээр, хээрт (3.4; 8) амьдарна (Мөнхбаяр, Тэрбиш, 1997). Алтайн Өвөр говийн Захуй, Зарман, Аж Богд, Тост, Ноён, Говь Алтайн нурууны Их Богд, Нууруудын хөндийд Орог нуур, Холбоолж нуур, Хангай нурууны зүүн өмнөд үзүүр, Умард говийн Дэлгэрхангай, Баян дов, Талын худаг, Алашань говийн Буурын нуруу, Ханбогд, Зурамтай уул, Хоолойн гашуун, Дорнод говь, Дарьганга Сулинхээр зэрэг газраас тэмдэглэжээ (Банников, 1958; Мөнхбаяр, 1971; 1982; Семенов и Шенброт, 1986; Ананьева и др., 1997). Мөн Хангай, Хэнтий нурууны зааг нутаг Орхон голын хөндий Цагаан толгойн сангийн аж ахуйн орчимд тэмдэглэгдсэн (Terbish *et al.*, 2006). Монгол оронд далайн түвшнээс дээш Орхон голын савын 800 м-ээс Ноён уулын 1,900 м өндөрт тохиолдоно (Ананьева и др., 1997).



**Амьдралын онцлог.** Говь, цөлийн уулсын хад чулуу, бутанд орогнон амьдарна. Янз бүрийн гүрвэлээр хооллоно. 4-9 өндөг гаргана. Хоргүй могой (Мөнхбаяр, Тэрбиш 2010).

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Түлээ, түлшний хэрэгцээний мод бутыг түүх, ургамлыг хэт ашигласнаас (1.8) түүний амьдрах орчныг хомсдолд оруулж байна. Уул уурхайн

үйлдвэрлэлийн (1.3.1) улмаас амьдрах орчин доройтох нь энэ зүйлийн тоо толгой буурах нэг шалтгаан болно. Махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2; 8.3), ган (7.1), зуд (7.3) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр энэ зүйлийн тоо толгой буурах магадлал өндөр.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон. Ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1) агнаж, барина. Хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Тархац нутгийн 24% орчим нь тусгай хамгаалалтай газарт хамрагдсан (Мөнхбаяр нар, 2023). Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгджээ (Мөнхбаяр, Мөнхбаатар, 2016).

#### **Хамгаалах арга хэмжээ**

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөг судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй.

## 4.4. РАШААНЫ МОГОЙ

### *Elaphe dione* (Pallas, 1773)

**Баг:** Хайрстан (Squamata), Могойн салбар баг (Serpentes)

**Овог:** Нарийн могойн овог (Colubridae)

**Англи нэр:** Steppe Rat Snake

**Ижил нэр:** *Coluber dione* (Pallas, 1773); Dione Ratsnake, Dione Snake.



**Ангилал зүйн тойм.** Салбар зүйлд хуваагдахгүй. Амьдрах орчноос хамааран олон янзын өнгөний хэлбэр тохиолдох боловч тэдгээр нь ангилал зүйн хувьд ач холбогдолгүй.

**Таних шинж.** Их биеийн урт нь 105 см, сүүлний урт 28 см. Хавтгай, өргөн толгой нь хүзүү хэсгээс үл ялиг өргөн. Их биеийн нэг эгнээ хайрс 21-25, хааяа 27. Улаан хүрэн туяатай сааралдуу, бор шаргал эсвэл цайвар бор зүстэй. Их биеийн тууш дагуу дөрвөн хүрэн судалтай, тэдгээрийн 2 нь сүүлний дагуу үргэлжилнэ. Биеийн хоёр хажуугаар хүрвэтэр өнгийн толбонууд цувран байрлах ба сүүл рүүгээ улам бүдгэрнэ. Толгойн дээд талд хар зураасаар хүрээлэгдсэн угалз мэт

онцлог хээтэй. Хэвлий ягаавтар туяатай цайвар шаргал өнгөтэй бөгөөд бараан хүрэн өнгийн олон толботой (Ананьева и др., 1997; Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).


2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Монгол орон дахь тархан амьдрах талбайн хэмжээг 1,356,223 орчим км<sup>2</sup> гэж үнэлсэн.

**Үнэлгээ хийсэн:** П.Эрдэнэтүшиг, Х.Тэрбиш, Г.Онолпрагчаа, М.Бүрнээ (2025).

**Үнэлгээ хянасан:** Х.Мөнхбаяр, М.Мөнхбаатар, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Украины зүүн нутаг, Орос, Гүрж, Армен, Иран, Азарбайжан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Тажикстан, Хятадын умард нутаг (өмнөөс Сычуаны баруун нутаг хүртэл, Жиангсугийн зүүн нутаг, Киангсу, Шантунг, Шанси, Шенси, Гансу, хойш Чанг Жианг гол хүртэл), Монгол, Киргизстан, Солонгосын хойгт тархсан (Terbish *et al.*, 2006a; Uetz *et al.*, 2021).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол орны говь, цөлийн бүсээс хойд хэсгийн ой тайга хүртэлх өргөн уудам нутагт, өндөр уулын бүсээс бусад байгалийн янз бүрийн бүс, бүслүүрт тархана (Мөнхбаяр, 1976б; Ананьева и др., 1997; Тэрбиш, 1998). Харин Монгол орны зүүн өмнөд хэсэг, Алтайн Өвөр говийн үлэмж нутгаас одоогоор энэ зүйлийг тэмдэглээгүй. Энэ нь судалгаа хийгээгүйтэй холбоотой тул цаашид дурдсан бүс нутагт рашааны могойн тархцын цэгүүд тэмдэглэгдэх үндэстэй. Монгол оронд далайн түвшнээс дээш 600-3,000 м өндөрт тохиолдоно (Ананьева и др., 1997).



**Амьдралын онцлог.** Ойт хээр, хээр, цөлөрхөг хээрийн бүсийн уулс, хад чулуут дов толгод, голын хөндий, хуурай сайр, эрэг ганганы хөвөөгөөр бут сөөг, харгана, дэрс зэрэг ургамалтай газраар (3.4; 4.4; 5.1; 5.2; 5.12; 6; 8.2; 11.5) ихэнхдээ усны ойролцоо тохиолдоно. Өдрийн идэвхтэй, усанд сайн сэлдэг, хоргүй могой. Бах, мэлхий, гүрвэл, жижиг мэрэгч, шувууд болон тэдгээрийн өндгөөр хооллоно. 9-10-р сард ичээлж, 4-р сард ичээнээс гарч үржилд орно. 7-р сард 5-18 өндөг гаргах ба 8-р сард зогойнууд өндөгнөөс гарна. Мэрэгчдийн нүх, хад чулууны ан цав, модны хонгил, хөндий, дархи, чулуун дор, чулуун хашаа, байшингийн завсар, хонгилд орогноно. Гол

дайсан нь махчин шувууд, зараа, үнэг, хярс зэрэг хөхтөн болно (Мөнхбаяр нар, 2023).

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Янз бүрийн биотопыг хамарсан өргөн уудам тархацтай учраас ховордлын шалтгаан төдий хэмжээгээр олон янз. Тухайлбал, хот суурин газрын тэлэлт (1.2.4), ашигт малтмалын олборлолт (1.3.1), зам, тээвэр (1.4.4), түймэр (7.4), орчны бохирдол (6.2; 6.3), гангаас улбаатай ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (7.1), хүний төрөл бүрийн үйл ажиллагааны нөлөөгөөр түүний амьдрах орчин доройтох (1) нь рашааны могойн тархац нутгийг хумьж, амьдрах орчны чанар байдлыг доройтуулж, улмаар тоо толгой нь буурах үндсэн хүчин зүйлс болно (Terbish *et al.*, 2006a).

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Тархац нутгийн 10% орчим нь тусгай хамгаалалтай нутагт хамрагдсан. Монгол дахь тархац нутаг уудам учраас улсын тусгай хамгаалалтай газар нутгуудад тохиолдоно (Terbish *et al.*, 2006; Мөнхбаяр нар, 2023).

#### Хамгаалах арга хэмжээ

- Ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөг судлан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй.

## 4.5. ХАР МӨРНИЙ ЦАРИГ МОГОЙ

### *Elaphe schrenckii* (Strauch, 1873)

**Баг:** Хайрстан (Squamata), Могойн салбар баг (Serpentes)

**Овог:** Нарийн могойн овог (Colubridae)

**Англи нэр:** Amur Rat Snake

**Ижил нэр:** *Coluber schrenckii* (Boulenger, 1894); Great Black, Manchurian Black, Siberian Rat Snake (Frank and Ramus, 1996).



**Ангилал зүйн тойм.** Дэлхийн тархац нутгийн хэмжээнд энэ зүйлийг *Elaphe schrenckii schrenckii* болон *Elaphe schrenckii anomala* хэмээх хоёр салбар зүйлд ялгана. Монгол орны цариг могой нь эх салбар зүйл болох *Elaphe schrenckii schrenckii*-д хамаарах магадлалтай (Ананьева и др., 1997; Terbish *et al.*, 2006; Мөнхбаяр нар, 2023).

**Таних шинж.** Их биеийн урт нь 180 см, сүүлний урт 45 см. Толгой нь хүзүү хэсгээс үл ялиг өргөн. Их биеийн нэг эгнээ хайрс 23 хааяа 25. Биеийн хажуугаас хэвлийн чигт салаалсан хөндлөн шар судлуудтай хүрэн, эсвэл хар. Толгойн дээд тал бараан өнгөтэй. Дээд уруулын хайрснууд (хамгийн сүүлчийнхээс

бусад нь) хөндлөн хар судал бүхий шар. Нүдний араас завж хүртэл үргэлжилсэн хар судалтай, ийм судал зарим бодгальд нүд, хамрын сүвний хооронд ажиглагдана. Доод уруулын бамбай хайрснууд шар өнгөтэй бөгөөд хойд ирмэгээрээ хар эмжээртэй. Хэвлий цагаан шаргал (Ананьева и др., 1997; Мөнхбаяр нар, 2023).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).

2025 онд Үнэлэх боломжгүй (NA). Монгол дахь тархац нутгийн хэмжээ нь манай улсын нийт нутаг дэвсгэрийн нэгээс бага хувийг эзэлдэг. Хар мөрний цариг могойг Монголд 1983 онд Хянганы нурууны баруун хэсэг, Нөмрөгийн голын савд ус гаталж явахыг ганцхан удаа л ажиглажээ (Боркин и др., 1990; Ананьева и др., 1997). Судалгааны дээж хараахан цуглуулаагүй. Энэ зүйлийн Монгол дахь тархан амьдрах талбайн хэмжээг 823 орчим км<sup>2</sup> гэж үнэлсэн.

**Үнэлгээ хийсэн:** П.Эрдэнэтүшиг, М.Мөнхбаатар, Г.Онолрагчаа (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, Х.Тэрбиш, П.Золжаргал, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Орос (Амар мөрөн, Приморын хязгаар), Хятадын төв болон умард нутаг (Жехол, Хопей, Шанси), Монголын дорнод нутаг, Солонгосын хойгт тархсан (Uetz *et al.*, 2021).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Их Хянганы уулс, Нөмрөг, Дэгээ голын сав дагуу ойт хээр (1.4), уулын хээр (3.4; 4.4), нугаар (5.1; 5.3) нутагших боломжтой (Мөнхбаяр, Тэрбиш, 1997; Terbish *et al.*, 2006). Монгол оронд далайн түвшнээс дээш 500-1,000 м өндөрт тохиолдоно (Ананьева и др., 1997).



**Амьдралын онцлог.** Ойн цоорхой, зах, бут сөөг, ургамал ихтэй газар модны хонгил, хөндий, хожуул, дархи дор чийглэг орчин шүтэн амьдарна. Гадаад орнуудад хүний сууринтай ойр тохиолдох нь элбэг. Өдрийн идэвхтэй, усанд сайн сэлдэг, хоргүй могой. Бах, мэлхий, мэрэгч, жижиг шувууд болон тэдгээрийн өндгөөр хооллоно. 9-10-р сард ичээлж, 4-р сард ичээнээс гарч үржилд орно. 11-30 өндөг гаргана. Зогойнууд 2-3

дахь жилдээ бие гүйцнэ. Мэрэгчдийн нүх, хад чулууны ан цав, мод, хожуулын хонгил, хөндий, дархи, чулуун дор, чулуун хашаа, байшингийн завсар, хонгилд орогноно. Гол дайсан нь махчин шувууд, зараа, үнэг, хярс зэрэг хөхтөн амьтад болно (Ананьева и др., 1997).

**Тоо толгой, нягтшил.** Энэ талаарх мэдээ, баримт хомс.

**Ховордлын шалтгаан.** Энэ зүйлийн ховордлын шалтгаан хараахан тодорхойгүй.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн ихэнх хэсэг Нөмрөгийн дархан цаазат газар хамрагджээ.

#### Хамгаалах арга хэмжээ

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Үнэлэх боломжгүй” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах үндэсний эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 4.6. СУМ МОГОЙ

### *Psammophis lineolatus* (Brandt, 1838)

**Баг:** Хайрстан (Squamata), Могойн салбар баг (Serpentes)

**Овог:** Нарийн могойн овог (Colubridae)

**Англи нэр:** Steppe Ribbon Snake

**Ижил нэр:** *Coluber* (*Taphrometopon*) *lineolatus* (Brandt, 1836); *Coluber caspius* (Lichtenstein, 1823); *Chorisodon sibericum* (Dumeril and Bibron, 1854); *Taphrometopon lineolatum* (Boulenger, 1896); *Psammophis triticeus* (Wall, 1912).



**Ангилал зүйн тойм.** Өргөн тархалттай, монотип зүйл.

**Таних шинж.** Бие нарийн, урт нь 91 см. Сүүл нь их биеийн уртаас 2.5-3.5 дахин богино. Хоншоорын дээд тал тууш ховилтой. Духны болон шанааны хайрс нэг, нүдний арын хайрс нүдэнд хамаарсан. Биеийн нуруун тал цайвар шаргал, цайвар хүрэн өнгөтэй. Толгойн бамбай хайрс орчмоос эхлэн биеийн тууш дагуу үргэлжилсэн 4 бараан судалтай. Хэвлийн өмнөд хэсэг шаргал

дэвсгэртэй, түүн дээр хүрэвтэр эсвэл саарал өнгийн толботой (Мөнхбаяр, Тэрбиш 2010).

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish *et al.*, 2006a). 2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам ч тоо толгой, нягтшил сийрэг зүйл. Популяцийн тоо толгой буураагүй гэж үнэлсэн тул дээрх үнэлгээг


хэвээр үлдээв.

**Үнэлгээ хийсэн:** М.Мөнхбаатар, П.Эрдэнэтүшиг, Ж.Гүррагчаа (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, Х.Тэрбиш, П.Золжаргал, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Иран, Азарбайжан, Казахстаны зүүн өмнөд нутаг, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Киргизстан, Монгол, Хятадын баруун хойд нутагт (Гансу, Нингхиа, Шинжаан) тархсан (Uetz *et al.*, 2006; Terbish *et al.*, 2006a).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Алтайн Өвөр говь, Говь Алтайн нуруу, Зүүнгарын говь, Алашаа говь, Умард говь, Дорнод говь зэрэг нутгийн цөл, цөлөрхөг хээрээр тархана (Мөнхбаяр, Тэрбиш, 1997; Terbish *et al.*, 2006a). Алтайн Өвөр говийн хуурай цөлийн дэд бүс дэх Эхийн голын баянбүрдэд тэмдэглэгдсэн (Семенов и Боркин, 1992).



**Амьдралын онцлог.** Сум могой нь уулын хад асга (6), бутлаг ургамал бүхий сайр, садарга (3.4; 4.4), хайргат болон элсэн цөл (8.2; 8.3), говийн баянбүрдээр тохиолдоно. Жижиг гүрвэл, шавжаар хооллоно. Маш хурдан шалмаг хөдөлгөөнтэй могой. Хүнд хор хөнөөлгүй.

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Түлээ, түлшний хэрэгцээний мод бутыг түүх, ургамлыг хэт ашигласнаас (1.3.4) түүний амьдрах орчныг хомсдолд оруулж байна. Мөн уул уурхайн үйлдвэрлэлийн (1.3.1) улмаас амьдрах орчин доройтох нь энэ зүйлийн тоо толгой буурах нэг шалтгаан болно. Махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2; 8.3), ган (7.1), зуд (7.3), хүчтэй шороон шуурга, үер (7.2) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр энэ зүйлийн тоо толгой буурах магадлал өндөр.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Говийн Их дархан цаазат газрын “А”, “Б” хэсэг, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар, Говийн Бага дархан цаазат газрын “А”, “Б” хэсэгт хамрагджээ.

#### Хамгаалах арга хэмжээ

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийгэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 4.7. БАМБАЙ ХОНШООРТ МОГОЙ

### *Gloydius halys* (Pallas, 1776)

**Баг:** Хайрстан (Squamata), Могойн салбар баг (Serpentes)

**Овог:** Загалмайт могой (Viperidae)

**Англи нэр:** Halys Pit Viper

**Ижил нэр:** *Ancistrodon halys* (Nikolsky, 1916); *Agkistrodon halys* (Pallas, 1776); Asian Viper.



**Ангилал зүйн тойм.** Политип зүйл. Энэ зүйл нийт 5 салбар зүйлтэй бөгөөд түүнээс Монголд *G. h. Halys* болон *G. h. caraganus* гэсэн 2 салбар зүйл бий (Анаьева и др., 1997).

**Таних шинж.** Их биеийн урт 70 см. Сүүл нь их биеийнхээ уртаас 5.5-8.4 дахин богино. Нурууны хайрс 23. Хэвлийн хайрс 143-187. Төгсгөлийн сүвний бамбай хайрс 7-8. Нүд, хамрын сүвний хооронд гүнзгий хонхортой тул зэрвэс ажиглахад хамрын 4 сүвтэй мэт харагдах нь бий. Нуруу ба сүүлийн дагуу хөндлөн бараан толботой. Энэ толбоны зах нь тод хар боловч голдоо цайвар. Биеийн хоёр хажуугаар тууш эгнээ жижиг бараан толботой. Биеийн ерөнхий зүс их төлөв хул шарга эсвэл хар хүрэн. Гэвч биеийн зүс маш хувьсамтгай. Тухайлбал, ой мод

бүхий нутгийнх ихэвчлэн тод хар хүрэн, говь цөлийнх цайвар юм уу бор шарга.

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Terbish *et al.*, 2006a; Terbish *et al.*, 2006b).


2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой, нягтшил сийрэг зүйл бөгөөд түүний популяцийн тоо толгой буураагүй гэж үнэлсэн тул дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Үнэлгээ хийсэн:** П.Золжаргал, Х.Тэрбиш (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, М.Мөнхбаатар, М.Бүрнээ, С.Гомбоаатар (2025).

**Дэлхийн тархац.** Оросын өмнөд болон зүүн өмнөд хэсэг, Ираны умард нутаг, Казахстан (Волга мөрнөөс Урал мөрний хооронд), Узбекистан, Афганистаны зүүн нутаг, Тажикстан, Киргизстан, Хятад, Монгол, Туркменистанд тархсан (Uetz *et al.*, 2006; Terbish *et al.*, 2006a).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол орны говь цөл (8.2), уулын хээр (3.4; 4.4), ойт хээр (1.4), ой хөвч (1.1) зэрэг байгалийн үндсэн бүс, бүслүүрт өргөн тархсан (Мөнхбаяр, Тэрбиш, 1997; Terbish *et al.*, 2006). Дархадын хотгор, Монгол Алтайн нурууны Алтай Таван Богд орчмын нутгаас бусад бүх нутгаас тэмдэглэжээ (Мөнхбаяр, Тэрбиш, 1997). Монгол оронд далайн түвшнээс дээш 600-3,100 м өндөрт тохиолдоно (Боркин и др., 1990).



**Амьдралын онцлог.** Хад асга, хайрга, бутат цөл, тал хээр, говь, ойн цоорхой, голын эрэг орчим, нуга намаг зэрэг янз бүрийн нөхцөлд оршин амьдарна. Мэрэгчдийн нүх, мод, хад чулууны хонгил, хөндийд орогноно. Ихэвчлэн мэрэгч амьтад, хааяа жижиг шувууд, гүрвэлээр хооллоно. Энэ могой манай оронд хаана ч элбэг тохиолдох учир цэцэг, жимс, мөөг түүх, мод чулуу хураах, өвс хадах үед анхаарал болгоомжтой ажиллах хэрэгтэй (Мөнхбаяр нар, 2023).

**Тоо толгой, нягтшил.** Монгол орон даяар популяцийн хэмжээний мэдээлэл тодорхойгүй.

**Ховордлын шалтгаан.** Янз бүрийн биотопыг хамарсан өргөн уудам тархацтай учраас ховордлын шалтгаан төдий хэмжээгээр

олон янз байна. Тухайлбал, хот суурин газрын тэлэлт (1.2.4), ашигт малтмалын олборлолт (1.3.1), зам, тээвэр (1.4.4), түймэр (7.4), орчны бохирдол (6.2; 6.3), ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (7.1), хүний төрөл бүрийн үйл ажиллагааны нөлөөгөөр амьдрах орчин доройтох (1) нь энэ могойн тархац нутгийг хумьж, амьдрах орчны чанар байдлыг доройтуулах, тоо толгойг бууруулах үндсэн хүчин зүйлс болно. Махан идэшт амьтдын тоо толгойн өсөлт (8.2; 8.3), ган (7.1), зуд (7.3), хүчтэй шороон шуурга, үер (7.2) зэрэг байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр энэ зүйлийн тоо толгой буурах магадлал өндөр (Terbish *et al.*, 2006a).

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (Terbish *et al.*, 2006; UNEP-WCMC, 2006; Мөнхбаяр нар, 2023).

#### Хамгаалах арга хэмжээ

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2)
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 4.8. ДОРНОДЫН БАМБАЙ ХОНШООРТ МОГОЙ

### *Gloydus ussuriensis* (Emelianov, 1929)

**Баг:** Хайрстан (Squamata), Могойн салбар баг (Serpentes)

**Овог:** Загалмайт могой (Viperidae)

**Англи нэр:** Ussuri Pit Viper

**Ижил нэр:** Уссурийн бамбай хоншоорт; *Ancistrodon blomhoffi ussuriensis* (Emelianov, 1929); Ussuri mamushi.



**Ангилал зүйн тойм.** Монотип. Амьдрах орчноос хамааран олон янзын өнгөний хэлбэр тохиолдох боловч тэдгээр нь ангилал зүйн хувьд ач холбогдолгүй.

**Таних шинж.** Эр бодгалийн их биеийн урт нь 37-63 см, харин эмийнх 41-64.7 см. Сүүл нь их биеийнхээ уртаас 12-17 дахин богино. Нурууны хайрс 21. Хэвлийн хайрс 146-157, сүүлэн доорх хайрс 39-54, төгсгөлийн сүвний бамбай хайрс 7. Өнгөний олон шинжтэй

бөгөөд цайвар хүрэн, саарлаас хар хүрэн, газрын өнгөтэй адил. Нурууны толбо 24-33 харьцангуй том зууван хэлбэртэй толбо бүхий цайвар хүрэн саарлаас хар хүрэн. Эдгээр толбо нь биеийн дунд талын шугамын хоёр талд эсрэг буюу ээлжлэн орших ба ихэвчлэн битүү бөгөөд голд нь бараан толботой цайвар дотортой байдаг нь биеийн хоёр талдаа бухын нүд мэт харагдуулна (Gloyd and Conant, 1990).

### Үнэлгээ ба үндэслэл

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023).

**Бүс нутгийн үнэлгээ:** 2006 онд Үнэлгээ хийгээгүй.

2025 онд Үнэлэх боломжгүй (NA). Энэ зүйл Монгол оронд ганцхан цэгт тэмдэглэгдсэн, түүний популяцийн талаарх судалгааны мэдээ, баримт хомс.

**Үнэлгээ хийсэн:** П.Золжаргал, М.Мөнхбаатар (2025).

**Үнэлгээг хянасан:** Х.Мөнхбаяр, М.Бүрнээ, С.Гомбобаатар (2025).

**Дэлхийн тархац.** Хятадын зүүн хойд хэсэг Ляониноос Хар мөрөн хүртэл, Оросын Алс Дорнод (Приморский, Хабаровскийн хязгаарт), өмнөд Сибирь (Чита муж), түүнчлэн зэргэлдээх Монголын хойд хэсэг (Kropachev *et al.*, 2016), Солонгосын хойг хүртэл нэлээд өргөн тархсан (Zhao and Adler, 1993).

**Монгол орны тархац, амьдрах орчин.** Монгол оронд Нөмрөгийн сав газраас тэмдэглэсэн (Kropachev *et al.*, 2016).



**Амьдралын онцлог.** Тэгш тал, нам дор газрын толгодоор тохиолдоно. Ойт хээр (1.4), хээрийн ургамлан бүрхэвчтэй, бут сөөг, чулуурхаг (3.4; 4.4) газарт орогноно. Жижиг мэрэгчид, мэлхий, шавж, загасаар хооллох ба хааяа могой, гүрвэл иднэ (Zhao, 2006).

Энэ зүйл нь 2-6 амьд зулзага төрүүлдэг.

**Тоо толгой, нягтшил.** Энэ талаарх мэдээ, баримт байхгүй.

**Ховордлын шалтгаан.** Энэ зүйлийн ховордлын шалтгаан хараахан тодорхойгүй.

**Хамгаалсан байдал.** Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл амьтны аймагт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг бүхэлдээ Нөмрөгийн дархан цаазат газрын нутаг дэвсгэрт хамаарна.

### Хамгаалах арга хэмжээ

- Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Үнэлэх боломжгүй” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг үндэсний бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2)
- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн онцлог (3.3), түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Мөлхөгчдийн хамгаалалд зориулсан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж (4.4.1; 4.4.2; 4.4.3), биологи, экологийн (3.3) судалгаа явуулах
- Энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

## 4.9. ЭГЭЛ ЗАГАЛМАЙТ МОГОЙ

### *Vipera berus* (Linnaeus, 1758)

**Баг:** Хайрстан (Squamata), Могойн салбар баг (Serpentes)

**Овог:** Загалмайт могой (Viperidae)

**Англи нэр:** Adder

**Ижил нэр:** *Coluber berus* (Linnaeus, 1758); *Vipera nikalskii* (Vedmederya, Grubant and Rudajewa, 1986); *Vipera sachalinensis* (Zarevsky, 1917); Northern Viper.



**Ангилал зүйн тойм.** Политип зүйл. Эгэл загалмайт могойн 3 салбар зүйлээс Монголд *V. berus berus* хэмээх эх салбар зүйл тархжээ.

**Таних шинж.** Их биеийн урт 74 см. Нурууны нэг эгнээний хайрс 19. Хэвлийн хайрс эрд 132-151, эмд 140-156. Төгсгөлийн сүвний бамбай хайрс нэг. Хамрын сүв хамрын хайрсны яг голд нь байрлана. Их бие цайвар эсвэл хар хүрэн зүстэй, нуруун дагуу тахирласан бор, бор хүрэн судал дагзнаас сүүлний бараг шувтрах үзүүр хүртэл үргэлжилнэ. Нүднээс завж хүрсэн хар судал байдгаараа онцлог. Толгойн дээр хэрээс хэлбэрийн бараан хээтэй. Хэвэл нь цайвар хүрэн юм уу хар толботой. Залуу бодгалиуд улаан хүрэн ба хилэн хар өнгийн бие гүйцсэн могойнууд тохиолдоно. Сүүлний үзүүр цайвар шар эсвэл улбар шарга.

**Үнэлгээ ба үндэслэл**

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй (LC).


